



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ



JAPAN GOV  
THE GOVERNMENT OF JAPAN



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Save the Children





БОЛОВСРОЛЫН  
ЯАМ



JAPAN GOV  
THE GOVERNMENT OF JAPAN



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Save the Children

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип  
боловсрол олгох” төсөл (2019-2025)

“Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills For The Most Vulnerable  
Youth In Rural Mongolia” project (2019-2025)

# ЭНТРЕПРЕНЕР ЭХЛЭЛ

---

## BECOMING AN ENTREPRENEUR

Харилцан суралцаж, хамтдаа бүтээсэн түүхүүд

Stories created through mutual learning

Улаанбаатар хот 2025

Ulaanbaatar 2025

# ГАРЧИГ/ CONTENTS

## ЭНТРЕПРЕНЕР ЭХЛЭЛ/ BECOMING AN ENTREPRENEUR

Харилцан суралцаж, хамтдаа бүтээсэн түүхүүд/ Stories created through mutual learning

Зөвлөх: Ё.Нямдаваа, Т.Гантунгалаг  
Редактор: Ч.Батпүрэв, Э.Соёл-Эрдэнэ  
Орчуулгын редактор: Жули Питцен  
Орчуулагч: Ч.Сансар  
Дизайнер: Л.Лхагвачимэг

Зохиогчийн эрх © Хүүхдийг Ивээх Сан 2025

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,  
Аризона төвийн 4-р давхар  
Утас: 11329365, 11329371

Consultant: Yo. Nyamdavaa, T. Gantungalag  
Editor: Ch. Batpurev, E. Soyol-Erdene  
Translation editor: Julie Pitzen  
Translator: Ch. Sansar  
Layout designer: L. Lkhagvachimeg

Copyright © Save the Children 2025

Address: Ulaanbaatar city, Chingeltei district,  
1st khoroo, 4th floor of Arizona Center  
Phone: 11329365, 11329371

## ӨМНӨХ ҮГ/ FOREWORD

5-6

## БҮЛЭГ 1/ CHAPTER 1

7

### ESEL СУРГАЛТ / ESEL TRAINING

7

|   |    |
|---|----|
| Би-гээс бид болсон миний түүх                                 | 8  |
| My Story: From “I” to “We”                                    | 8  |
| Хүсэл тэмүүлээ нэгтгэсэн “Мөрөөдлийн хөтөч”-ийнхэн            | 11 |
| “Dream Guide” Club: Driven by Passion                         | 11 |
| Хамтын шийдэл бас хосолсон сургалт                            | 14 |
| Collaborative solution and Blended Learning                   | 14 |
| Хүртээмжтэй сургалт, үр дүнтэй удирдлага                      | 18 |
| Accessible Training and Efficient Management                  | 18 |
| ESEL хөтөлбөрийн чиглүүлэгч, энтрепренер клубийн зөвлөх       | 20 |
| ESEL Program Facilitator and Advisor of the Entrepreneur Club | 20 |
| Хосолсон сургалт хөгжүүлэгч                                   | 24 |
| Developing a Blended Learning Model for Rural Communities     | 24 |
| Малчин залуусын бэлчээр, танхим хослуулсан сургалт            | 27 |
| Integrating Pasture With Classroom Learning                   | 27 |
| ESEL сургалтаас эхтэй эерэг өөрчлөлтүүд                       | 31 |
| Positive Changes Resulting From ESEL Training                 | 31 |
| Уйрагүй оролдлого, чин сэтгэл, хамтын зүтгэл амжилтад хүргэв  | 34 |
| Tireless Effort, Dedication, and Teamwork Leads to Success    | 34 |
| Мөрөөдөл, зорилго нэгтэй энтрепренер клубийнхэн               | 39 |
| Entrepreneur Club Members Uniting Dreams, and Goals           | 39 |

## БҮЛЭГ 2 / CHAPTER 2

45

### ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР / SMALL GRANT PROGRAMS

45

|  |    |
|--|----|
| Эрвээхий “нисэлдсэн” хүслийн өргөө                           | 46 |
| Butterflies Will Make You Feel Free and Live Your Dreams     | 46 |
| Бүтээлч сэтгэлгээтэй хүүхдүүд                                | 50 |
| Children with creative minds                                 | 50 |
| Утсаар биш урд урдаасаа харж нөхөрлөө                        | 55 |
| Building Friendships Face to Face, Beyond Smartphone Screens | 55 |
| Мөрөөдөл биелж, ирээдүй тодорсон эхлэл                       | 59 |

|   |    |
|---|----|
| Turning Dreams into Reality and Making Future Plans Clearer | 59 |
| Тэвчээр, төвлөрөл олгох үндэсний спорт                      | 64 |
| A National Sport That Develops Endurance and Concentration  | 64 |
| “Сурагчийн шүүгээ” төсөл хүнд ачаанаас салгав               | 68 |
| “Student Locker” Project Lightens the Load                  | 68 |
| “Тоорхон” багийн тогооч хүүхдүүд                            | 74 |
| Young Cooks of the ‘Toorkhon’ Team                          | 75 |

### БҮЛЭГ 3/ Chapter 3

#### ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ / COLLABORATION AND SUPPORT

|  |     |
|--|-----|
| Говьсүмбэрийнхэн аймгаараа хамтардаг                                     | 80  |
| The People of Gobisumber Collaborate to Overcome Challenges              | 80  |
| Санхүүгийн боловсролын хөтөч   | 84  |
| Financial Education Guide  | 84  |
| Өглөөний цайны соёл түгээх санаачилга                                    | 87  |
| Initiative to Cultivate a Breakfast Culture                              | 87  |
| Зорилгод чиглүүлэгч, амжилтын хөшүүрэг буюу бизнес көүч                  | 93  |
| Business Coach: Steering Towards Goals, Optimizing Achievements          | 93  |
| Амжилтад хөтөлсөн хамтын ажиллагаа                                       | 98  |
| Collaboration for Success  | 98  |
| Эрүүл хүнс тариалдаг Эко сургуулийнхан                                   | 102 |
| Eco School Students Grow Healthy Food                                    | 102 |
| Дэлхийд гаргах замын “инженер”   | 106 |
| Local “Engineers” Paving the Road to the World                           | 106 |
| Энтерпрайзаа сургалтын хөтөлбөртэй холбосон “Үйлдвэрлэгч хүүхдүүд”       | 109 |
| “Child Producers”: Integrating the Enterprise into the School Curriculum | 109 |
| Эргэх холбоог бэхжүүлэгч   | 114 |
| Rebuilding Connections: Pathways for Growth and Empowerment              | 114 |
| Шинийг эрэлхийлж, зорилгодоо тэмүүлэгч                                   | 117 |
| Seeking New Opportunities and Achieving Goals                            | 117 |
| Зөвлөн чиглүүлэгч, сэтгэл зүйн “дасгалжуулагч”                           | 120 |
| Counselor and Psychological “Coach”                                      | 120 |
| Хөгжилд тэмүүлэх урам зориг өгсөн “Хөгжлийн хөтөч” төв                   | 124 |
| “Development Guide” Center: Inspiring Growth                             | 124 |
| Зорилгоо тодорхойлсон ментор   | 128 |
| A Mentor With Clear Goals  | 128 |

### ТАЛАРХАЛ/ ACKNOWLEDGEMENT

132



Л.Баян-Алтай  
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь  
Суурин төлөөлөгч

L.Bayan-Altai  
Country Manager and Representative, Save the  
Children Japan in Mongolia

## ӨМНӨХ ҮГ

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан 21 дүгээр зууны иргэнд нэн хэрэгцээтэй хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох өвөрмөц, сонирхолтой төслийг амжилттай хэрэгжүүлээ. Энэ бол Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сангийн 2.75 сая ам.долларын буцалтгүй тусламжаар 2019-2025 онд Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн 29 суманд хэрэгжсэн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл юм.

Төслөөр нийт 8773 хүүхэд, залуусыг “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” (ESEL) сургалтад хамрууллаа. Эдгээр хүүхэд, залуус баг бүрдүүлж, нийт 360 бичил төсөл хэрэгжүүлж, тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг авсан байна. Түүнчлэн төслийн явцад сурагчдаас гадна сургуулийн багш, удирдлагууд, төслийн аймаг, сумын зөвлөлийн гишүүд зэрэг бүх оролцогч талууд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсролоо хамтдаа дээшлүүлжээ.

Эдгээр зорилтот таван аймгийн зургаан сумын ерөнхий боловсролын сургууль

## FOREWORD

Save the Children Mongolia has successfully implemented a distinctive and engaging project aimed at equipping young people with vital personal and entrepreneurial skills for the 21st century. The project, titled “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia,” has been carried out in 29 soums across Khovd, Zavkhan, Uvurkhangai, Gobisumber, and Sukhbaatar provinces from 2019 to 2025. This initiative is supported by a \$2.75 million grant from the Japan Social Development Fund, a World Bank Trust Fund.

The project engaged 8,773 children and youth in the “Entrepreneurship-based Socio-Emotional Skills” (ESEL) training. These participants formed teams, implemented a total of 360 subgrant projects, and received over a billion MNT in funding. Additionally, throughout the project, all stakeholders—including students, teachers, authorities, and members of the project’s Aimag and Soum Level Counsels—worked together to enhance their personal skills and entrepreneurship education.

General secondary schools from each of the six target soums, across five target aimags,



“Сургуульд суурилсан энтерпрайз”-ийг нийт 600 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Энэ бол сурагчид сургуулийн орчинд бизнес эрхлэх, ашгийн төлөө бус, энтрепренер сэтгэлгээ, үр чадвараа хөгжүүлэх цогц үйл ажиллагаа гэдгийг дурдахад таатай байна. Тус сургуулиудад багш, сурагчдын хамтын ажиллагаа өргөжиж, тэдний бизнесийн мэдлэг, үр чадвар сайжрахын зэрэгцээ үйлдвэрлэлээ сургалтын хөтөлбөртэй уялдуулж, дадлага хийнгээ орлого олдог зэрэг олон давуу тал бий болжээ.

Мөн хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох шинэлэг, оролцоонд тулгуурласан, төсөлд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн үндсэн судлагдахууны нэг болгосон нь бодит дэвшил байлаа. Үүнээс гадна аймгууд орон нутгийн үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгах, хэрэгжүүлэх зардлыг төсөвт багтаах, бизнесийн байгууллагуудтай хамтрах, тэднээс дэмжлэг авах зэргээр төслөө зорилтот аймаг, сум, цаашилбал үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг хангах стратеги боловсруулан гаргалаа.

Бид хамтдаа өнгөрсөн хугацаанд олон гайхалтай түүх бүтээжээ. Та бүхэнд ололт, туршлагуудаа хуваалцсан эдгээр амжилтуудаас түүвэрлэн, монгол, англи хэлээр хүргэж байна.

Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхэд өөрсдийн сэтгэл зүтгэл, оюун ухаанаа харамгүй зориулсан бүхий л талуудад гүн талархал илэрхийлье.

are implementing the “School-Based Enterprise” initiative, with a total investment of over 600 million MNT. I am pleased to highlight that this is a comprehensive, non-profit activity, designed to allow students to run businesses within the school environment, and help them develop their entrepreneurial mindset and skills. As a result of this project, collaboration between teachers and students has increased, business knowledge and skills have improved, production has been integrated into the school curriculum, and income generation through business activities has been fostered.

It also marked a significant step forward in developing an innovative, participatory, project-based curriculum for personal skills and entrepreneurship education, making it a core component of the Vocational Education Curriculum. Furthermore, aimags have crafted strategies to promote the project at the provincial, soum, and national levels, and to ensure its sustainability by integrating it into local action plans, budgeting implementation costs at the local level, and collaborating with and receiving support from business entities.

We have created many remarkable stories together in the past. We are pleased to share with you a selection of successes, showcasing our achievements and best practices, in both Mongolian and English.

We would like to extend our deepest gratitude to all those who have contributed their time, effort, and expertise to the success of this project.



## ESEL СУРГАЛТ | ESEL TRAINING



## БИ-ГЭЭС БИД БОЛСОН МИНИЙ ТҮҮХ

### MY STORY: FROM "I" TO "WE"

Намайг Э.Хоролням гэдэг. Би 18 настай. Малчин айлд төрж, өссөн. 2019 онд Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багийн ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийг төгсөөд Өвөрхангай аймгийн Политехникийн коллежид үг, дуу цөөтэй, нийгмийн идэвхгүй, бүрэг ичимтгий охин элсэн орж байлаа.

Хүний амьдралд алдаж болохгүй боломж тийм ч олон гардаггүй. Надад тохиосон нэг боломж бол Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлсэн "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төслийн хөтөлбөрт сонгогдон, хамрагдсан явдал юм. Энэ хөтөлбөр Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд анх удаа, тэр тусмаа манай сургуульд хэрэгжихээр болсон таатай мэдээг ангийн багшаасаа сонсож, бүртгүүлэн сургалтад хамрагдсан билээ. Маш олон хүүхэд хамрагдахыг хүсэж байсан учраас би өөрийгөө тэнцэнэ гэж бодоогүй. Удалгүй сургалтад хамрагдах 20 хүүхдийн нэг болсноо сонсоод маш их баярласан. ESEL хөтөлбөрийн 8 долоо хоногийн хөтөлбөрт амжилттай суралцан төгсөж, гэрчилгээ гардаж аваад сэтгэл маш их догдолж байлаа.

Би багаар ажиллах чадварт маш сайн суралцсан. Өмнө нь багаар биш ганцаараа тэмцээнд бэлдэж, ганцаараа оролцдог байсан болохоор сургалтын эхний долоо хоногт өөрийнхөө багаар ажиллах чадвар

My name is E. Khorolnyam, and I am 18 years old. I was born and raised in a herder family. I was a very quiet, socially reserved, and shy girl when I graduated in 2019 from the 9th grade at the general secondary school in Jargalant Bagh, Uyanga soum, Uvurkhangaï province, and enrolled in the Polytechnic College of Uvurkhangaï province.

There are few opportunities in life that should be missed, and one such opportunity that came my way was being selected for the "Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia" project, implemented by Save the Children. I was thrilled to hear from my class teacher that this project would be launched for the first time in Arvaikheer soum, Uvurkhangaï province, and that it would take place specifically at my school. Excited, I registered and participated in the training. At first, I didn't think I would be selected, as so many children were eager to join. So, when I found out that I was one of the 20 chosen participants, I was overjoyed. I felt immense pride when I successfully completed the 8-week ESEL program and received my certificate.

I learned the importance of teamwork. Previously, I had always prepared for and participated in competitions on my own, not as part of a team. As a result, I quickly realized my lack of teamwork skills during the first week of training. In this project, each team member took on their responsibilities, listened attentively to one another, respected each other's opinions, and together, we created lasting memories throughout the training.

I was honored to be invited to participate in and deliver a speech at the opening of the "Experience-sharing workshop of Polytechnic colleges and TVET schools implementing the ESEL program" in Ulaanbaatar last January.

дутмаг байгааг ойлгосон. Багийн гишүүн бүр үүрэг хариуцлагаа тухай бүрд нь биелүүлж, бусдыг хүлээцтэй сонсож, үзэл бодлыг нь хүндэтгэж, сургалт бүр дээр хамтдаа гоё дурсамжууд бүтээж чадсан юм. Би өнгөрсөн нэгдүгээр сард Улаанбаатар хотод "ESEL хөтөлбөр хэрэгжүүлж буй Политехник коллеж, МСҮТ-үүдийн туршлага солилцох семинар"-т уригдан оролцож, нээлтэд нь үг хэлсэндээ баяртай байдаг. Би эдүгээ Өвөрхангай аймгийн "Өвлэйв" мэдээллийн сайтад ажиллаж байна. Мөрөөдөл маань нэвтрүүлэгч болох юм. Телевизийн хөтөлгч, нэвтрүүлэгчдийг хараад би ийм мэргэжилтэй хүн болно гэж шийдсэн. Мөрөөдлөө биелүүлэхээр алхам алхмаар, эрч хүчтэй урагшилж байгаа. Цаашид өөрийгөө хөгжүүлж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Олж авсан мэдлэг, ур чадвартаа тулгуурлан шинэлэг санаагаа төсөл болгон бичиж, шалгуурт нийцвэл бичил санхүүжилт авч гарааны бизнес эхлүүлэх боломж олгож буй энэ хөтөлбөр бидэнд бодитой өөрчлөлт авчирсан. Анх төсөлд хамрагдаж байх үед би санхүүгийн мэдлэггүй, хувийн зохион байгуулалтгүй, бүр цаашлаад өөрийнхөө болон хамт суралцаж байгаа үе тэнгийн найз нөхөд, дүү нарынхаа сэтгэл зүйн онцлогийн талаар ч мэддэггүй байлаа. Үүнээс болоод үл ойлголцох, хийж байгаа зүйлээ буруу тооцоолох гэх мэтийн олон бэрхшээлтэй тулгарч байсан.

Эдгээрийг шийдвэрлэхэд сургагч багш нар маань их туслалцаа үзүүлсэн. Манай найзууд хүүхэд бүр өөрийгөө илэрхийлэх, асуудлаа шийдвэрлэх чадвартай байх хэрэгтэй гэж өдөр өдрийн хичээлүүдтэй холбож, өөрсдийн алдаа болон давуу



Э.Хоролням, Өвөрхангай аймгийн Политехникийн коллежийн сурагч, ESEL хөтөлбөрийн төгсөгч

E. Khorolnyam, student of Uvurkhangaï Polytechnic College, graduate of the ESEL program

Currently, I work at the "Uvlive" news site in Uvurkhangaï province. My dream is to become a TV anchor. Inspired by television anchors and newscasters, I decided that I, too, would pursue this profession. Step by step, I am moving forward with energy and determination to fulfill my dream. I am confident that I will continue to grow and develop in the future.

This project has brought about real change, offering us the opportunity to transform our innovative ideas into a project proposal based on the knowledge and skills we've gained. If we meet the criteria, we can receive a subgrant to launch a startup business.

When I first joined the project, I had little knowledge of financial literacy, personal organization, or even the psychological traits of myself, my peers, and my siblings. As a result, I faced many challenges, such as misunderstandings and making poor decisions. However, our trainers provided invaluable support,



талуудаа олж, түүндээ тулгуурлан төслөө бичдэг болсон. Бас өөрсдийн бичсэн төслөө бусдын өмнө зөвөөр илэрхийлж сурсан.

Бид багаараа “Dream party” төслөө амжилттай хэрэгжүүлж байна. Цаашид аймгийн хэмжээнд зарлагдах том, жижиг төсөл, хөтөлбөрүүдэд оролцоно, төслөө улам өргөжүүлж, хувийн компани байгуулна гэсэн том зорилго тавьсан байгаа. “Томоор мөрөөд, жижгээр эхэл, гэхдээ хамгийн чухлаас нь эхэл” гэж Саймон Синекийн хэлсэн үгэнд дуртай.

Авьяасгүй хүн гэж байдаггүй, харин айдас, эргэлзээгээ даван туулах чадваргүй хүн л байдаг гэж боддог. Би өмнө нь аймхай, түүнийгээ “ичимхий” гэдэг үгээр далдалдаг байсан болохоор шинэ сургууль, шинэ орчинд энэ дутагдлаа бага багаар засаж чадсан минь амжилтын эхлэл болсон.

**Үеийн найзууд, дүү нартаа хандаж хэлэхэд, үзэл бодолдоо үнэнч байж, зорилгодоо хүрэхийн төлөө хичээдэг, тохиолдож буй бэрхшээлийг даван туулах зоригтой, тууштай байгаарай гэж захъя. Харилцан суръя, хамтдаа бүтээе!**

2023 онд хэвлэгдсэн

helping me overcome these issues.

Our friends, believing that every child should be able to express themselves and solve problems, learned to integrate this principle into their daily lessons. They identified their own mistakes and strengths and used them to write their project proposals. Additionally, they learned how to effectively present their proposals to others.

We are successfully implementing our “Dream Party” project as a team. We’ve set an ambitious goal to participate in both large and small projects and programs announced at the provincial level in the future, with the aim of expanding our project and eventually establishing a private company. I love the quote by Simon Sinek: “Dream big, start small, but start with what matters most.” I believe there are no untalented people—only those who haven’t yet overcome their fears and doubts. I used to be timid, often hiding behind the word “shy.” However, gradually overcoming this limitation in a new school and environment was the beginning of my success.

**To my peers and younger children, I urge you to stay true to your beliefs, pursue your goals with determination, and be courageous and persistent in overcoming the challenges you encounter. Let’s learn from one another and create together!**

Published in 2023



ESEL хөтөлбөрийн тухай амжилтын түүхүүдийг монгол хэлээр уншина уу.

Read the article about the ESEL training in Mongolian.

## ХҮСЭЛ ТЭМҮҮЛЛЭЭ НЭГТГЭСЭН “МӨРӨӨДЛИЙН ХӨТӨЧ”-ИЙНХЭН

### “DREAM GUIDE” CLUB: DRIVEN BY PASSION

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд таван аймгийн зорилтот сумдад 41 энтрепренер клуб ажиллаж байгаагийн нэг нь Ховд аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн “Мөрөөдлийн хөтөч” энтрепренер клуб юм. Тус клубийн гишүүд бол “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” сургалт төгсөж, хүсэл тэмүүлээрээ нэгдсэн олон арван сурагчдын төлөөлөл билээ. “Мөрөөдлийн хөтөч” клуб 8-12 дугаар ангийн 15 гишүүнтэй, ахлагч нь Х.Билэгдэмбэрэл, менежментийн багийн ахлагч нь Г.Гантогтох нар юм. Эдгээр сурагчид найз нөхдөдөө тусалж, тэднийг хүсэл мөрөөдөлдөө хүрэхэд нь хөтлөн замчилна гэж энэ нэрийг өгчээ.

Тэд сар тутам хоёр удаа уулзаж, гишүүн бүр шинэ санаа хэлж, хамтдаа хэлэлцэн, хамгийн их санал авсан ажлуудаа төлөвлөдөг байна.

2023 оны 10 дугаар сард өөрсдийн суралцдаг нэгдүгээр сургууль болон “Минжит булган” цогцолбор сургуулийн “ZET” энтрепренер клубтэй хамтран суманд хэрэгжиж байгаа бичил төслүүдийг олон нийтэд танилцуулах “Туршлага солилцох уулзалт” зохион байгуулжээ. Булган суманд хэрэгжиж буй бичил төслийн багийнхан туршлага солилцохоос гадна багш нар, эцэг эхчүүд төслүүдийн үйл ажиллагаатай танилцаж, шинээр төсөл бичиж байгаа сурагчид үлгэр дууриал авсан байна.

Клубийн ахлагч Х.Билэгдэмбэрэл “Хүүхэд

As part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project implemented by Save the Children, 41 entrepreneurial clubs are operating in target soums across five provinces. One such club is the “Dream Guide” entrepreneurial club at secondary school No. 1 in Bulgan soum, Khovd province. The club members are students united by their passion, all of whom graduated from the “Entrepreneurship-Based Personal Skills Development” course. The “Dream Guide” club consists of 15 members from grades 8-12. The club is led by Kh. Bilegdemberel, with G. Gantogtoх serving as the leader of the management team. The club’s name was chosen by the members to symbolize their commitment to helping their peers achieve their dreams. They meet twice a month, during which time each member presents new ideas, and they discuss them collectively before planning the projects that receive the most support from the group.

In October 2023, the “Dream Guide” club organized an “Experience Exchange Meeting” to showcase the subgrant projects being implemented in the soum. The event was held in collaboration with the “ZET” Entrepreneur Club of the “Minjit Bulgan” complex school and Secondary School No. 1, where the students study. During the meeting, teams implementing projects in Bulgan soum shared their knowledge and experiences, presented their project activities to teachers and parents, and served as role models for students working on new project proposals.

Club leader Bilegdemberel said, “Every child

бүхэнд мөрөөдөл бий. Би чадахгүй байх гэсэн бодлоо хаяж, мөрөөдлөө бүү орхиорой. Бүтэлгүйтэх вий гэж эмээлгүй өөртөө итгээд мөрөөдлийнхөө төлөө тууштай байгаасай гэж хүсмээр байна. ESEL сургалт төгссөн, шинээр төсөл бичих гэж байгаа, төслөө бичсэн ч яаж танилцуулах вэ гэж эргэлзэж байгаа сурагчдад туслах, зөвлөгөө, итгэл өгөх нь бидний гол зорилго юм” гэлээ.

Клубийн гишүүд төсөл бичиж байгаа сурагчдад зөвлөгөө өгч, олон багт төслөө амжилттай танилцуулж, санхүүжилт

has a dream. Don't give up on your dreams and don't think you can't achieve them. Believe in yourself and pursue your dreams without fear of failure. Our main goal is to help, advise, and instill confidence in students who have just completed ESEL training and are uncertain about how to write a project proposal or present their ideas.”

The club members helped many students develop and present their project proposals, ultimately securing funding. In total, 36 teams in Bulgan soum successfully implemented



авахад нь тусалжээ. Булган суманд 104.1 сая төгрөгийн санхүүжилт бүхий 36 багийн бичил төсөл амжилттай хэрэгжихэд “Мөрөөдлийн хөтөч” клубийн гишүүдийн оролцоо, дэмжлэг их байсан билээ.

Булган сум дахь ерөнхий боловсролын хоёр сургуулийн хооронд 2023 оны 11 дүгээр сард “Сурагч солилцоо” арга хэмжээ санаачлан зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагаа сурагчдад их таалагдаж “Сурагч солилцоог дахиад заавал зохиогоорой, илүү олон хоног болгоорой” гэж хүсчээ. “Бидний санаачилсан ажилд хүүхдүүд дуртай оролцож, баярлаж байгааг харах

their subgrant projects with a combined funding of 104.1 million MNT. The “Dream Guide” club played a pivotal role in this success by providing support to these teams.

In November 2023, an experience sharing event was organized between two secondary schools in Bulgan soum. The students enjoyed the activity so much that they requested, “Please organize the experience sharing event again and make it last longer.” The club members shared that the best part was seeing the students actively participate in and enjoy the activities they had initiated.

The major event involving the soum com-

хамгийн сайхан байсан” гэж тус клубийн гишүүд ярих.

Сумын ард иргэдийг хамарсан томоохон арга хэмжээ бол “What3Words” буюу гурван үгт хаягийг түгээн дэлгэрүүлэх 10 долоо хоногийн нөлөөллийн аян байв. Энэ нь урт хугацаанд үргэлжлэх, сумын нийт иргэдийг хамарсан, сумын удирдлагуудын дэмжлэг зайлшгүй хэрэгтэй аян байсан тул клубийн гишүүд амжилттай хэрэгжүүлж чадах эсэхдээ эргэлзэж, зүрхшээж байжээ. Эхний долоон долоо хоногт тэд мэдээлэл хүргэж, хугацаа их зарцуулав. Дараа нь гишүүд ажил үүргээ хуваарилан ESEL сургалтад хамрагдсан бусад сурагчид, сум, сургуулийн удирдлага, сумын Онцгой комисс, сумын Онцгой байдлын газраас дэмжлэг авснаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, багш ажилтнууд, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч зэрэг нийт 3417 иргэнд гурван үгт хаягийг таниулж, ашиглуулж сургажээ. “Мөрөөдлийн хөтөч” клуб нь ийнхүү олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулснаар туршлага хуримтлуулж, багаараа нэгдэж чадвал зорилгодоо хүрнэ гэсэн урам зоригтой болсон байна. Цаашид гишүүдийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, шинэлэг арга хэмжээ, нөлөөллийн аянууд зохион байгуулж, үе тэнгийнхнийгээ манлайлан, нийгэмд дуу хоолойгоо хүргэхийг зорьж байна.

munity was a 10-week outreach campaign to promote “What3Words” service. Given its long duration, involvement of the entire community, and the need for support from soum authorities, the club members initially felt nervous and hesitant about whether they could successfully implement it.

During the first seven weeks, the club members dedicated a significant amount of time to disseminating information about the “What3Words” mobile application service. Following this, they divided their tasks, and with the support of other students who had participated in the ESEL training, the soum and school administration, the Soum Emergency Commission, and the Soum Emergency Management Department, they successfully taught 3,417 citizens— including secondary school students, teachers, and staff from government and non-government organizations— how to use the “What3Words” mobile application service.

By organizing such a variety of activities, the “Dream Guide” club gained valuable experience and became more motivated, realizing that by uniting as a team, they could achieve their goals. In the future, they aim to increase their membership, expand their activities, organize innovative events and advocacy campaigns, lead their peers, and make their voices heard in society.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Энтрепренер клубийн амжилтын түүхүүдийг монгол хэлээр уншина уу.

Read the success stories of subgrant projects in Mongolian.



Энтрепренер клубийн амжилтын түүхүүдийг англи хэлээр уншина уу.

Read the success stories of subgrant projects in English.





А.Уранчимэг бол Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 2020 оноос хэрэгжиж байгаа “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” (ESEL) сургалтын зөвлөх багш юм. “Гурван-Эрдэнэ” багшийн дээд сургуулийг монгол-англи хэлний багш мэргэжлээр төгсөж, Сүмбэр сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуульд багшилж, монгол хэл, бичиг-уран зохиолын хичээл зааж байна. Тэрээр зөвлөх багш болсон талаараа “Би төслийн талаарх мэдээлэл авч, зөвлөх багш болох сургалтад хамрагдсанаар хүүхдүүддээ хувь хүний хөгжлийн чиглэлээр өөрсдийгөө хөгжүүлэх шинэ боломж нээж өгөх, санхүүгийн зөв зохистой мэдлэг олгох, суралцагчдыг чадваржуулах явцдаа өөрөө хамт суралцах, хөгжих боломж байна хэмээн харсан. Төсөл хэрэгжиж эхлэх үед хүсэлт өгсөн багш нараас шалгарч,

A. Uranchimeg is an ESEL teacher/counselor for the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, which has been implemented in Sumber soum, Gobi-sumber province, since 2020. She graduated from the “Gurvan-Erdene” Pedagogical Institute with a degree in Mongolian-English language teaching and is currently serving as a Mongolian language and literature teacher at General secondary school No. 1 in Sumber soum.

She shared her thoughts on becoming an ESEL teacher/counselor: “I learned about the project and realized that by participating in the training to become an ESEL teacher/counselor, I could create new opportunities for my students to develop personally, equip them with proper financial knowledge, and build their capacity while learning and growing together with them. I’m grateful to have been selected from the pool of applicants when the project started, and to have become an ESEL

зөвлөх багш болсондоо баяртай байдаг” хэмээн ярьсан юм. Зөвлөх багш нар хүүхэд залуусын далд авьяас, ур чадварыг илрүүлэх, зорилгоо тодорхойлох, бие дааж ажиллах, энтрепренерийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх арга барилд суралцжээ.

### Танхимын болон цахим сургалт хослуулав

ESEL сургалт Сүмбэр суманд эхлэх үед тохиолдсон хамгийн том сорилт, бэрхшээл бол дэлхий даяар гарсан “КОВИД-19” цар тахал байлаа. Сургалт эхлээд хэд хоногийн дараа цар тахлын нөлөөгөөр орон нутагт хөл хорио тогтоож, сургалтыг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон. Энэ үед гарц гаргалгаа олж, сургалтаа цахим болон танхим хэлбэрээр явуулж төгсгөсөн аж. Нийт 66 цагийн сургалтын 23 цагийг танхимаар, 43 цагийг цахимаар зохион байгуулж, суралцагчид ч амжилттай төгссөн байна. Цахим сургалт давуу болон сул талтай байв. Давуу тал нь, суралцагчид бие даан сургалтын шинэ арга, технологи ашиглаж, асуудлыг шийдвэрлэж, шийдэл гаргаж сүрчээ. А.Уранчимэг багш суралцагчидтайгаа хамт өөрийгөө хөгжүүлсэн нь мөн л давуу тал болов. Тэрээр, цахим сургалт явуулах оновчтой програм хангамжуудыг судлан, тэдгээрийг ашиглахад суралцагчдаа тусалж байлаа. А.Уранчимэг багшийн хувьд одоо дөрөв дэх ESEL сургалтаа чиглүүлэн ажиллаж байна.

### Төсөл чиглүүлж, амжилтад хүргэв

Түүний 2021-2022 оны хичээлийн жилд төгсгөсөн хоёр ангийн суралцагчид санаачилгаараа дөрвөн баг болон “Оюуны наран хүүхэд хөгжлийн танхим”, “Бяцхан эрдэмтэд”, “Мөнх тэнгэрийн бичиг”, “Movie club” гэсэн дөрвөн төсөл

teacher/counselor.”

The ESEL teacher/counselors learned how to guide children and young people in uncovering and developing their hidden talents and skills, setting goals, working independently, and acquiring the knowledge and skills necessary to engage in entrepreneurial activities.

### Combining classroom and online training

The global COVID-19 pandemic was the biggest challenge when ESEL training began in Sumber soum. A few days after the training began, a local lockdown was imposed due to the pandemic, making it impossible to continue the training as usual. At that point, a solution was found and training was completed both online and in the classroom.

Out of the total 66 hours of training, 23 hours were held in the classroom, while 43 hours were conducted online, and the students successfully completed the program. Online learning came with both advantages and challenges. On one hand, students learned to independently use new learning methods and technologies, tackle problems, and develop solutions. Teacher A. Uranchimeg also grew alongside her students, which was a key benefit of the training. She researched the best software for online courses, selected the most suitable one, and helped her students navigate it effectively. A. Uranchimeg is currently leading her fourth ESEL training session.

### Guiding the Project to Successful Outcomes

She led two classes to graduation in the 2021-2022 school year. The students formed four teams on their own initiative and developed project proposals such as, “Intellectual Sun Child Development Hall”, “Little Scientists”, “Eternal Heaven’s Letter”, and “Movie Club”,

бичиж, тэтгэлэгт уралдаанд оролцжээ. Эдгээр төслийн хоёр нь эхний тэтгэлэгт уралдаанд тэнцсэн бол “Мөнх тэнгэрийн бичиг”, “Movie club” нь эхний уралдаанд шалгараагүй ч дахин сайжруулан оролцож, шалгаран тус бүрдээ 2,8 сая төгрөгийн санхүүжилт авчээ. А.Уранчимэг багш “Энэ бол сургалтын үр дүнгийн бодит илрэл юм” хэмээн танилцуулав. Дээр дурдсан дөрвөн төсөл 100 хувийн санхүүжилт авч, сургуулийн захиргааны дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжүүлэх анги танхимаа өөрсдийн хүчээр тохижуулж, үйл ажиллагаагаа тогтвортой, амжилттай явуулж байна. Тэрээр 2023 оны намрын ESEL ангийн суралцагчдын бичиж буй гурван төсөлд зөвлөн, дараагийн тэтгэлэгт уралдаанд оролцуулахаар төлөвлөжээ. А.Уранчимэг “Сүмбэр сумын Засаг дарга, төслийн аймгийн болон сумын зөвлөлийн гишүүд, ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн захирал Г.Сонинбат, сургалтын менежер Ц.Авирмэд, М.Мөнгөнбаатар нар олон талаар тусалж, тулгарсан бэрхшээл, асуудлуудыг шийдэхэд хамтран ажилласан. Төсөл амжилттай хэрэгжихэд энэ хүмүүсийн хувь нэмэр их байлаа” гэсэн юм.

## Төгсөгчид амжилт, бүтээл ихтэй байна

А.Уранчимэг багшийн чиглүүлж сургасан хүүхдүүд амжилтаар арвин байлаа. Тухайлбал, “Бяцхан эрдэмтэд” төслийн ахлагч, 12 дугаар ангийн сурагч О.Урангоо ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахад ESEL сургалтаа амжилттай төгсөж, хувь хүний үр чадвараа хөгжүүлсэн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцсон байдал нь давуу тал болжээ.

Сүмбэр сумын иргэн С.Цогзолбаатар: (Нэгдүгээр сургуулийн 10 дугаар ангийн сурагч Ц.Тэмүүлэнгийн аав) “Манай хүү

and then participated in the subgrant competition. Two of these proposals were selected in the first grant competition, while “Eternal Heaven’s Letter” and “Movie Club” did not qualify. However, the students revised and resubmitted the proposals, and both were selected, each receiving 2.8 million MNT in funding.

A. Uranchimeg emphasized, “ This is proof that the training was very successful.” These project proposals secured 100% funding, and with the support of the school administration, the students are now renovating their classroom on their own while successfully managing their operations. She also mentored the fall 2023 ESEL class, which worked on three project proposals, and plans to facilitate their participation in the next subgrant competition.

A. Uranchimeg noted, “The Governor of Sumber soum, members of the project’s Provincial and Project Soum Level Counsels, the director of the school No. 1, G. Soninbat, and training managers Ts. Avirmed and M. Mungunbaatar provided significant support and collaboration to address the challenges we faced. Their contributions were instrumental in the successful implementation of the project.”

## The Graduates Achieved Remarkable Success

The students taught by teacher A. Uranchimeg have achieved remarkable success. For example, 12th-grade student O. Urangoo was enrolled in the Russian Government Scholarship Program. Her successful completion of the ESEL course, development of personal skills, and active participation in extracurricular activities played a key role in her selection for the scholarship.

S. Tsogzolbaatar, a resident of Sumber soum (father of Ts. Temulen, a 10th-grade student at school No. 1), shared his thoughts on how his

сургалтаас маш их зүйлсийг сурсан. Төсөл бичих, төлөвлөх, хэрэгжүүлэх, мөнгөө зөв зарцуулах, багаар хамтарч ажиллах, бусдын өмнө санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэргээс гадна нийгмийн идэвх нь сайжирч, хичээлдээ оролцох оролцоо ч нэмэгдсэн. Баримт бичгийн боловсруулалт, бүрдүүлэлт гэх мэт олон талын чадваруудтай болсон” гэж уг сургалтад хамрагдаад хүү нь хэрхэн өөрлөгдсөн талаар сэтгэгдлээ хуваалцлаа. “Оюуны наран хүүхэд хөгжлийн танхим” төслийн багийн гишүүн Ц.Эмүжин “Уранчимэг багш бидэнд ESEL сургалтыг маш сонирхолтой арга хэлбэрээр, ойлгомжтой зааж, хүүхдийн онцлог, сонирхолд нийцүүлэн хүүхэд бүрд хүрч ажилласан. Мөн багаар ажиллуулахдаа хүүхэд бүрийн албан тушаал, үүрэг хариуцлагыг нь мэдрүүлж, бие дааж, эсвэл багаар хөгжих боломжуудыг нээж өгсөн. Манай баг тэтгэлэгт уралдаанд шалгарч, санхүүжилтээ аваад “Хүүхэд хөгжлийн танхим”-аа өөрсдийн гараар хамтран тохижуулж, засварын ажлыг хийсэн нь хамгийн гайхалтай, дурсамжтай мөч байсан” гэж ярилаа. Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 2020 оноос “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл амжилттай хэрэгжиж, суралцагчид, төсөл хэрэгжүүлж буй хүүхдүүд, зөвлөх багш нар ч амжилтаар дүүрэн, урам зоригтой явна. Амжилтаар дүүрэн зөвлөх багшийн нэг А.Уранчимэгийн талаар өгүүлэхэд ийм байна.

2024 онд хэвлэгдсэн

son changed after participating in the training: “My son learned a great deal from the training. In addition to developing skills like writing, planning, and implementing projects, he learned to manage finances wisely, work effectively in a team, and express his opinions confidently in front of others. His social engagement has improved, his participation in school activities has increased, and he has learned to prepare and process documents”.

Ts. Emujin, a member of the “Intellectual Sun Child Development Hall” project team, shared: “Teacher Uranchimeg conducted the ESEL training in a very engaging and clear manner, tailoring her approach to each child’s characteristics and interests. Additionally, working in teams helped each child understand their roles and responsibilities, providing opportunities for them to develop both independently and as part of a group. Our team participated in the subgrant competition, won funding, and renovated the child development room by ourselves. It was the most amazing and memorable experience.”

The “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project has been successfully implemented in Sumber soum, Gobisumber province, since 2020. The students, children involved in the project, and ESEL teachers/counselors have all experienced great success and are full of enthusiasm. This is the story of one such ESEL teacher/counselor, A. Uranchimeg, whose success is truly inspiring.

Published in 2024



ESEL хөтөлбөрийн тухай амжилтын түүхүүдийг англи хэлээр уншина уу.

Read the article about the ESEL training in English.



## ХҮРТЭЭМЖТЭЙ СУРГАЛТ, ҮР ДҮНТЭЙ УДИРДЛАГА

### ACCESSIBLE TRAINING AND EFFICIENT MANAGEMENT

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн зорилтот сумдын нэг болох Ховд аймгийн Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер Н.Далхаа зургаан удаагийн ESEL сургалтыг удирдан чиглүүлж, 208 сурагчийг амжилттай төгсгөсөн юм. Мөст сумын сургууль “Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадвар хөгжүүлэх” ESEL сургалтын багш бэлтгэх хоёр удаагийн сургалтаар нийт 12 багшийг мэргэшүүлэн бэлтгэсний нэг нь Н.Далхаа менежер билээ.

Сургалтын менежерийн хувьд сургалтыг амжилттай чиглүүлэхийг зорьж, сургалтын явцад ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөн, сурагч бүрийн идэвхтэй оролцоог хангахын тулд багш нарт аргазүйн зөвлөгөө өгч хамтран ажилладаг байна. Мөн ESEL сургалтын багш болон суралцагч нарын өдрийн ачааллыг нэмэгдүүлэхгүйн тулд сургалтыг хичээлийн нэгдсэн хуваарьт тусгадаг аж. Ингэснээр сургалт үр дүнтэй, хүртээмжтэй, багш, суралцагчдын оролцоог бүрэн хангах боломж бүрддэг байна.

Тэрээр, өсвөр үеийн сурагчдын хувь хүний хөгжил, харилцааны үр чадварууд, бизнес сэтгэлгээ зэрэг ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт тэр бүр байдаггүй ч өнөө цагийн хүүхэд, залууст зайлшгүй хэрэгтэй үр чадваруудыг хөгжүүлдэг нь тэдэнд хамгийн их боломжийг бий болгож байгаа явдал юм хэмээн онцоллоо. ESEL сургалт нь сурагчид, багш нар, сургуулийн удирдлага гээд бүх талын хамтран

N. Dalkhaa is the training manager at the secondary school in Must soum, Khovd province, one of the target soums for Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. He was one of the first 12 graduates of the two ESEL trainer courses held at his school. After completing his training, he facilitated six ESEL sessions at his school, successfully training 208 students. As the training manager, Dalkhaa organizes the sessions and works closely with other teachers to provide methodological support and ensure active student participation. He observes the training process carefully, taking notes to ensure the sessions are both engaging and effective. By integrating the ESEL training into the school’s regular schedule, he minimizes the extra workload for both teachers and students. This approach ensures that the training is not only accessible and effective, but also offers full participation opportunities for everyone involved.

Dalkhaa emphasized that ESEL training provides the greatest opportunities for today’s children and youth by developing skills that are often missing from general secondary school curricula, such as personal development, communication skills, and entrepreneurial thinking.

He also noted that the ESEL training has expanded opportunities for collaboration and growth among all parties—students, teachers, and school administrators. Furthermore, he proudly shared how students who successfully completed the training were able to



ажиллах, хөгжих боломжийг нэмэгдүүлсэн гэв. Үүгээр зогсохгүй сургалтаа амжилттай төгссөн сурагчид санаагаа жижиг бизнес болгон хөгжүүлж, сум, орон нутгийнхаа хөгжил дэвшилд хувь нэмэр оруулж, үе тэнгийнхнээ манлайлж, өөртөө итгэлтэй, бүтээлч, санаачлагатай байдлыг бий болгож байгааг бахархалтайгаар ярих. Төслийн сумын зөвлөл нь сумын Засаг даргын захирамжаар байгуулагдан, журмын дагуу идэвхтэй ажиллаж, ESEL сургалтыг амжилттай төгсөн, пич уралдаанд төслөө ирүүлсэн сурагчидтай уулзаж ярилцан, төсөлтэй нарийвчлан танилцан, зөвлөмж өгч, уралдаанд шалгарсан төслүүдийн хэрэгжилтэд байнга хяналт тавьдаг нь сурагчид төслөө амжилттай хэрэгжүүлэх нэг үндэс болдог гэж Н.Далхаа менежер дүгнэсэн юм.

transform their ideas into small businesses, contribute to their local communities, take on leadership roles, and develop self-confidence, creativity, and initiative.

The project soum Level Counsel (SLC), established by the order of the soum governor, has actively worked in line with the regulations.

Dalkhaa concluded that one of the key factors in the students’ successful project implementation is the SLC’s approach: meeting with students who have completed their ESEL training and submitted their project proposals to the Pitch Competition, reviewing the proposals in detail, offering recommendations, and continuously monitoring the progress of the winning projects.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024

## ESEL ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛҮҮЛЭГЧ, ЭНТРЕПЕНЕР КЛУБИЙН ЗӨВЛӨХ

### ESEL PROGRAM FACILITATOR AND ADVISOR OF THE ENTREPRENEUR CLUB

*-Хосолсон хөтөлбөрийн багш хүүхэд, залуусыг хамтад нь чиглүүлж, сургадаг-*

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийнхөө сурлагын амжилтаар аймагтаа тэргүүлдэг. Ш.Болор-Эрдэнэ ур чадварыг зах зээлтэй холбох ирмүүн хүсэлтэй багш юм. Тэрээр, ESEL хөтөлбөрийн танхимын болон хосолсон хөтөлбөрийн хүүхэд, залуусын чиглүүлэгч нь. Ш.Болор-Эрдэнэ Баяндэлгэр сумынхаа сургуульд 23 дахь жилдээ технологийн багшаар ажиллаж байна. Түүний хувьд алслагдсан хөдөө, орон нутгийн хүүхэд, залуус боломжоо ашиглаж, хил хязгаар үл харгалзан хөгжих ёстой гэж итгэдэг. Орон нутаг дахь өсвөр үеийнхэн аливаа боломжийг туршиж, чадах зүйлсээ олж мэдэхэд багшийн ухаалаг чиглүүлэлт, дэмжлэг чухал ч хөдөөд материаллаг нөөц хомс, харилцаа, сэтгэл зүй, санхүүгийн мэдлэг, мэдээлэл тааруугаас шалтгаалж бэрхшээл их байв.

Харин Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл 2020 онд Баяндэлгэр суманд хэрэгжих болсон нь алдагдсан боломжийг нөхөх ач холбогдолтой байлаа.

Ш.Болор-Эрдэнэ багш төслийн зорилго хүсэл тэмүүлэлтэй нь нийцэж байгаад олзуурхаж, чиглүүлэгч багш сонгон ажиллуулах шалгаруулалтад орж тэнцжээ. Ийнхүү тэрээр, хөтөлбөрийн чиглүүлэх

*- Guiding and educating teachers, children, and youth in the blended learning program-*

Bayandelger soum's general secondary school in Sukhbaatar province is well-known for producing some of the region's top graduates. One of the teachers dedicated to bridging the gap between students' skills and the market is Sh. Bolor-Erdene, who serves as both a school teacher and a facilitator for the ESEL classroom and blended learning programs.

Having taught technology at the school for 23 years, Sh. Bolor-Erdene believes that children and youth in remote rural areas can seize opportunities and grow, despite the challenges posed by geographical isolation. While teachers' guidance and support are vital in helping students unlock their potential, rural areas often lack key resources—such as materials, communication infrastructure, and financial or psychological knowledge—which creates significant barriers to development.

In 2020, Save the Children launched the ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project in Bayandelger soum, Sukhbaatar province, offering a valuable opportunity to address previously overlooked needs. Sh. Bolor-Erdene was excited that the project's goals aligned with her own aspirations, so she applied to become a ESEL teacher/ counselor. After successfully passing the selection process, she was hired. As a result, Bolor-Erdene took on the role of ESEL teach-

er/ counselor, guiding students, building their capacity, and teaching them how to write project proposals. At the same time, she enhanced her skills by attending a trainer course for the classroom and online blended learning program organized by Save the Children in Ulaanbaatar. With this additional training, she began guiding young herders and parents who were staying at home with their children to join the program. As a teacher for the blended learning program, Bolor-Erdene's role expanded beyond the school to include the soum governor's office, unemployed youth aged 14-25, and local citizens. She also worked closely with the bagh governors to conduct research on the target groups and share information about the program with them. The ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project developed an innovative curriculum, collaborates with local secondary schools and Lifelong Learning Centers, supports the practical application of knowledge gained from the training, and funds subgrant proposals developed by children and youth. Bolor-Erdene explains, “Introducing and promoting new approaches and activities to children, youth, and the community is never easy. My goal is to lead by example through my own participation and approach, then inspire the community through the children. In October 2023, she became a blended learning teacher/ counselor. By November, she had formed a class of 20 young people and began teaching. The training followed the same curriculum and duration as traditional courses, but it was designed to take place outside the classroom. Each student, along with the teacher, was provided with a tablet,

багш болж, сурагчдад зөвлөн тусалж, ур чадвар, төсөл бичих арга зүйд сургах болов. Үүний зэрэгцээ ур чадвараа ахиулан Хүүхдийг Ивээх Сангаас Улаанбаатар хотод зохион байгуулсан танхим болон цахим хосолсон хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан байна. Ингээд малчин залуус болон гэртээ хүүхдээ харж суугаа залуу эцэг, эхчүүдийг хөтөлбөрт чиглүүлэн ажиллах болжээ. Хосолсон хөтөлбөрийн багш болсноор зөвхөн сургуультай бус сумын Тамгын газар, сумын ажил хөдөлмөр эрхлээгүй 14-25 насны залуус, орон нутгийн нийт иргэдтэй хамтран ажиллах болов. Багийн Засаг дарга нартай хамтран зорилтот бүлгийнхний судалгаа гаргах, тэдэнд хөтөлбөрийн талаарх мэдээлэл хүргэх болж, үйл ажиллагааны хүрээ нь тэлсэн юм.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслөөс сургалтын шинэлэг хөтөлбөр боловсруулж, ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажилладаг. Орон нутгийн хүүхэд, залуус ESEL сургалтаас олж авсан мэдлэг, чадвараа бодитоор турших явдлыг дэмжиж, хүүхэд, залуучуудын боловсруулсан бичил төслийг санхүүжүүлж байна. “Шинэ хандлага, шинэ соёлыг дэлгэрүүлж, хүүхэд, залуус, ард иргэдэд хүргэнэ гэдэг амаргүй. Тиймээс би оролцоо, хандлагаараа суралцагчдад үлгэрлэж, хүүхдүүдээр дамжуулан олон нийтэд нөлөөлөхийг зорьдог” хэмээн Ш.Болор-Эрдэнэ ярьж байна. Тэрээр, 2023 оны 10 дугаар сард хосолсон сургалтын сургагч багш болсон. Мөн оныхоо 11 дүгээр сард сумандаа нэг анги нээж, 20 залуу элсүүлжээ. Энэ сургалтын агуулга, цаг адил боловч танхим бусаар хичээллэх зориулалтаар багш болон залууст таблет өгч, датагаар хангаж, сүлжээгүй байсан

er/ counselor, guiding students, building their capacity, and teaching them how to write project proposals.

At the same time, she enhanced her skills by attending a trainer course for the classroom and online blended learning program organized by Save the Children in Ulaanbaatar. With this additional training, she began guiding young herders and parents who were staying at home with their children to join the program.

As a teacher for the blended learning program, Bolor-Erdene's role expanded beyond the school to include the soum governor's office, unemployed youth aged 14-25, and local citizens. She also worked closely with the bagh governors to conduct research on the target groups and share information about the program with them.

The ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project developed an innovative curriculum, collaborates with local secondary schools and Lifelong Learning Centers, supports the practical application of knowledge gained from the training, and funds subgrant proposals developed by children and youth.

Bolor-Erdene explains, “Introducing and promoting new approaches and activities to children, youth, and the community is never easy. My goal is to lead by example through my own participation and approach, then inspire the community through the children.

In October 2023, she became a blended learning teacher/ counselor. By November, she had formed a class of 20 young people and began teaching. The training followed the same curriculum and duration as traditional courses, but it was designed to take place outside the classroom. Each student, along with the teacher, was provided with a tablet,



ч таблетаасаа хичээлээ үзэх боломж бүрдүүлжээ. Насанд хүрэгчид сурагчдаас ялгаатай нь, үзэж судалснаа таблет дээрээ давтаж, даалгавраа хийж илгээхээс гадна багаараа хамтарч ажиллахад хурд сэтгэхүй нь илүү, хурдан шаламгай байсан нь багш, залууст хичээлээ үзэж дуусах, төслөө бичих, хэрэгжүүлэхэд дөхөм байсан ажээ. Түүний хувьд сургалт явуулна, бичил төслийг чиглүүлнэ, хамтрагч талуудтай мэдээлэл солилцож, дараагийн ажлын төлөвлөгөө боловсруулна, зорилтот бүлгийнхэнд мэдээлэл өгнө, Хүүхдийг Ивээх Сангаас заавар, дэмжлэг авч хөтөлбөрөө нутагшуулна гээд завгүй ажилладаг ч үндсэн ажлаа ч мартахгүй амжуулна. Сумандаа анхны ESEL хөтөлбөрийн багшаар ажиллаж эхэлснээс хойш 48 хүүхэд, залуусыг хөтөлбөрт амжилттай суралцуулж, төслийн хаалтын жил 24 суралцагчийг чиглүүлэн ажиллажээ. Түүний суралцагчдаас 15 нь дөрвөн баг болон “Бяцхан туслагч”, “Суран

data, and the necessary resources to access lessons, even in remote areas without network coverage.

Unlike school students, adults reviewed their lessons on their tablets and submitted their assignments. Their quick thinking and strong teamwork made it easier for both teachers and students to complete the lessons, write project proposals, and successfully implement them.

Despite her busy schedule—conducting training, managing subgrants, exchanging information with partners, developing work plans, providing updates to target groups, and receiving guidance and support from Save the Children to localize the program—she was able to continue her primary work.

Since becoming the first ESEL teacher/ counselor in her soum, Bolor-Erdene has successfully trained 48 children and youth. She facilitated the learning of 24 students in the final year of the project. Among her graduat-

эдлэл”, “Урлахуй”, “Эко саван” гэсэн бичил төслүүд бичсэн нь шалгарчээ. Ш.Болор-Эрдэнэ сургуульд байгуулагдсан хүүхдийн оролцооны энтрепренер клубийн зөвлөх багшаар ажиллаж, энтрепренер үзэл санааг орон нутагтаа түгээхэд хувь нэмэр оруулж байна.

“ESEL хөтөлбөрийн чиглүүлэгч багшаар ажиллахдаа суралцагчдын харилцаа хандлага, ялгаатай байдлыг нь ажиглан, хүн бүхэнд тохируулан сургах арга зүйг эрхэмлэдэг. Сурагч бүрийг нээлттэй, аливаад санаачилгатай болгоход анхаарч ажилласан нь үр дүнгээ өгсөн. Технологийн хичээлдээ ч ESEL сургалтын арга зүйг ашиглаж байгаа нь ач холбогдолтой байна. Сурагчид багшдаа итгэж, сурах эрмэлзэл нэмэгдэж байгаа нь ажиглагдсан. Төсөл хэрэгжихээс өмнө зөвхөн хичээлээ цагт нь заагаад явж байлаа. Төслийн нэг хэсэг болсноор хувь хүний талаасаа илүү олон зүйлийг амжуулж сурлаа. Төгсөгчид маань бусадтай нээлттэй харилцдаг болж, харилцааны үр чадварт суралцсан. Аливаад санаачилгатай байж, төслийн давуу талыг олж харж, үр шимийг нь хүртэж байгаад баяртай байна. Өмнө нь өөр төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан ч одоогийнх шиг нас насны хүүхэд, залуустай ажиллаж байгаагүй. “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөлд хамрагдсанаар суралцагчид төдийгүй би өөрөө ч шинэ санааг үргэлж эрэлхийлдэг болсон. Төслийн үр шим, соёл манай сургуульд нутагшсан” гэж Ш.Болор-Эрдэнэ багш эцэст нь өгүүллээ.

ing students, 15 formed four teams, and their project proposals—‘Little Helper,’ ‘Leather Goods,’ ‘Home Crafts,’ and ‘Eco Soap’—were selected in the subgrant competition. Additionally, Bolor-Erdene serves as a teacher and counselor for the Entrepreneurship Club established at the school, helping to spread entrepreneurial ideas throughout the community.

As a facilitator for the ESEL program, she observed students’ communication styles, attitudes, and individual differences, applying teaching methods tailored to each person’s needs. Encouraging each student to be open and proactive ultimately paid off. The use of the ESEL training methodology in technical sessions was found to increase students’ trust in their teachers and significantly boost their motivation to learn.

Sh. Bolor-Erdene shared, “Before joining the project, I was solely focused on teaching my classes. Being part of this initiative has allowed me to grow personally. My graduates have become more open and developed strong communication skills. I’m proud to see them take initiative, recognize the value of the project, and benefit from it. I’ve participated in projects as a trainer before, but this is the first project where I’ve worked with children of such varying ages. Being involved has sparked a continuous search for new ideas—not just among the students, but within myself as well. The benefits and culture of the project are gradually becoming embedded in our school.”

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024





## ХОСОЛСОН СУРГАЛТ ХӨГЖҮҮЛЭГЧ

### DEVELOPING A BLENDED LEARNING MODEL FOR RURAL COMMUNITIES

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн зорилтот аймгийн нэг Говьсүмбэр юм. Тус аймгийн Насан туршийн боловсролын төвийн захирал Х.Амаржаргал дөрвөн удаагийн ESEL сургалтыг удиран чиглүүлж, орон нутгийн 14-25 насны 80 залууг амжилттай төгсгөсөн юм. Говьсүмбэр аймгийн Насан туршийн боловсролын төв ESEL сургалтын багш бэлтгэх хоёр удаагийн сургалтаар дөрвөн багш мэргэшүүлсний нэг нь Х.Амаржаргал билээ.

Тэрээр “Би 2020 онд тус төслийн насан туршийн ангийн багш/зөвлөхөөр ажиллах хүсэлтээ өгч байсан нь саяхан мэт санагдаж байна. Түүнээс хойш танхимаар гурав, хосолсон нэг ангийн багш/зөвлөхөөр ажиллаж, сургалтуудаа үр дүнтэй, амжилттай зохион байгуулжээ. ESEL сургалтыг анх явуулахдаа өөртөө эргэлзэж байсан ч, төслийн багшаар бэлтгэгдэх явцад сургалтыг үр дүнтэй зохион байгуулахаас эхлээд олон шинэ арга зүйд суралцсан юм. Хувь хүний үзэл бодолд багагүй эерэг өөрчлөлт гарч, өөртөө итгэлтэй болсон” хэмээн ярьж байлаа. Түүний хэлснээр, ESEL сургалт орон нутгийн хүүхэд, залуучуудын хувь хүний хөгжил, харилцаа хандлагыг өөрчилж,

Gobisumber is one of the target provinces for Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. Kh. Amarjargal, the director of the province’s Lifelong Learning Center, has successfully led four rounds of ESEL training courses, training 80 local youth aged 14-25. Amarjargal is one of four ESEL teachers who have completed two rounds of ESEL training of trainers courses at the Gobisumber Lifelong Learning Center.

She shared, “It feels like just yesterday that I applied to work as a teacher/ counselor for the project’s Lifelong Learning class in 2020. Since then, I’ve taught classroom-based courses for three groups of students and used a blended learning approach for another group, by organizing my training sessions effectively and successfully. Initially, I felt hesitant about myself when conducting the ESEL training. However, after attending the training for trainers, I gained new skills, one of which is organizing effective training. This has led to significant personal growth, and I’ve become much more confident.”

She was pleased with how the ESEL training has transformed the personal development and communication skills of local children and youth. It has helped develop a business mind-

set, taught them to better understand themselves and others, and equipped them with skills that, while often not covered in school curricula, are essential for today’s youth. She emphasized, “The education, knowledge, skills, living environment, and behavior of the young people who participated in the training are different, so it felt like acquiring new skills and learning the profession of ‘psychologist’ at the same time.” The classroom-based and blended learning approaches of the ESEL training course proved to be an invaluable intellectual investment for both the young people and the young mothers caring for their children in remote areas.

For example, the blended learning approach

Тэрээр “Сургалтад хамрагдсан залуусын эзэмшсэн боловсрол, мэдлэг, үр чадвар, амьдрах орчин, ааш араншин өөр учир багшийн хувьд шинэ арга зүйд суралцаж, “сэтгэл зүйч” хэмээх мэргэжлийг давхар эзэмшиж байгаатай адил байлаа” гэж тодотгосон юм. ESEL сургалтын танхим болон хосолсон хэлбэр нь алслагдсан багийн залуус болон хүүхдээ харж буй залуу ээжүүдэд үнэлж баршгүй их оюуны хөрөнгө оруулалт болсон юм.





Тухайлбал, ESEL сургалтад сурахыг хүссэн ч амжихгүй байгаа, алслагдсан багт амьдарч буй малчин залуус, хүүхдээ хараад гэртээ байгаа ээжүүдэд боломж олгож, сургалтын шинэлэг арга зүйгээр сургаж, хөгжих, боловсрох маш том боломж өгсөн нь хосолсон сургалтын онцлог байв. Сургалтад хамрагдсан залуус мэдлэг, үр чадвараа ашиглаж, бичил бизнесээ туршиж, бодит ажил, үйлчилгээ нэвтрүүлэн, нийгэмдээ төдийгүй бусад үе тэнгийн залуучуудад үлгэрлэн, нэг шатаар ахиж дэвшиж, байнгын суралцаж байдаг нь энэ төслийн үр өгөөж юм.

Хосолсон сургалт нь багшийн хувьд орон зайг үл харгалзан хүрч ажиллах боломж олгодог. Мөн ажил амьдралаа ч зохицуулах, тухайн хичээлээ судлах цаг гаргаж өгдөг. Гэвч зайнаас буюу дэлгэцийн цаанаас тухайн суралцагчийг танин мэдэх, илүү ойртон ажиллахад хүндрэлтэй байсан тул Х.Амаржаргал багш ангийн групп чат нээн, өдөр бүр мэдээллээ солилцож, харилцаа холбоо үүсгэснээр бэрхшээлийг шийджээ. Тэрээр, тухайн багийн хүсэлтийн дагуу зарим сэдвийг танхимаар заахаас гадна алслагдсан багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж байна. Ингэснээр хамтын ажиллагаа өргөжиж, малчин залуусыг идэвхжүүлж, тэдэнд мэдээллээ цаг алдалгүй хүргэх болжээ.

2024 онд хэвлэгдсэн

was unique in that it provided opportunities for young herders and mothers caring for their children in remote areas—who wanted to study, but were unable to attend the ESEL training—to develop and learn using innovative training methodologies.

The benefits of this project include the fact that young people who have participated in the training apply their knowledge and skills to run their micro-businesses, offer real work and services, and serve as role models not only in their communities, but also to peers of their own age. They progress step by step and continue to learn and grow.

Blended learning allows teachers to work remotely, regardless of distance, while also providing the flexibility to balance work and personal life and giving them time to study the subject. However, connecting with students and working closely with them remotely proved challenging. To overcome this, Amarjargal addressed the issue by creating a group chat to exchange information and build relationships on a daily basis.

In addition to teaching certain topics in the classroom at the request of the baghs, she has been working closely with the governors of remote baghs. This has expanded cooperation, engaged young herders, and provided them with timely information.

Published in 2024



## БЭЛЧЭЭР, ТАНХИМ ХОСЛУУЛСАН СУРГАЛТ

### INTEGRATING PASTURE WITH CLASSROOM LEARNING

Завхан аймгийн Баянтэс сум. Монгол орны баруун хойд хилийн ойролцоо Тэсийн голыг хөвөөлөн орших энэ нутагт жилийн жилд эрс тэс хүйтэн өвөл болдог. Цас ч их унадаг. Өдөртөө хасах 30-аас дээш хэмтэй өдрүүд цөөнгүй. Ийм хүйтэн, хүнд нөхцөлд малчин залууст сургалтаа тасралтгүй хүргэж, амжилттай төгсгөсөн нэгэн багшийн түүхийг өгүүлье. Тэр бол Баянтэс сумын ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл технологийн багш, ESEL сургалтын зөвлөх Б.Анхбаяр билээ.

Б.Анхбаяр багш хосолсон сургалтын чанарыг сайжруулж, сурагч бүртээ хүрч ажиллахын тулд багийн дарга нарыг явуулын багш болгон туслуулсан нь шинэлэг бөгөөд үр дүнтэй арга болжээ.

Bayantes soum, located in Zavkhan province, sits along the Tes river near Mongolia's northwestern border. This region is known for its harsh winters, with temperatures often plunging below -30°C and heavy snowfall being a frequent occurrence. Let me tell you a story of a teacher who, despite these extreme conditions, managed to successfully deliver a training program for young herders. Her name is D. Ankhbayar, an Information Technology teacher and ESEL teacher/ counselor at Bayantes soum general secondary school.

Teacher Ankhbayar's innovative approach of using bagh governors as mobile trainers has proven to be an effective way to improve the quality of blended learning and ensure that each student is reached.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL буюу Энтрепренершипд суурилсан хувь хүнийг хөгжүүлэх сургалт ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн сурагчдаас гадна Насан туршийн боловсролын хүрээнд буюу сургуулиас гадуурх 14-25 насны залуусыг сургаж, боломж олгодог онцлогтой. Танхимын болон танхимын бус хосолсон сургалтаар ESEL хөтөлбөрт хамрагдаж, бичил төслийн уралдаанд оролцон төслийн санаагаа бодит болгон хэрэгжүүлсэн олон жишээ бий. Төслөөс хосолсон сургалтад хамрагдсан залуус бүрд хичээлийн агуулга суулгасан таблетыг интернэт, утасны ярианы эрхийн хамт өгдөг. Сургагч багш нар ч ийм боломжоор хангагдаж, зайнаас болон танхимаар хослуулан сургалтаа явуулдаг. Орон зайнаас үл хамаарч, цаг хугацаа хэмнэсэн, шинэлэг хийгээд сонирхолтой хосолсон сургалт сумдад үр дүнтэй хэрэгжиж байна. Хосолсон сургалтын сурагч малчин залуус малаа маллаж, гэр ахуйгаа эмхлэнгээ хичээлээ сонсож, үзэх боломжтой. Цаг наргүй ажлынхаа завсар зайгаар даалгавраа хийж гүйцэтгээд багш руугаа илгээнэ. Утсаар асууж тодруулна.

Д.Анхбаяр 2021 онд ESEL сургалтын зөвлөх багш болжээ. ESEL сургалтыг явуулахдаа ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн сурагчдыг танхимаар, сургуулиас гардуурх 14-25 насны залуусыг хосолсон сургалтаар чиглүүлж удирдсан туршлагатай багш юм. Тэрээр, 2023 оны 10 дугаар сард хосолсон сургалтын багш болж, сургалтаа чанартай явуулж, сурагч бүрийг идэвхтэй оролцуулж байна. Танхимын бус, зайнаас

The ESEL training, conducted as part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, is unique in offering opportunities for students in grades 8-12 as well as out-of-school youth aged 14-25 under the Lifelong Learning Program.

There are numerous examples of successful engagement with the ESEL program through a blended approach that combines both classroom and non-classroom learning, participation in Pitch competitions, and the realization of innovative project ideas.

This training course provides each student with a tablet preloaded with course content, along with internet and phone access. Trainers also use the tablets to deliver a blend of distance and in-person training. This innovative course, which bridges distance and time, has been successfully implemented in soums and is already showing positive results. In practice, young herders using this blended learning approach can listen to and watch lessons while herding livestock or helping with household chores on the farm. They can complete assignments, send them to their teachers, and ask questions over the phone during work breaks.

D. Ankhbayar became an ESEL teacher/ counselor in 2021. With extensive experience as a trainer, she has conducted ESEL training for high school students in grades 8-12 in the classroom, as well as for young people aged 14-25 through blended learning. In October 2023, she completed her training to become a certified blended learning trainer. Since then, she has been delivering high-quality training sessions that actively engage every student. Recognizing the unique challenges of remote teaching, she also thought to enlist the help of her soum bagh governors to support her

хичээллэх үед дээр хэлсэнчлэн сумынхаа багийн дарга нарыг туслуулах талаар боджээ. Ингээд Баянтэс сумынхаа удирдлагууд, сумын Төслийн зөвлөл, нийт багийн дарга нарт ESEL хосолсон сургалт явуулах боломжийг танилцуулж, хамтарч ажиллахаар тохирсон байна. Түүний саналыг Баянтэс сумын дөрвөн багийн дарга дэмжиж, сумынхаа залуусын боловсрол, мэдлэгийг сайжруулахад хамтран ажиллахаар төлөвлөгөө гаргав. Багийн дарга нарын ойлголтыг нэг түвшинд хүргэхийн тулд ESEL хосолсон сургалтын талаар мэдлэг, ойлголт өгөх нэг өдрийн сургалтыг Д.Анхбаяр багш, Баянтэс сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер Д.Гэрэлжаргал, захирал Ч.Дашхүү нарын хамт зохион байгуулав. Сургалтад суусан багийн дарга нарт “Явуулын багш” гэсэн батламж өгч, урам зориг, хариуцлагыг нь баталгаажуулсан ажээ.

Баянтэс сумын 2023 оны 11 дүгээр сараас 2024 оны нэгдүгээр сар хүртэл хичээллэсэн хосолсон сургалтын ангийн 20 сурагч ямар нэгэн завсардалгүй амжилттай төгсөж, тус ангиас гурван сурагч баг болж, “Мебель тавилгын үйлдвэрлэл” төсөл бичиж, 2024 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан “Пич-7” уралдаанд шалгарч санхүүжилт авах эрхтэй болжээ. ESEL сургалтын зөвлөх багш Д.Анхбаяр “Төслийн сумын зөвлөл болон багийн дарга нарын үүрэг оролцоо их байлаа. Багшаас нь гадна багийн дарга нар, орон нутгийн удирдлагууд анхаарал тавьж, гэрт нь очиж сургалт явуулахаар сурагчид урам зоригтой болж байна. Олон хүн анхаарал тавьж, дэмжихээр хичээлээ сайн сурахгүй бол болохгүй нь

students.

She then presented the idea of organizing ESEL blended learning to the leaders of Bayantes soum, the project soum level counsel and the bagh governors. Her proposal was supported by the governors of four baghs in Bayantes soum, and they developed a plan to collaborate in improving the education and knowledge of the youth in their soum.

To enhance the understanding of the bagh governors, teacher D. Ankhbayar, Education Manager D. Gereljargal, and Principal Ch. Dashkhuu of Bayantes soum school organized a one-day training session on ESEL blended learning. The training aimed to provide knowledge and clarity about the blended learning approach. Additionally, the school awarded certificates to the bagh governors, recognizing them as “mobile trainers,” which helped ensure their motivation and sense of responsibility.

Twenty blended learning students from Bayantes soum studied successfully without any interruptions from November 2023 to January 2024. Three students from the class formed a team and wrote a project proposal titled “Furniture Production” and participated in the Pitch-7 competition held in March 2024. Their proposal was selected and received funding.

ESEL teacher and counsellor Ankhbayar said, “The Project Soum Level Counsel and bagh governors played a crucial role in ensuring the training was successfully implemented. In addition to the teachers, the bagh governors and local authorities showed great care for the students, visiting their homes and offering encouragement. The support and attention from so many people made the students feel that they had to study hard and do their best.”



гэсэн мэдрэмжтэй болж, хичээнгүйлэн суралцдаг” хэмээн ярилаа.

Сургалтын үеэр гарсан бэрхшээл ч цөөнгүй. Ангийн 20 суралцагчийн долоо нь сүлжээ огт барьдаггүй газар өвөлждөг ч сүлжээ барих газарт зорин очиж, багштайгаа долоо хоногт 1-2 удаа заавал утсаар ярьдаг байв. Багшид нь ажил гарсан үед асуух зүйлээ багийн даргатайгаа холбогдож хэлдэг. Бужир багийн дарга, явуулын багш Д. Бадамгарав багийн сурагчийнхаа Google classroom-д байршуулсан гэрийн даалгаврыг илгээхийн тулд сүлжээ ордог газар руу талдаа 40 км явж байв. Багийн дарга нарыг явуулын багш болгосон нь багшийн ажлыг хөнгөвчилж, хамгийн гол нь сумын төвөөс 30-90 км зайтай амьдардаг сурагчид даалгавраа нэг ч таслалгүйгээр илгээж байлаа.

“Орон нутгийн өсвөр үеийнхэд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох” төсөл сурах хүсэл эрмэлзэл дүүрэн ч аймаг, хотоос алслагдсан, сум дотроо алс хол амьдардаг залууст сурч хөгжих, ур чадвараа сайжруулах боломж өгсөн юм. Малын бэлчээрийг танхимтай хослуулсан, орон зай үл хамаарах энэ сургалт үүнээс ч олон залууст боломж олгох биз ээ.

There were also many challenges during the training. Seven out of the 20 students in the class lived in an area with no cell phone network during the winter. To stay connected, they would travel to a location with a signal and speak to their teacher on the phone 1-2 times a week. If the teacher was unavailable, the students would reach out to the bagh governor with their questions.

For example, “Bujir” bagh governor and mobile trainer, D. Badamgarav, drove 40 km with the students to a location with internet to help them upload their assignment to Google Classroom, and then returned them home.

Designating bagh governors as mobile trainers made the work of the trainers easier. Most importantly, students living 30-90 km away from the soum center were able to submit their assignments without interruption. The “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project offered valuable opportunities for young people, eager to learn but living in remote areas, to study, develop, and enhance their skills.

This training, which combines pastoral settings with classrooms and is not constrained by distance or location, will continue to offer opportunities to even more young people.

## ESEL СУРГАЛТААС ЭХТЭЙ ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТҮҮД

### POSITIVE CHANGES RESULTING FROM ESEL TRAINING

Монгол орны баруун хязгаар, Ховд аймгийн Мөст сум. Гарааны жижиг бизнес дэх сорилт бэрхшээл, алдаа оноо, амжилт ололтыг энэ түүх өгүүлнэ.

“Санхүүгийн хувьд бусдаас хамааралгүй болоод ирэхээр өөртөө итгэх итгэл нэмэгдэж, хүчтэй болж байгаа шиг мэдрэмж төрдөг юм билээ. Бидний мөрөөдөл өдрөөс өдөрт томорч байгаа” хэмээн ярих залуучууд бол Ховд аймгийн Мөст сумын Насан туршийн боловсролын төвийн суралцагч, “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн үр шимийг хүртэгч “Ялалт кейк хаус” кофе шоп ажиллуулдаг нэг гэр бүлийн хоёр Ц.Аззаяа, Б.Галцогт нар юм.

Ц.Аззаяа нөхөр Б.Галцогтын хамт төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт, үйл ажиллагаанд хамрагдан, идэвхтэй оролцсоноор амьдралд нь эерэг өөрчлөлт гарсан тухай ийнхүү өгүүлсэн юм. “Анх Мөст сумын Насан туршийн боловсролын төвийн Б.Нямцэцэг багш маань хувь хүний ур чадварыг хөгжүүлэх ийм сургалт болно гэж хэлсэн. Би ESEL сургалтын 2021 оны хаврын элсэлтээр элсэн суралцсан юм. Сургалт сонирхолтой, мэддэг юм шиг хэрнээ мэддэггүй, амьдралд их ойрхон, сургуульд заадаггүй зүйлсийг зааж байсан учир нөхрөө “ятгаж” ESEL сургалтын 2022 оны намрын хосолсон ангид элсүүлсэн. Нөхөр бид хоёр ESEL сургалтаас сэдэл

Must soum, Khovd province, Western Mongolia. This story highlights the challenges, mistakes, and successes of running a small business.

When we are no longer financially dependent on others, our self-confidence grows, we feel stronger, and our dreams expand each day,” said Ts. Azzaya and B. Galtsogt, students at the Lifelong Learning Center in Must soum, Khovd province. This husband and wife duo are beneficiaries of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project and are the proud owners of Yalalt Cake House, a local coffee shop.

Ts. Azzaya shared how she and her husband, B. Galtsogt, participated in the training and activities offered by the project, highlighting the positive changes in her personal development and life. Teacher B. Nyamtsetseg, from the Lifelong Learning Center in Must soum, Khovd province, informed Azzaya about a personal development training course. In the spring of 2021, Azzaya enrolled in the ESEL course. The training was engaging and though the topics seemed familiar, they felt entirely new and highly relevant to everyday life. It offered practical lessons that were not taught in school. Encouraged by her own experience, Azzaya convinced her husband to join the ESEL blended learning program in the fall of 2022.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



“Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар олгох” (ESEL) хөтөлбөрийн арга зүйн онцлогийн тухай видеог монгол, англи хэлээр үзнэ үү.

Watch the video about the ‘Entrepreneurship-based Socio-Emotional Skills’ (ESEL) training in Mongolian and English.

авч, эрэл хайгуул хийж байх үед буюу 2022 оны 3 дугаар сард “Энтерпренер Seeds” тэтгэлэгт хөтөлбөр зарлагдаж, бид “Healthy life” төслөөр оролцон шалгарсан юм. Гэхдээ шүүгч нар иогийн албан ёсны багшлах эрхтэй болсны дараа төслөө хэрэгжүүлэх нь дээр гэж



зөвлөсөн.

Бич “Иогийн багш болж, төслийнхөө гэрээг хийнэ дээ” гэж бодож байсан ч иогийн багш болох сургалтын төлбөр гурван сая төгрөг байсан тул санхүүгийн боломжоос шалтгаалан суралцаж чадаагүй. Гэхдээ бид бууж өгөөгүй” хэмээн Ц.Аззаяа ярилаа. Гэр бүлийн хоёр маань эхний төслөө хэрэгжүүлж чадаагүй ч дахин өөр төсөл бичин шалгаруулалтад оролцоно гэж сэтгэл шулуудаж, бэлтгэлээ хангав. Ц.Аззаяа өмнө нь цалинтай ээжийн 50 мянган төгрөгөөр бялуу жигнэх хэрэгсэл авч, хадам ахынхаа жижиг гэрийг барьж, өдөрт 20-30 ширхэг аяган бялуу хийдэг байжээ. Бялуугаа сумын

Azzaya recalled, “My husband and I were inspired by the ESEL training, which led us to start looking for a business idea when the ‘Entrepreneur Seeds’ subgrant competition was announced in March 2022. We submitted our proposal for the ‘Healthy Life’ project and were selected for funding. The judges recommended that we proceed with our project after obtaining official licenses to teach yoga. I was excited to become a yoga instructor and sign a contract to implement our project. However, the tuition fee to become a licensed yoga teacher was 3 million MNT, and due to financial constraints, I couldn’t afford the training. But we didn’t give up.”

Although their family was unable to implement their first project, they decided to try again with a new proposal. Previously, Azzaya had used the 50,000 MNT from their Parental Support Allowance to purchase cake-making equipment, set up a small ger provided by their brother-in-law, and began baking 20-30 cupcakes a day. They sold them at the soum shop, earning about 20,000-30,000 MNT. This small business sparked the idea for their next project proposal.

In 2023, the “Entrepreneur Seeds” subgrant competition was announced once again. Azzaya, along with her husband and friends, submitted a proposal for their new venture, “Yalalt Cake House,” named after their son. Their proposal was selected, and they received small business funding. The soum Counsel, formed as part of the project, provided them with premises for their business. The owners of “Yalalt” coffee shop believe

дэлгүүрээр дамжуулан борлуулж, өдөртөө 20,000-30,000 төгрөг олдог ч, хараахан өргөжүүлж чадаагүй байсан энэ бизнес санаагаа төсөл болгон бэлдэв. Удалгүй 2023 онд “Энтерпренер Seeds” тэтгэлэгт хөтөлбөр дахин зарлагдаж,



хүүгийнхээ

нэрээр нэрлэсэн “Yalalt cake house” төслөөр нөхөр, найзын хамт оролцон шалгарч, гарааны санхүүжилт авч чаджээ. Төслийн хүрээнд байгуулагдсан сумын зөвлөлөөс тэднийг дэмжин, ажлын байраар хангасан байна.

“Ялалт” кофе шопын эзэд “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд зохион байгуулсан хувь хүний ур чадвар нэмэгдүүлэх сургалт болон санхүүгийн дэмжлэгийн үр дүнд өөрсдийнх нь хэлснээр бөх бат байшингийн “суурь цутгаж” чадсан юм.

that the personal development training and financial support provided by the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project gave them the opportunity to build a strong foundation for their business.

Now the future is in our hands, and we are working tirelessly to build it,” they said. In 2023, Yalalt Cake House earned approximately 1 million MNT on Children’s Day.

Azzaya added, “Just as my son Yalalt is growing and getting bigger each day, our business is also expanding with the support of the ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project team, mentors, and the soum Counsel.

Published in 2023

“Одоо ямар байшин барих нь биднээс шалтгаална. Бид ч хичээн ажиллаж байгаа” гэж тэд өгүүлсэн. “Ялалт кейк хаус” 2023 оны хүүхдийн баяраар нэг сая орчим төгрөгийн орлого олжээ.

Ц.Аззаяа “Ялалт хүү минь өдрөөс өдөрт өсөж, том болж байгаатай адил бизнес маань ч төслийн багийн хамт олон, чиглүүлэгч багш нар, сумын зөвлөлийн дэмжлэгтэйгээр өргөжин тэлж байна” хэмээн ярьсан юм.

2023 онд хэвлэгдсэн





## УЙГАГҮЙ ОРОЛДЛОГО, ЧИН СЭТГЭЛ, ХАМТЫН ЗҮТГЭЛ АМЖИЛТАД ХҮРГЭВ

Т.Цолмон 2020 оноос Ховд, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Говьсүмбэр аймагт хэрэгжиж байгаа “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадвар хөгжүүлэх (ESEL) сургалтын зөвлөх багшаар ажиллаж байна. Тэрээр, Ховд аймгийн Үенч сумын ерөнхий боловсролын сургуульд багшилж байхдаа хоёр удаагийн ESEL ангийг чиглүүлэн төгсгөжээ. Т.Цолмон монгол хэл бичиг, уран зохиолын багш мэргэжилтэй. Эдүгээ төслийн зорилтот сургуулийн нэг болох аймгийн Политехник коллежид мэргэжлээрээ ажиллаж байна. “Мянга нэгээс эхэлдэг” гэдэг шиг ESEL анги чиглүүлэх багшаар бэлтгэгдэх шийдвэр миний болон шавь нарын минь одоо

T. Tsolmon has been working as a teacher/counselor for the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, which has been implemented in Khovd, Zavkhan, Uvurkhangai, Sukhbaatar, and Gobisumber provinces since 2020.

She facilitated two ESEL training courses while working at a general secondary school in Uyenich soum, Khovd province. A teacher of Mongolian language and literature, T. Tsolmon currently works at the provincial Polytechnic College, one of the target schools of the project.

She began by sharing, “As the saying goes, a journey of a thousand miles starts with a single step, and I am confident that my decision to become an ESEL teacher/counselor has

## TIRELESS EFFORT, DEDICATION, AND TEAMWORK LEADS TO SUCCESS

ирээдүйн амьдралд эерэг үр нөлөө үзүүлж байгаа гэдэгт би итгэлтэй байдаг” гэж тэр яригаа эхэллээ.

### Хамтдаа суралцаж, сорилт бэрхшээлийг давсан

“Анх бэрхшээл их байлаа. 80 минутыг хэтрүүлэх, хичээлийн агуулгыг бүрэн заахын тулд 2 цаг 30 минут үргэлжлүүлэх тохиолдол ч байлаа. Үндсэн хичээлийн дараа залгуулаад ESEL сургалт заахад ядарч, шантармаар үе ч олон байсан. Хэдий тийм ч зогсолтгүй урагшилж чадсан. ESEL хөтөлбөрийн агуулгыг өөрийн болгож, сум, орон нутгийнхаа хүүхдүүдийн онцлог хэрэгцээ, ахуй амьдралтай уялдуулж заах гэх мэтээр төлөвлөлт, арга зүйгээ сайжруулсан. Ингэснээр хичээлийн агуулгыг цагтаа амжиж, бүрэн хүргэж чаддаг болсон юм. Хүүхдүүдийн маань оролцоо ч нэмэгдэж, сургалтын үйл ажиллагаанд илүү бүтээлч, санаачилгатай оролцож эхэлсэн. Багшид маш их урам зориг өгөлгүй яах вэ. Тиймээс эхний ангиа төгсгөөд дахиад анги чиглүүлэх шийдвэр гаргасан” гэж ESEL-ийн хоёр ангийг чиглүүлж, 48 сурагчийг амжилттай төгсгөсөн зөвлөх багш Т.Цолмон ярилаа. Тэрээр, зөвхөн төслийн сургалт, үйл ажиллагаанаас гадна үндсэн хичээлээ бэлтгэхдээ ч хүүхдийн оролцоог аль болох дэмжихийг хичээдэг. Хүүхдүүдээр санааг нь гаргуулж, хичээлийн үйл ажиллагааны алхам бүрт идэвхтэй оролцоог нь хангаж,

had a positive impact on my life and the lives of my students, both now and in the future.”

### Overcoming Challenges Through Study- ing Together

Tsolmon recalled encountering many obstacles in the beginning. There were times when her training sessions extended to 2 hours and 30 minutes, far exceeding the originally planned 80 minutes. She often felt exhausted and discouraged, especially after teaching regular school classes before transitioning to the ESEL training. To overcome these challenges, she adapted the content of the ESEL program to better meet the specific needs and lives of the children in the soum, improving her planning and teaching methodologies. These adjustments enabled her to deliver the full training content on time and as scheduled. This approach resulted in increased student participation, as the children began engaging more creatively and proactively in the training activities. Their active involvement gave her a great deal of encouragement and inspiration. As a result, the decision was made to conduct another round of training, and she successfully trained two additional ESEL classes, with a total of 48 students.

Tsolmon explained: “In addition to the project training and activities, we also strive to support the children’s participation as much as possible during regular classes. We encourage them to come up with their own ideas, ensure their active involvement at every step of the

сурагч төвтэй заах арга зүйтэй байхыг зорьж байна. Энэ чадвар нь хүүхдүүд хичээлдээ илүү дур сонирхолтой болох, тэгш оролцох боломжийг нэмэгдүүлдэг. Багшийн хувьд зөвлөх, чиглүүлэх үүрэг түлхүү гүйцэтгэснээр заах арга зүй, ур чадварын хувьд ихэд хөгжжээ. Зөвлөх багш Т.Цолмон хэлэхдээ “ESEL сургалт хүүхдийн оролцоо, идэвх, санаачилгад суурилдаг учир хүүхдэд цагийг зөв зохицуулах, төлөвлөх, шинэ санаа гаргах болон түүнийгээ турших боломж олгодог. Сурагчид өөрийгөө олж нээх, давуу, сул талаа таньж мэдэх, бусадтай хамтран ажиллах ур чадваруудтай болсон. Тэдэнд гарсан хувь хүний хөгжлийн өөрчлөлтүүд нь сурлагын амжилтад ч эергээр нөлөөлж байна” гэж онцлов.

Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Батхүрэл “Т.Цолмон бол манай сургуулийн шинийг сонирхож, тасралтгүй суралцдаг, бусад багш нар болон сурагчдад эерэг нөлөө үзүүлдэг манлайлагч залуу багш нарын нэг. ESEL сургалтын зөвлөх багш болсноор багшлах арга зүйгээ дээшлүүлж, эзэмшсэн мэдлэгээ сургуульдаа түгээж байгаад бахархаж байна” гэж ярилаа. Ховд аймгийн Үенч суманд нийт 10 багш ESEL сургалтын багш/зөвлөхөөр бэлтгэгдсэн юм. Тэд сургалтын төлөвлөлтөө хамтран бэлдэж, харилцан зөвлөлдөж, хамтдаа суралцсанаар эзэмшсэн арга зүйгээ түгээн дэлгэрүүлж байна.

## Төсөл чиглүүлснээр зорилгодоо нэг алхам ойртов

Т.Цолмон багш эхний удаа гурван төслийн багийг чиглүүлэн пич уралдаанд

lesson, and focus on applying a student-centered teaching methodology. This not only enhances their interest but also ensures equal participation in the lessons. Trainers have significantly developed their teaching methods and skills by adopting a more advisory and guiding role.”

She further emphasized that “ESEL training is centered around children’s participation, activity, and initiative, giving them the opportunity to manage their time properly, plan, generate new ideas, and test them. This has allowed the students to discover themselves, recognize their strengths and weaknesses, and work with others. These changes in their personal development have had a positive impact on their studies.”

S. Batkhurel, the principal of Uyench soum secondary school said, “Teacher Tsolmon is one of the leading young educators at our school. She is passionate about new ideas, constantly seeks to learn, and has a positive impact on both teachers and students. I am proud that she has enhanced her teaching methods and is now sharing her knowledge with the school community by becoming an ESEL teacher/ counselor.” A total of 10 teachers in Uyench soum, Khovd province, have been trained as ESEL teachers/ counselors. They collaborate to prepare their training plans, consult with one another, and share the methodologies they have learned within their schools.

## Facilitating the Project: One Step Closer to the Goal

Initially, Tsolmon counselled three project teams to participate in the Pitch Competition. Unfortunately, none of the project proposals

оролцуулсан ч нэг ч төсөл тэнцсэнгүй. Хүүхдүүдийн хувьд ч, чиглүүлж байгаа багшийн хувьд ч туршлага, бэлтгэл дутав. Гэвч шантралгүй дахин гурван төслийн багийн чиглүүлэгч багшаар ажиллаж, өмнө нь шүүгчдийн зүгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, дараагийн пич уралдаанд оролцжээ. Хөвгүүдийн санаачилсан зайрмаг үйлдвэрлэж, борлуулах зорилготой “Амтлаг өдөр” төсөл, охидын санаачилсан чин сэтгэлийн илгээмж хүргэх зорилготой “Сэтгэлийн зууч” болон хүүхдийн танин мэдэхүй, оюун ухааныг тоглоомын аргаар хөгжүүлэх зорилготой “Тархины цэнэг” төслийн багууд шалгарч санхүүжилт авч, төслөө амжилттай хэрэгжүүлсэн байна. Бичил төслүүд нь суманд анхдагч, сонирхолтой байсан хэдий ч хэрэгжүүлэх явцад худалдан авалт хийх, бараа бүтээгдэхүүнээ захиалж авчрах, санхүүгийн баримт бүрдүүлэх, бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэхэд зарим бэрхшээлтэй тулгарчээ. Ийм үед хамтдаа шийдэл олох явцад хүүхдүүдийн аливаа бэрхшээлийг даван туулах, бусадтай зөв харилцах, ойлголцох ур чадвар нь нэмэгдэж байсан ажээ.

Т.Цолмон төслийн чиглүүлэгч багш болсноор сурагчидтайгаа хамт санхүүгийн баримт бүрдүүлэх, орлого болон зарлагаа тогтмол тэмдэглэж сурах чадварт суралцав. Төсөл, сургалт чиглүүлэх явцдаа “Яагаад нэмэлт орлоготой болж болохгүй байх вэ” хэмээн бодож, Улаанбаатар хотод бийрэн бичгийн сургалтад хамрагдаж, сумандаа сургалт явуулж, мөн бялуу хийж, борлуулж эхэлжээ.

“ESEL сургалт, сурагчдынхаа бичил

were selected due to the lack of experience and preparation from both the students and the teacher. However, she didn’t give up. Instead, she continued to support and guide three more project teams, incorporated feedback from the judges, and participated in the next Pitch Competition.

In the competition: the Boys’ team behind the “Sweet Day” project proposal which aimed to produce and sell ice cream; the Girls’ team with the “Soul Mediator” project proposal focused on delivering heartfelt messages, and the “Brain Charge” project proposal, which aimed to enhance children’s cognitive abilities and intelligence through play, all emerged as winners. They received funding and successfully implemented their projects in the soum.

Although the subgrant projects were innovative and engaging, they faced several challenges during implementation, including purchasing supplies, ordering goods, preparing financial documents, and getting their products to market. However, the children’s ability to overcome these difficulties, communicate effectively with one another, and collaborate on finding solutions improved significantly as they worked together.

As Tsolmon took on the role of project mentor, she learned how to develop financial documents and track income and expenses alongside her students. While guiding the projects and conducting training, she asked herself, “Why not generate additional income?” Inspired by this thought, Tsolmon attended a calligraphy training course in Ulaanbaatar and later conducted her own classes in the soum. She also started baking and selling cakes.



төслийг чиглүүлснээр мэргэжлийн төдийгүй хувь хүний олон ур чадвар маань хөгжсөн гэж боддог. Өөрийгөө дайчилж, шинэ зүйлд суралцаж, нэмэлт орлоготой ч болсон. Гэр бүлийн гишүүдэд маань ч эерэгээр нөлөөлсөн” гэж Т.Цолмон багш өгүүллээ. Ховд аймагт 2020 оноос “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” (ESEL) сургалтын багш/зөвлөхөөр 92 багш бэлтгэгдсэн. 2024 оны байдлаар нийт зургаан удаагийн элсэлтээр 83 ангийн 1912 хүүхдэд хувь хүний ур чадвар хөгжүүлэх, энтрепренершип боловсрол олгож байна.

2024 онд хэвлэгдсэн

Tsolmon concluded, “Through the ESEL training and by mentoring my students’ projects, I’ve developed numerous professional and personal skills. I’ve been able to motivate myself, learn new things, and earn extra income. There have also been many positive outcomes for my family members.”

Since 2020, 92 teachers in Khovd province have been trained as ESEL teachers and counselors. As of 2024, 1,912 children across 83 classes are receiving personal skills development and entrepreneurship education through a total of six training cycles.

Published in 2024



“Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” (ESEL) сургалтын талаарх видеог монгол, англи хэлээр үзнэ үү.

Watch the video about the ‘Entrepreneurship-based Socio-Emotional Skills’ (ESEL) training in Mongolian and English.

## МӨРӨӨДӨЛ, ЗОРИЛГО НЭГТЭЙ ЭНТРЕПРЕНЕР КЛУБИЙНХЭН

### ENTREPRENEUR CLUB MEMBERS UNITING DREAMS, AND GOALS

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд таван аймгийн зорилтот сумдад нийт 41 энтрепренер клуб ажиллаж байгаагийн нэг нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн энтрепренер клуб юм.

Эдгээр сурагчид бол тус клубийн гишүүд. Хүсэл эрмэлзэл, зорилго, мөрөөдөл, сонирхол дор нэгдэж, үе тэнгийн хүүхэд багачууд, насанд хүрэгчид, орон нутагтаа сайн сайхныг бүтээн бэлэглэгчид юм. Тэд бахархалт үйлээсээ урам зориг авдаг. Харин энэ бүхэн тэдний суралцаж төгссөн, өөрчлөлт, шинэчлэлийн эринд амьдрах иргэдэд нэн хэрэгцээтэй багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох зэрэг олон ур чадварт сургаж, мэдлэг олгодог ESEL хөтөлбөрөөс эхлэлтэй. Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуульд Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл амжилттай хэрэгжиж, ESEL хөтөлбөрийн төгсөгч 9-12 дугаар ангийн сурагчид саналаараа энтрепренер клуб байгуулжээ.

**Клубийн ахлагч, 12 дугаар ангийн сурагч Б.Бундмаа: Эцэг, эхээ баярлуулсан**

Within the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project implemented by Save the Children, 41 Entrepreneur Clubs were established across the target soums of 5 provinces. One of these clubs is the Entrepreneur Club located at the Gunzgii secondary school in Kharkhorin soum, Uvurkhangai province.

These students, members of the club, share a common aspiration, goal, dream, and interest. Motivated to contribute positively to their peers, community, and society, they strive to create something they can be proud of. Their journey began with the ESEL program, which equipped them with skills and knowledge including teamwork, self-expression, and understanding others, which are essential skills for individuals navigating an era of change and reform. Save the Children successfully implemented the Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia project at the Gunzgii secondary school in Kharkhorin soum. After completing the ESEL program, some students decided to start the Entrepreneur Club on their own. The club is made up of students from grades 9 to 12.

**Club leader, 12th grade student B. Bundmaa: Parents are happy now.**

First, we held a training session to inform parents about the ESEL program, which was part

Бид Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL хөтөлбөрөөс сурсан зүйлүүд болон клубийнхээ талаар эцэг, эхчүүдэд танилцуулж, уулзалт зохион байгуулсан. 2024 онд клубийн гишүүдийн тоо нэмэгдсэн учир гишүүд хоорондоо харилцан суралцах, мэдээлэл солилцох зорилгоор “Team bonding” арга хэмжээ санаачлан, төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгуулсан. Эцэг, эхчүүд хүүхдүүдээ ингэж хөгжин суралцаж байгаад үнэхээр баярлаж байсан.

Тэдний зохион байгуулсан “Team bonding” арга хэмжээ нь клубийн гишүүдийн эв нэгдлийг хангаж, итгэлцэл бий болгох, бие биеэ илүү сайн мэдэх, эерэг уур амьсгал бүрдүүлэх, дурсамж бүтээх, багийг нэгтгэн бүрдүүлэхэд чухал үүрэгтэй байв. Гишүүд хамтдаа аливаа асуудлыг шийдэх, сорилт бэрхшээлийг даван туулахад нэгдмэл байх боломж бүрдүүлжээ. Энтрепренер клубийн гишүүдэд бусдаас давуу тал олон бий. Тэд ESEL хөтөлбөрөөр үр чадвараа хөгжүүлж, санхүү, бизнесийн ухаанд суралцан, төсөл бичиж, санхүүгийн тэтгэлэг аван бизнесийн санаагаа хэрэгжүүлж байгаа сурагчид юм.

Энтрепренер клубийнхэн өөрсдийгөө хөгжүүлэх, сургууль, орон нутгийн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд хувь нэмэр оруулахыг хичээж, олон үйл ажиллагаа зохион байгуулдаг. Тухайлбал, Өвөрхангай аймагт байгуулагдах Ид шидийн оронд хандив босгох аян амжилттай өрнүүлжээ. “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аян сургууль дээрээ дэмжин ажиллаж, “What3Words” байршил тогтоох аппликейшныг нутгийн иргэддээ

of Save the Children’s project called, “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia.” We shared what we learned in the program and introduced our club. Additionally, in 2024, we saw an increase in the number of club members. To foster teamwork and unity among members, we organized Team bonding events with the financial support of the project. These events were successful in promoting learning and information exchange among club members. Parents of club members have expressed positive feedback about their children’s self-development through the club.

The Team bonding events they organized played a crucial role in fostering unity and trust among club members. It provided an opportunity for members to deepen their connections, create a positive atmosphere, and build lasting memories together. Moreover, the event facilitated teamwork and problem-solving skills, empowering members to tackle challenges collectively. Members of the Entrepreneur Club have several advantages over others. They have sharpened their skills through the ESEL program, gained knowledge in finance and business, developed project proposals, secured grants, and are actively implementing their business ideas.

The Entrepreneur Club is actively involved in various activities focused on self-development and addressing school and community issues. For instance, they are planning to organize the “Magic Land Fundraising” campaign in Uvurkhangai province this summer. Additionally, the school supported the “Bullying Should Not Spread” campaign and promoted the what3words application to residents. Moreover, information leaflets containing new English words and messages promoting kindness have been placed in the school’s

түгээж байгаа юм. Сургуулийнхаа ариун цэврийн өрөөнд мэдээллийн хуудас байршуулж, англи хэлний шинэ үг, сайн үйлсийн уриалга гэх мэтийн өргөн хүрээтэй мэдээллийг хүүхдүүдэд түгээх болжээ. Клубийн үйл ажиллагаа сайн дурынх болохоор гишүүдийн оролцоо чухал. Тиймээс тухайн ажлаасаа шалтгаалаад багаар хуваагдаж, дотоод зохион байгуулалт хийдэг байна.

### Клубийн шинэ ахлагч, 9 дүгээр ангийн сурагч Л.Золзаяа: Бүгдийг төлөвлөдөг тул бэрхшээл бага гардаг

Энтрепренер клубийн гишүүд 2 долоо хоногт нэг удаа 2 цаг хүртэл хугацаатай уулзаж, багаараа ярилцан, ажлын төлөвлөгөө гаргана. Зарын чанартай

restrooms to benefit children. Given that the club operates on a voluntary basis, member participation is crucial. Therefore, the club assigns different tasks to teams of participants to ensure everyone is involved.

### New leader of the club, 9th grade student L. Zolzaya: Because we plan well, we encounter fewer problems

Members schedule bi-weekly meetings lasting up to 2 hours, during which they collaborate as a team to develop a work plan. Important announcements and information are shared in the Youth Entrepreneur Club social media group. Meetings typically take place in the library or a vacant classroom. Taking into account factors like funding and time, they select tasks they can manage. The club



мэдээллээ “Өсвөрийн Энтрепренер клуб” группэд байршуулна. Уулзалтаа номын сан, сул чөлөөтэй анги танхимд хийнэ. Мэдээж, санхүүжилт, хугацаагаа тооцоолж аль болох боломжтой ажлуудаа сонгодог. Тиймээс бэрхшээл бага гардаг. Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа сургуулийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлдэг.

Энтрепренер клубийн гишүүдийн зарим нь төгсөх ангийн сурагчид учир шинээр ахлагч, дэд ахлагчийг гишүүдээсээ сонгож, үйл ажиллагаагаа залгамжлуулжээ. Илүү урт хугацаанд, тууштай ажиллах байдлыг тооцоолж, 9 дүгээр ангийн Л.Золзаяа, Б.Сумьяасүрэн нарыг сонгов. Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн сурагчид клубийн гишүүдийг завгүй, нийгмийн идэвхтэй, бүтээлч хүүхдүүд гэж хүндэлдэг аж. Тус сургуульд ESEL сургалт төгссөн хүүхдүүдийн “Morty”, “Papertown”, “Granola”, “Polypop”, “Doctor colors” зэрэг төслүүд амжилттай хэрэгжиж байна. Клубийнхэн “Morty”, “Doctor colors” төслийн багийнхантай хамтран “Хайртай хувцсаа дахин амилуулъя” арга хэмжээ зохион байгуулжээ.

2024 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан төслийн уралдаанаас 9-10 дугаар ангийн сурагчдын LYRA багийн Bath bomb төсөл шалгаран 3.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаагаа эхлүүлсэн аж. Тус төслийн банны бөмбөлөг, давс үйлдвэрлэх үйл ажиллагааг клубийн хүүхдүүд мөн дэмжин ажиллаж, хайрцаг сав бэлтгэхэд тусалж байна.

### Нийгмийн ажилтан Н.Долгосүрэн: Гишүүдийн оролцоонд тулгуурлана

Би өсвөрийн энтрепренер клубийн чиглүүлэгч багшаар ажиллаж байна.

encounters few obstacles. Updates on ongoing activities are regularly published on the school's website.

Since some members of the Entrepreneur Club are graduating students, it was decided to appoint new leaders and deputy leaders from among the remaining members to ensure continuity of activities. After careful consideration of their long-term dedication and consistent efforts, students L. Zolzaya and B. Sumyasuren from the 9th grade were chosen as the new leaders and deputy leaders, respectively.

Students at the Kharkhorin soum Gunzgii secondary school perceive club members as industrious, socially engaged, and innovative individuals. Projects like Morty, Papertown, Granola, Polypop, and Doctor Colors are being effectively carried out by students who have completed ESEL training at the school. Collaborating with the Morty and Doctor Colors teams, club members organized the event “Let's Bring Your Beloved Clothes Back to Life.”

In the grant competition held in March 2024, the LYRA team, consisting of 9th and 10th-grade students, received a 3.5 MNT small grant for their “Bath Bomb” project proposal and initiated project activities. Additionally, club members are lending their support to the production of bath bombs and bath salt as part of the project, as well as assisting in the preparation of packaging boxes.

### Social worker N. Dolgorsuren: Entrepreneur club activities are based on members' participation.

I work as a training facilitator for the Youth Entrepreneur Club, where we carry out our activities based on the interest and engage-

Клубийн үйл ажиллагаа гишүүдийнхээ сонирхол, оролцоонд тулгуурлаж байгаа. Жил бүрийн 10 дугаар сард хичээлээс гадуурх үйл ажиллагаа эхэлдэг. Сурагчид маань 2022 оны намар клубээ 11 гишүүнтэй байгуулж байсан бол одоо 30 гишүүнтэй болсон байна. Миний хувьд шаардлагатай үед нь зөвлөгөө өгч, дэмжиж ажилладаг. Хүүхдүүд санаачилсан үйл ажиллагаандаа идэвхтэй оролцож, илүү үр дүнд хүрч байна гэлээ.

Сурагчид оролцоондоо тулгуурлан энтрепренер клуб байгуулах, үйл ажиллагаа явуулах, нэгдэх, хамтарч ажиллах нь амжилт, сайн эхлэл юм. Энтрепренер буюу entrepreneur гэдэг үг нь франц хэлний хийх, оролдох гэсэн утгатай entreprendre гэсэн үйл үгнээс гаралтай гэдэг. Сурагчид ийнхүү клубээрээ дамжуулан нийгэмд тулгарч байгаа аливаа бэрхшээлийг эерэгээр шийдвэрлэх эрэл хайгуул хийж байна.

ment of our members. Every October, extra-curricular activities kick off in schools. In the autumn of 2022, students formed a club with 11 members. Since then, our membership has steadily grown, and we now have 30 active members. I provide guidance and support to the students as needed. Through active participation in the activities they initiate, the children consistently achieve better results.

The fact that students collaborated with each other to establish the Entrepreneur Club and conduct activities is itself a remarkable achievement and an auspicious beginning.

Interestingly, the term ‘Entrepreneur’ originates from the French verb ‘entreprendre’, meaning ‘to do’ or ‘to try’. Hence, students are actively seeking solutions to the challenges encountered by children, citizens, and society through the clubs they've formed.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Энтрепренер клубийн талаарх видеоог монгол, англи хэлээр үзнэ үү.

Watch the video about the Entrepreneur Club in Mongolian and English.





## ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР SMALL GRANT PROGRAMS







## ЭРВЭЭХИЙ “НИСЭЛДСЭН” ХҮСЛИЙН ӨРГӨӨ

### Эрх чөлөөт орчин, хүсэл мөрөөдөл мэдрүүлнэ

Завхан аймгийн Тэс суманд хаврын урин цагтай зэрэгцэн үйлчилгээний нэгэн шинэ газар үүдээ нээсэн нь “Номын кафе” байв. Сурагч Г.Цэнгүүн, Б.Нандин-Эрдэнэ, Д.Чингүүн, А.Азжаргал, Э.Тэмүүлэн нар “Butterfly” төсөл бичсэн нь шалгарч энэхүү кафег байгуулжээ. Эдгээр сурагчид “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL сургалтад хамрагдан, нэг баг болж, бичил төслийн уралдаанд бизнесийн санаагаа танилцуулан санхүүжилт авсан байна.

In the spring, a new service center called the “Book Cafe” opened in Tes soum, Zavkhan province. The cafe was established by students G. Tsenguun, B. Nandin-Erdene, D. Chinguun, A. Azjargal, and E. Temuulen through their “Butterfly” project. These students participated in the ESEL training of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, where they formed a team, developed their business ideas, presented them in a subgrant competition, and received funding.

Let me share how they conducted their research, wrote their project proposal, secured funding, and overcame the challenges they faced.

## BUTTERFLIES WILL MAKE YOU FEEL FREE AND LIVE YOUR DREAMS

Тэд хэрхэн судалгаа хийж, төслөө бичиж, санхүүжилт авсан, ямар сорилт давсан талаар өгүүлэе.

Хөдөөгийн алслагдсан сумын сурагчдад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хичээлээ хамтран давтах тохилог газар ховор гэдгийг багийн сурагчид анзаарч, судалгаа явуулжээ. Судалгаанд оролцсон олонхи сурагч тав тухтай орчинд цагийг үр бүтээлтэй ашиглаж, хөгжих газар хэрэгтэй гэж хариулснаар “Butterfly” баг бизнес санаагаа хэрэгжүүлэх боломжтой гэдгийг мэдэрч, нэгэн зорилго дор нэгджээ. Тэд сурагчдад хувийн, чөлөөт орон зай өгснөөр хувь хүний хөгжилд нь тусалж чадна гэж итгэжээ. Энэ шийдвэр нь зөв байв. “Butterfly” багийнхан бичил бизнесээр ашиг олохоос илүүтэй найз нөхдөдөө тав тух, эерэг мэдрэмж төрүүлж байгаадаа баяртай байдаг юм.

Төслийн сумын зөвлөлөөс эдгээр сурагчдад ахуйн үйлчилгээний хэсгийн зай талбай сайтай өрөөг ашиглах боломж олгосноор бичил бизнесийн суурь тавигджээ. Сурагчид төслөөс авсан эхний санхүүжилтээр өрөөгөө тохижуулж, кафед уншуулах номуудаа худалдаж авчээ. Орчноо тохижуулах ажилд үйлчлүүлэгчдээ татан оролцуулах идэвхжүүлэлтийн арга нэвтрүүлсэн байна. Үйлчлүүлэгчид хүсвэл хана, таазнаас унжуулж, байршуулсан том, жижиг эрвээхийн дүрсийг будаж, тохижилтод хувь нэмрээ оруулах боломжоор хангасан нь өвөрмөц байв. Энэ санаачилга нь орчны тохижилтод тустайгаас гадна хамгийн гол

The students conducted a study after noticing that students in remote rural soums often lack comfortable spaces to spend their free time and study together. Most respondents expressed a need for such a space to spend their time more productively and focus on personal development. In response, the “Butterfly” team decided to bring their business idea to life.

They believed that creating a personal space for students would positively contribute to their development. This proved to be the right decision. Members of the “Butterfly” project team shared that they find more satisfaction in bringing comfort and positive experiences to their peers than in making a profit from their micro-business.

Project Soum Level Council (SLC) of the project provided students with the opportunity to use a large room in a utility building, laying the foundation for their small business. The first round of project funding was used to renovate the space and purchase books for reading in the café. The project team introduced an interactive element that invited customers to contribute to the space’s transformation. Visitors were given the opportunity to paint butterflies, which were hung on the walls and ceilings, offering a unique experience. This initiative was separate from the space renovation, and the butterflies symbolized freedom, serving as an inspiration for children to embrace learning and personal growth.

At the Book Cafe, students pay 800 MNT

нь эрвээхийнүүд хүүхдүүдэд эрх чөлөөг мэдрүүлж, сурч хөгжих хүсэл мөрөөдөл төрүүлдэг ажээ.

“Номын кафе”-д сурагчид цагт 800 төгрөг төлж, хичээлээ давтах, халуун цай үнэгүй уух, найзуудтайгаа ярилцах, ном унших боломжтой. Шинэ ном унших хүсэлтэй бол тухайн цагтаа авах эрхтэй. Түүнчлэн хичээлээ давтаж буй сурагчдын дэвтэр, үзэг бал дуусвал тус кафе байрлах бичиг хэргийн булангаас худалдан авах боломжтой юм. Тус кафе байнгын үйлчлүүлэгчтэй болох зорилгоор урамшуулалт үнийн санал нэвтрүүлсэн бөгөөд 2 цаг нь 1500 төгрөг, 3 цаг нь 2200 төгрөг, 4 цаг нь 2900 төгрөг байхаар тариф боловсруулснаар үйл ажиллагаа явуулагч, үйлчлүүлэгч хоёр талдаа сэтгэл хангалуун болжээ.

**2023 оны 3 дугаар сарын 9-ний өдрөөс хойш нийт 205 хүнд тус үйлчилгээ хүрсэн байна.**

“Бид ESEL сургалтаас олон талын мэдлэг олж авсан. Цагийн менежментээ зөв төлөвлөх, багаар ажиллах, урьдчилан тааварлах боломжгүй сорилтыг олон талаас нь харах үр чадварт суралцсан”

per hour to do their homework, enjoy free hot tea, and socialize with friends. They can also pick up a new book to read during their visit. Additionally, students working on their homework can purchase notebooks and pencils from the café’s stationery corner if they run out of supplies.

To attract more regular customers, the café introduced promotional pricing. For example, they offer 1,500 MNT for 2 hours, 2,200 MNT for 3 hours, and 2,900 MNT for 4 hours. As a result, both the service provider and the customers have been satisfied with the arrangement.

**A total of 205 people have been served at the “Book Café” since March 9, 2023.**

“We gained valuable knowledge from the ESEL training. We learned how to improve our time management skills, how to work as a team, and developed the ability to anticipate unexpected challenges from different perspectives,” said the project team.

During the implementation of their project, they faced challenges such as fluctuations in the prices of goods they needed to purchase, which forced them to reduce the number of

хэмээн тэд ярилаа. Тэднийг төслөө хэрэгжүүлэх явцад худалдаж авах бараа бүтээгдэхүүний санхүүгийн тооцоонд үнийнөөрчлөлт гарч, тооширхэгээ багасгах зэрэг асуудлууд тулгарчээ. Мөн дотоод засал чимэглэлд төлөвлөөгүй зардал нэмэгдэв. Гэвч тэд багаараа ярилцаж, тулгарсан сорилтыг ухаалгаар шийдсэн аж. Сурагчид бичил төсөл бичихдээ санхүүгийн тооцоогоо маш бодитой гаргаж, багийн гишүүдийн саналыг сонсож, сайтар зөвлөж ярилцсанаар ямар ч бэрхшээлийг даван туулах боломжтой гэдгийг бусдад үлгэрлэсэн юм. “Butterfly” багийнхан мөн фэйсбүүк хуудас ажиллуулдаг бөгөөд тэдний үйл ажиллагааг Завхан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төв дэмжиж, номын хандив цуглуулж илгээсэнд баярлан хүлээн авч, аливааг хийхээр зоригловол дэмжих, ойлгох хүн олон байдаг, гагцхүү зогсолтгүй л хүсэж тэмүүлэх ёстой юм байна гэдгийг ойлгожээ.

“Butterfly” багийнхан ESEL сургалтаас бичил төсөл хэрэгжүүлэх, багаар ажиллах, ногдсон үүргээ ухамсарлах, бусдыг сонсож сурах, санаагаа илэрхийлэх, аливаад нээлттэй хандах зэрэг олон чадварт суралцаж, их ч зүйлийг сурч мэджээ. Энэ бүх чадвар тэднийг насанд хүрсэн хойно ч, ажил амьдралд гарсан ч оюуны томоохон хөрөнгө оруулалт болон үлдэх биз ээ.

items they had initially planned to buy. They also encountered unplanned expenses for interior decoration, but the team managed to handle this by making smart decisions. The team members demonstrated that by making realistic financial calculations, listening to each other’s opinions, and discussing solutions collaboratively while developing the project proposal, that any difficulties could be overcome.

The team also manages a Facebook page. When the Youth Development Center of the Department of Family, Children, and Youth Development in the Zavkhan province capital enthusiastically supported them by collecting and donating books, they gratefully accepted the gift. The team realized that if they are brave enough to pursue their goals, many people will offer support and understanding—they just need to keep fighting for their dreams.

The “Butterfly” team gained a wealth of knowledge from the ESEL training, including how to implement subgrants, work effectively in a team, understand their responsibilities, listen to others, express themselves clearly, and remain open-minded. All of these skills will serve as a valuable intellectual investment as they grow and begin their professional careers.

Published in 2023

2023 онд хэвлэгдсэн



Завхан аймагт хэрэгжсэн бичил төслүүдийн түүхийг монгол хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented in Zavkhan province in Mongolian.



## БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭТЭЙ ХҮҮХДҮҮД

### CHILDREN WITH CREATIVE MINDS

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн зорилтот бүлгийн төлөөлөл болох Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн “Радио электроник” төслийн үйл ажиллагаа, сайн туршлагыг танилцуулъя. Уг төсөл нь 2022 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан “Энтрепренер Seeds” тэтгэлэгт уралдаан буюу “Пич-3” арга хэмжээнд амжилттай оролцон гурван шатны шалгаруулалтад тэнцэж гарааны санхүүжилт авсан юм.

### Сурагчдын техник сэтгэлгээг хөгжүүлж байна

Өвөрхангай аймгийн Хархорин сум Улаанбаатар хотоос 430 км зайтай, жилдээ нийт 15,000 хүнд нийгэм, эдийн засгийн үйлчилгээ үзүүлдэг, шилжих хөдөлгөөн ихтэй, төвийн болон орон нутгийн томоохон авто зам дамжин өнгөрдөг, аялал жуулчлалын бүс нутаг юм. Тус суманд ерөнхий боловсролын дөрвөн сургуульд 3,000 орчим хүүхэд суралцаж байна. Бүс нутгийн онцлог гэвэл, байнгын шилжилт хөдөлгөөнтэй, олон төрлийн харилцаа холбоотой, дэд бүтцийн хөгжил сайн учир хүүхдүүдийг тал бүрээс хөгжүүлэх хэрэгцээ тулгарч байна. Өнөө цагт бид өдөр тутамдаа техник, технологийн хэрэглээ, дэвшилтэт бүтээгдэхүүний тусламжтай бусадтай илүү ухаалгаар харилцаж, ойлголцох нөхцөл үүссэн байна. “Радио электроник” төслийн “Elite team” багийн гишүүд О.Тэмүүжин,

Here we present the activities and successful experience of the “Radio Electronics” project of Kharkhorin Soum General Secondary School No. 2, Uvurkhangai province. The high school students who completed the ESEL training program of the project “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” participated in the “Entrepreneur Seeds” small scale funding competition or Pitch 3 event held in May 2022, and received initial funding for their innovative project.

### Radio Electronics Project Aims to Develop Students' Technical Mindset

Kharkhorin Soum, situated 430 kilometers from Ulaanbaatar, is a vibrant tourist destination with well-established social and economic services. The number of visitors exceeds 150,000 annually, and there is a high flow of people passing through the soum due to major national and regional roads running through its center. This soum has four schools with over 3,000 students

Given the region's unique characteristics, such as the constant flow of visitors, diverse communication channels, robust infrastructure development, and widespread technology usage, children today face the need for comprehensive development. Acknowledging the significance of nurturing children in this technologically advanced era, the “Radio Electronics” project is led by O. Temuujin, S. Gombodorj, and S. Altantsetseg, members of



Ш.Гомбодорж, С.Алтанцэцэг нар техник, технологийн өндөр хурдацтай энэ цаг үед сурагчдын техник сэтгэлгээ, сонирхлыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх замаар бүтээлч, ирээдүйн инженер болж төлөвших суурийг тавих томоохон зорилго өвөртөлжээ. Тэд технологийн багш Цэндээхүүгээс арга зүйн дэмжлэг авч, чиглүүлэгч багшаар Д.Мягмарсүрэн ажиллаж байна.

### Робот угсрах аргачлал шинэлэг, үр дүнтэй

Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр тодорхой агуулга ерөнхий боловсролын сургуулийн сургалтад багтсан байдаг ч хэрэглэгдэхүүний үнэ өндөр, орон нутагт олдоц ховор. Тиймээс агуулгыг илүү дэлгэрэнгүй судлах нөөц боломж, дугуйлан, сургалт байхгүй юм. Энэ хоосон орон зайг нөхөж чадсан нь

the “Elite team”. The project aims to establish a foundation for cultivating future creative engineers. Through this initiative, young entrepreneurs strive to foster a technical mindset among students and provide them with opportunities to engage in creative and productive activities in the field of radio electronics. The project team receives guidance from D. Myagmarsuren, an ESEL teacher/counselor, and methodological support from Tsendekhuu, the technology teacher.

### The Robot Course is Innovative and Effective

The current secondary school curriculum includes modules designed to foster students' creativity. However, the depth of learning in this area is hindered by the high cost and limited availability of technical materials in rural areas. The Radio Electronics project offers a creative business solution that could address



“Радио электроник” төслийн шинэлэг санаа байв. Төслийн багаас аль болох уян хатан, үр дүнтэй байх нөхцөлийг хангаж ажилладаг нь гол зорилгоо биелүүлэхэд үр дүнтэй байж чаддаг. “Elite team” баг хэрэглэгчдэдээ аргачлал заах сургалт (электрон тоглоом угсрах аргачлал, техникийг заана), практиктай хосолсон сургалт (электрон тоглоом угсрах аргачлалыг туршилттай хослуулан заана)-ын үйлчилгээ санал болгодог. Үүнээс гадна суралцагч төгсөхдөө өөрийн гэсэн тоглоомтой болсон байх юм. 2022 оны 9 дүгээр сард гарааны санхүүжилт авч, шаардлагатай хэрэглэгдэхүүнээ худалдаж авснаар 10 дугаар сард “РЭД” төслийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн байна. О.Тэмүүжин, Ш.Гомбодорж нар үндсэн сургалтын үйл ажиллагааг, Э.Ундрах сургалтын хөтөлбөр боловсруулах,

these gaps in the current secondary school curriculum in rural areas.

Furthermore, there were no other student clubs focusing on radio electronics, making the project unique and innovative. The project team strives to be flexible and efficient in order to achieve the project’s primary goals and meet customer expectations.

The Elite team offers the following services to its customers:

Methodology training: This includes teaching various methods and techniques for assembling electronic toys.

Practical training: Students are provided with hands-on experience by combining the assembly of electronic toys with conducting experiments. By the end of the training, each student will have created their own toy.

хуваарь гаргах, С.Алтанцэцэг маркетинг, сурталчилгааны ажлыг хариуцан ажилладаг ажээ.

### Гурван удаагийн элсэлтээр 42 сурагч төгсөв

Ерөнхий боловсролын бусад сургуулийн технологийн багш нар “Elite team” багийн гишүүдтэй хамтран ажиллах хүсэлт гаргадаг бөгөөд зочин багшаар уригдаж, хамтдаа суралцаж байгаа юм.

“Бид өөрсдийн мэдлэг чадварыг түгээхдээ харилцан суралцах байдлыг эрхэмлэн, үе тэнгийнхэн, ах эгч, дүү нартайгаа хамт хөгжиж байгаадаа талархалтай байдаг” хэмээн тэд ярьсан. Үйл ажиллагааны үр дүн, ахиц амжилтыг дүгнэх чухал зүйлсийн нэг нь “Радио электроник” төслөөс үр шим хүртэгч болон сонирхогчдын сэтгэгдэл, урам зориг юм.

Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүн О.Тэмүүжиний аав Оюунболд: Төслийн ажилтай, төсөл бичиж байгаа, сургууль дээр ажилтай гээд гэртээ ч ирэх завгүй байсан хүү маань санаанд багтамгүй зүйлийг хийсэн байгаа нь үнэхээр бахархалтай байна. Робот угсарна гэдэг нь зөвхөн мундаг техник сэтгэлгээтэй, тусгайлан сурч боловсорсон хүний хийдэг зүйл л гэж боддог байлаа. Гэтэл миний хүү чадсан байна. Их баяртай байна. Цаашид бүхий л боломжоороо хүүгээ, багийнхныг нь дэмжинэ.

Сургалтад хамрагдсан сурагч О.Жавхлан: Би сонирхлоо хөгжүүлэхийн тулд заавал хотод очиж сургалтад хамрагдах, эсвэл хэдэн цагаар ч хамаагүй YouTube бичлэг үзэж суухаас өөр сонголт байдаггүй байсан. Харин одоо хоббитойгоо ойрхон байна гэдэг үнэхээр гоё байна.

After receiving initial funding and procuring the necessary materials in September 2022, the “Radio Electronics” project officially launched in October 2022. O. Temujin and Sh. Gombodorj are responsible for the main training activities. E. Undrakh oversees curriculum development and scheduling, and S. Altantsetseg manages marketing and advertising.

**Since its launch, the project has attracted 42 students across three classes, significantly benefitting both the project team members and participants.**

The project’s success has garnered the attention of technology teachers from other high schools, who have expressed interest in collaboration and have been invited as guest teachers, thereby expanding the learning opportunities for all involved. They prioritize learning together and are happy to grow together with their peers. The testimonials and enthusiasm from beneficiaries and interested parties of the “Radio Electronics” project play a crucial role in evaluating the results and progress of the initiative. Here are some statements highlighting their appreciation: Oyunbold, the father of Temujin, a member of the project team, expressed his immense pride in his son’s accomplishments. He shared, “I am incredibly proud of my son who dedicated his time to project development and spent long hours at school. He has achieved something unimaginable. I used to believe that creating robots required exceptional technical skills and specialized education. But seeing my son involved in this project brings me great joy. In the future, I will provide unwavering support to my son and his team in any way I can.”

O. Javkhlan, a student who participated in the training, expressed, “Prior to joining the proj-





## Тогтвортой, ахисан түвшний хөгжил чухал

Төслийн багийнхан үндсэн хичээл, сургалтын зэрэгцээ төслийн үйл ажиллагааг төлөвлөн, цагийн хуваариа маш нарийн гаргаж, сургалтад хэрэгцээтэй хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэх, сургалт, маркетингийн ажлыг тогтмол зохион байгуулах гэх мэт өндөр түвшний хувийн болон багийн зохион байгуулалт хийснээр өөрсдийн хувийн ажлаа амжуулж, гэрийн даалгавраа хийх зэргээр цагийг бүтээмжтэй өнгөрүүлэх, сурагчдын ахицыг үнэлэх, сонирхолтой аргазүйг судлах, бусадтай хамтран ажиллах, арга туршлагаа хуваалцах үр чадваруудаа нэмэгдүүлж олон талт байдлаар бүгд хөгжиж байна. Төслийн санхүүжилтээр сургалтад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүн (робот тоглоом угсрахад шаардлагатай хэрэглэгдэхүүн)-ийг худалдан авсан нь сургуулийн орчинд шинэлэг сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах боломж бүрдүүлж чаджээ.

“Радио электроник” төсөл нь зөвхөн сургуулийн төдийгүй сум, аймгийн нүүр царай болохуйц, онцлох сайн туршлага бүхий төсөл болсонд гишүүд нь баяртай байдаг. Нөгөө талаас маш том үүрэг хариуцлага учир илүү их хичээх хэрэгтэй гэж хүүхдүүд ярих.

Багийн ахлагч О.Тэмүүжин аймгийн технологийн олимпиадад сургуулиа төлөөлөн амжилттай оролцож, МУБИС, ДУТС-д элсэн орох хоёр ч урилгыг зэрэг хүлээн авчээ.



Өвөрхангай аймагт хэрэгжсэн бичил төслүүдийн түүхийг монгол хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented in Uvurkhangaï province in Mongolian.

ect, I had limited options for developing my interests. I either had to travel to the city for trainings or spend hours watching YouTube videos. However, now it's wonderful to have my hobby accessible and within reach.”

## Sustained, advanced-level development holds significant importance

In addition to the main training task, the project team plans the project activities, allocates the time schedule very precisely, prepares the materials needed for the training in advance, organizes the training and marketing activities at a high level, etc. All of them are developing in a multifaceted manner by increasing their skills to be productive, evaluate student progress, explore interesting methods, collaborate with others, and share their experiences. The project funding has enabled the purchase of educational materials necessary for assembling robot toys, providing students with innovative learning resources within the school environment.

The project has become a point of pride not only for the school, but also for the Soum and Uvurkhangaï province. The students recognize the responsibility that comes with this recognition and are motivated to continue striving for excellence.

O. Temuujin, the leader of the project team, represented his school successfully in the provincial technology Olympiad with his work, earning an invitation to enroll in the School of Fine Arts and Technology at Mongolian National University of Education.

## УТСААР БИШ УРД УРДААСАА ХАРЖ НӨХӨРЛӨӨ

## BUILDING FRIENDSHIPS FACE TO FACE, BEYOND SMART-PHONE SCREENS

### Санаачилгаас төсөл рүү, төслөөс амьдрал руу

Хүүхдийг Ивээх Сан “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийг 2020 оноос Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт хэрэгжүүлж байна. Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд төслийн хүрээнд ESEL сургалтууд амжилттай зохион байгуулагдаж, төгсөгчид нь нийт 12 төсөл хэрэгжүүлж байгаа юм. Тэдгээрийн нэг болох “Fun day” төслийн амжилтын түүхийг танилцуулъя.

### ESEL сургалтаас их зүйлийг сурсан

Намайг О.Энхбаяр гэдэг. Би 18 настай. ШУТИС-ийн нэгдүгээр дамжааны оюутан. Би 2022 оны хавар “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершипболовсрололгох”төслийн ESEL сургалтад хамрагдсан юм. Цагийг зөв зохистой ашиглаж, санхүү тооцоо гаргаж, тайлан бичиж, бусадтай хамтран ажиллах чадваруудаа илүү сайн хөгжүүлсэн. Бас олон найзтай ч болсон. Тэдний зарим нь манай “Fun day” төслийн багийн гишүүд. Бид хүсэл мөрөөдөл, санаачилгаа цаасан дээр буулгаж, төсөл болгон бичиж, түүнийгээ амьдралд хэрэгжүүлсэн азтай хүүхдүүд гэж боддог. Манай багийнхан ESEL сургалтаас харилцаа хандлага, танин мэдэх, шинийг эрэлхийлэх, бусдыг ойлгох зэрэг олон чадвар эзэмшсэн. Сүүлийн жилүүдэд хүүхэд залуучууд бүгд ухаалаг

### From Initiative to Project, and From Project to Reality

Since 2020, Save the Children has been implementing the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project across Khovd, Zavkhan, Uvurkhangaï, Gobisumber, and Sukhbaatar provinces. As part of the initiative, ESEL training sessions have been successfully held in Shiveegobi soum of Gobisumber province. The graduates of this training program have launched a total of 12 small business projects (Subgrants). Here's a success story from one of them: the “Fun Day” project.

### There's So Much I Learned from the ESEL Training

My name is O. Enkhbayar, and I'm 18 years old. I'm currently a first-year student at the Mongolian University of Science and Technology. In the spring of 2022, I participated in the ESEL training as part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. This training helped me develop valuable skills in time management, financial accounting, report writing, and teamwork. I also had the chance to make many new friends, some of whom are now part of the “Fun Day” project team. We feel fortunate to be among those who have turned our dreams and ideas into real projects by writing proposals and bringing them to life.

утас барьж, найз нөхөд, гэр бүлийн амьд харилцаа өдөр ирэх тусам багассан. Бид ярилцаад сургуулийнхаа суралцагчдын амьд харилцааг бэхжүүлэх замаар, гэр бүл, найз нөхөдтэйгөө хичээлээс гадуурх чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж, оюуны болон спорт тоглоомоор тоглох орчин нөхцөл бий болгохыг зорьсон юм.

Through the ESEL training, our team gained essential skills and knowledge in communication, innovation, and understanding others. In recent years, smartphones have become a constant presence in the lives of young people, making face-to-face interaction with friends and family less common. With this in mind, we decided to create a space where students could spend their free time productively—engaging with family and friends outside of class, playing intellectual and sports games, and fostering genuine, face-to-face relationships among our students.



## Санал, санаачилгаа бодит болгосон нь

Бид эхлээд хэрэгцээ шаардлагаа олж харахыг хичээсэн. Би гэхэд ширээний теннис тоглох дуртай. Гэвч манай суманд энэ спортоор хичээллэх газар байхгүй байсан. Дараа нь бид сумын нийт сурагчдаас төслийн хэрэгцээ шаардлагыг илрүүлэх зорилгоор судалгаа авахад хамрагдсан 420 сурагчийн 75 хувь нь

## Turning Our Ideas and Initiatives into Reality

We started by identifying our own needs. Personally, I enjoy playing table tennis, but there was no place for children in our soum to play the game. So we conducted a needs assessment survey among all the students in the soum. Out of 420 students surveyed, 75% reported spending their free time on social media platforms like Facebook, Instagram,

чөлөөт цагаа Facebook, Instagram, YouTube, TikTok ашиглаж өнгөрөөдөг, ингэснээр цахим орчинд донтож, чөлөөтэй сэтгэх, бие даах чадвар эрс буурсан хэмээн ярьж байсан. Энэхүү асуудал нь жижиг суманд их тулгардаг. Орон нутгийн хүүхэд багачууд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, дугуйлан дутмаг учраас тэд цахим орчинд олон цагийг өнгөрөөж байна. Энэ бүхэн олон сул талтай учраас нөхцөл байдлыг өөрсдөөсөө эхлэн өөрчлөхөөр “Fun day” төсөл хэрэгжүүлэх санаа төрсөн юм. Бид сумынхаа нийт сурагчдад сонголтот үйлчилгээг санал болгосон. Хөгжөөнт тоглоомоор хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих, цаашлаад амьд харилцааг бэхжүүлэх, гэр бүл, найз нөхөдтэйгөө хичээлээс гадуурх чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж, оюуны болон спорт тоглоомоор тоглох орчин бий болгосон. Манайд ирсэн хүүхдүүд нэгдүгээрт, урлаг буюу 4D бүжиг, хоёрдугаарт, спорт буюу ширээний теннис, дартс, ширээний хөл бөмбөг, гуравдугаарт, сэтгэхүй хөгжүүлэх буюу шатар, даам, IQ тоглоом, хөлөгт тоглоом гэсэн гурван төрлөөс сонгож тоглодог.

## Гэр бүл, хүүхдэд эрүүл, зөв дадал хэвшүүлсэн

“Fun day” төсөлд давуу тал олон. Тухайлбал, манай үйлчилгээний төвд ирж үйлчлүүлснээр найз нөхөд, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлж, дурсамж бүтээх боломжтой. Цаг үеийн баяр ёслолыг тохиолдуулан уралдаан тэмцээнд оролцоно. Суралцагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөж, эрүүл, зөв дадалд хэвшүүлнэ. Тоглоомоор дамжуулан багаар хамтран ажиллах чадвартай болж, зөв харилцаа, хандлагатай, хариуцлагатай болно. Суманд теннис, биллиард тоглуулдаг нэг газар бий. Гэвч насанд хүрсэн хүмүүс үйлчлүүлдэг

YouTube, and TikTok. This excessive screen time has led to a noticeable decline in their ability to think freely and independently, as many become addicted to the online world. This issue is common in small soums like ours.

Children in our community often spend too much time online because there are no suitable spaces or extracurricular activities for them to engage in during their free time. To address this, we came up with the idea for the “Fun Day” project to change the situation, starting with ourselves.

Through this project, we’ve been able to offer optional services to all students in our soum. We promoted physical health through fun games, strengthened social bonds, encouraged productive use of free time with family and friends, and created an environment where both intellectual and sports activities can be enjoyed. Children who come to use the space can choose from three types of activities: 1) Art, including 4D dance; 2) Sports, such as table tennis, darts, and table football 3) Intellectual Development, including chess, checkers, IQ games, and board games.

## Instilling Healthy Habits in Families and Children

Our project offers numerous benefits. By visiting our service center, families and friends can enjoy a warm, welcoming atmosphere and create lasting memories. Students can visit during holidays to participate in a variety of competitions and activities. This provides them with the opportunity to spend their free time productively while developing healthy habits. Through these games, participants not only improve their teamwork skills but also build strong relationships and cultivate a sense of responsibility.

In our soum, there is a place where people play table tennis and billiards, but it is often associated with drinking and smoking, creat-



учир архи, тамхи хэрэглэх зэрэг хүүхдэд ээлгүй орчинтой. Харин манай “Fun day” төв бүх талаараа өрсөлдөгчөөсөө давуу. Гэр бүл болон сурагчдын амьдрах, сурах орчинд элдэв хорт зуршил дэмжихгүй, эко үйл ажиллагаатай. Техник, тоног төхөөрөмж бүгд шинэ, сүүлийн үеийнх. Үйлчлүүлэгчдийнхээ нас, сэтгэхүйд тохирсон онцлогтой. Бид мэргэжлийн багш нартай хамтран орон нутгийн хүүхэд залуучуудад ширээний теннисийн сургалт зохион байгуулах, амралтын өдөр гэр бүлээрээ ирж уралдаан тэмцээнд оролцох, чөлөөт цагаа өнгөрөөх хөтөлбөрүүдийг тогтмол санал болгодог. Сумын төдийгүй сургуулийн хэмжээнд ширээний теннис, дартсын тэмцээнийг уламжлал болгон амжилттай зохион байгуулж байна.

### “Fun day” дараагийн шатанд...

Төслийг анх санаачлан эхлүүлж байсан багийн гишүүд бүгд ахлах ангийн сурагчид байлаа. Тэд 2023 оны зун сургуулиа төгсөхдөө ESEL ангийнхнаас адил хүсэл зорилготой дүү нараа сонгон авч төслөө өвлүүлэн үлдээсэн юм. Ийнхүү “Fun day” төсөл анхныхаас дараагийн үе рүү шилжиж, илүү өргөн хүрээнд, олон сурагчдад хүрч чадсан билээ. Бид санаагаа бодит ажил болгох, хамтдаа суралцах, хөгжих шинэ боломжууд нээж байгаад үргэлж баярладаг. Бидэнд энэ боломжийг олгосон Хүүхдийг Ивээх Сангийн хамт олонд сумынхаа нийт хүүхэд, багачуудын өмнөөс баярлаж талархдагаа илэрхийлье.

2023 онд хэвлэгдсэн



Говьсүмбэр аймагт хэрэгжсэн бичил төслүүдийн түүхийг монгол хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented in Gobisumber province in Mongolian.

ing an unhealthy environment for children.

In contrast, our “Fun Day” center stands out from the competition in many ways. We provide a clean, safe, and eco-friendly space that is free from harmful habits for both families and students.

We offer up-to-date, high-quality equipment tailored to the age and needs of our clients. In collaboration with local and provincial teachers, we regularly organize activities such as table tennis training for local children and youth, family competitions, and recreational events. We also host successful table tennis and darts competitions at both the soum and school levels.

### The Next Phase of the “Fun Day” Project

The original team behind the “Fun Day” subgrant project was made up of high school students. In the summer of 2023, they selected younger students from the ESEL class who shared their aspirations. Upon their graduation, the high school students passed the project on to them, ensuring its continuation and expansion to reach an even wider audience. We are happy that we are able to turn our ideas into reality and create new opportunities for learning and growth together. On behalf of all the children in our soum, we would like to express our sincere gratitude to the team at Save the Children for making this opportunity possible.

Published in 2023

## МӨРӨӨДӨЛ БИЕЛЖ, ИРЭЭДҮЙ ТОДОРСОН ЭХЛЭЛ

### TURNING DREAMS INTO REALITY AND MAKING FUTURE PLANS CLEARER

#### Сургалтаас эхтэй мэдлэг чадварууд

Завханаймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар дунд сургуулийн ахлах ангийн сурагч С.Мөнхжин, Б.Хулан, С.Үйлстөгөлдөр, Б.Пүрэвсүрэн, Г.Намуунцэцэг нар Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL хөтөлбөрт хамрагдаж, “Нэг цэгийн үйлчилгээ” бичил төсөл хэрэгжүүлжээ. Тэд хоёр жилийн өмнө 2,6 сая төгрөгийн санхүүжилтээр шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авч, сургууль дээрээ хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээ эрхэлсэн юм.

Хичээлийн бус цагаар гэрэл зураг авч, угаах, цаасан эхийг хувилж олшруулах, цахимаас цаасан дээр буулгах, үеийнхнийхээ бие даалтыг шивж гаргах, багш нарын хичээлийн төлөвлөгөө, тарааж өгөх материалыг өнгө үзэмжтэй бэлтгэж, хэвлэх зэргээр идэвхийлэн ажиллажээ. Сургуулиас хүүхдүүдийн санаачилга, идэвхийг дэмжин 12 ам.метр талбай бүхий өрөө гаргаж өгсөн нь урам нэмжээ.

“Дунд, ахлах ангийн сурагчид хэвлэлийн үйлчилгээ хайж хол, ойр явахгүй, бүгдийг нэг дороос, сургууль дээрээсээ, төвөг чирэгдэлгүй, хурдан шуурхай, чанартай авдаг болсонд “Нэг цэгийн үйлчилгээ”

#### Skills gained from the training

Munkhjin, B. Khulan, S. Uilstuguldur, B. Purevsuren, and G. Namuuntsetseg, students of general secondary school No. 2 in Tosontsengel soum of Zavkhan aimag, attended an ESEL course under the Save the Children's project “Entrepreneurship-focused Socio-emotional Skills for the Most Vulnerable Youth” and implemented the “One-Stop Service Center” small grant project (subgrant).

Two years ago, they purchased the necessary equipment and machinery worth 2.6 million MNT and started providing all kinds of printing services at the school. Outside of school hours, they were actively taking and printing photos, making copies of documents, printing computer files, typing assignments for their peers, preparing, and printing well-designed lesson plans and materials for teachers' distribution. The school provided a 12 square meter room to support the children's initiative and activity.

“The One-Stop Service Center” project offers middle and high school students the opportunity to get everything in one place at their school in a hassle-free, fast, and quality manner, without having to travel far in search of printing services. Thanks to their subgrant, our children have earned some income,

төслийн ач холбогдол оршиж байна. Манай хүүхдүүд бичил төслийнхөө үр шимээр тодорхой хэмжээний орлоготой болж, санхүүгийн бүртгэл баримт хөтөлж сурснаас гадна мөнгөний үнэ цэнийг мэдэрч ойлгодог болсон” гэж чиглүүлэгч багш Э.Бямбасүрэн сэтгэл дүүрэн ярилаа. Хүүхдүүд хичээлийн жилийн хэдхэн сард 800.000 төгрөгийн орлоготой ажиллажээ. Төслийн үйл ажиллагааг сургуульдаа сурталчилахын тулд фэйсбүүк хуудас нээсэн нь олон дагагчтай болж, маркетинг, зар сурталчилгааны зардлыг хэмнэсэн байна. Өнгөрсөн намар төсөл хэрэгжүүлэгч таван хүүхдийн дөрөв нь оюутан болж нийслэлд ирсэн бол С.Мөнхжин хараахан төгсөх болоогүй тул бизнесээ хариуцан үлджээ. Биднийг оны өмнөхөн зорьж очиход тэрээр том, жижиг олон зураг хэвлэж, өөг нь хайчилж бэлтгээд завгүй байж таарлаа. Жижгэвтэр өрөөнд хүүхдүүд дугаарлаж, чимээ шуугиантайхан, хөлтэйхэн аж. Ажлын сиймхийд нь хэдэн үг солиход С.Мөнхжин даруухан инээмсэглэж, “Хэдийгээр хамтран ажиллагсад маань оюутан болсон ч би хийж буй ажлаа үргэлжлүүлж, доод ангийн нэг хүүхэдтэй баг болон ажиллаж байна. Энэ зургуудын дараа (60 гаруй гэрэл зураг байлаа) 30-аад өргөмжлөл хийж гаргах захиалгатай” гэв. Тэрээр, энэ хичээлийн жилийн эхний хоёр сард 600 гаруй материал хувилсан, 100 гаруй өргөмжлөл, бас бус төрөл бүрийн ажил хийж гүйцэтгэн, 200.000 төгрөгийн орлоготой ажилласнаа хуучлав. “Цагаа зохицуулж сурсан учир хичээлээ цалгардуулалгүй бүхнийг амжуулж байна гэж гэрийнхэн болон багш нар сайшаахад маш их урам ордог” гэж С.Мөнхжин нэмж хэлсэн.

learned to keep financial records, and understand the value of money,” says ESEL trainer and counselor E. Byambasuren. Within a few months of the school year, the children generated an income of 800,000 MNT. To promote the project, the school created a Facebook page, which gained many followers and saved money on marketing and advertising.

Last fall, four of the five children involved in the project became college and university students and moved to Ulaanbaatar city. Munkhjin hadn't finished school yet, so she was left to run the business. When we visited them at the end of the year, she was busy printing large and small pictures and cutting them out neatly.

We heard a lot of noise in the small room and saw many children running around. When we managed to have a word with Munkhjin, she smiled modestly and said: “My colleagues have become college students, but I continue to work with one student from a lower grade. After I finish these pictures (there were more than 60 of them), my next task is to produce 30 certificates of appreciation.” She added that in the first two months of this academic year, she has copied more than 600 materials, produced more than 100 certificates, and completed various other tasks, earning 200,000 MNT.

Munkhjin added: “When my family and teachers praise me for learning to manage my time effectively and still study diligently, it encourages me”.

## Оюуны үр дэлгэрчээ

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL сургалт тус сургуульд зургаан удаа зарлагджээ. Хүүхдүүд уг сургалтад хамрагдсанаар багаар ажиллаж, санаа зорилгоо оновчтой, зөв илэрхийлэх чадвартай болсон байна. Сурвалжлагын баатрууд маань энэ сургалтын үр дүнд төсөл бичиж, хэвлэлийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санаагаа олжээ. Тэдний төсөл сургуулийнхаа хамгийн анхны бичил төслүүдийн нэг юм. Эдүгээ СЭЗИС-д бизнесийн удирдлага мэргэжлээр суралцаж байгаа, “Нэг цэгийн үйлчилгээ” төслийн багийн гишүүн Б.Пүрэвсүрэн ESEL сургалтад хамрагдаж бичил төслийн уралдаанд шалгарч, найз нарынхаа хамт амжилттай ажилласнаар мөрөөдлөө өөрчилж, ирээдүйгээ шинээр харах болов. Тэрээр, уг нь эмч болохыг хүсдэг байсан ч одоо бизнесийн чиглэлээр суралцвал амжилтад хүрнэ гэдгээ мэдэрч ойлгожээ. Тиймээс ч сонголтоо эргэлзэлгүй хийсэн

## Spreading Intellectual Seeds

ESEL training has been conducted six times at the school. The training helped children learn how to work as a team and express their opinions properly. As a result of the training, the children found an idea for one-stop publishing services and developed a project proposal. Their project is one of the school's first subgrant projects.

Purevsuren, a member of the One-Stop Service Center project team and currently studying business management at the University of Finance and Economics, participated in ESEL training and was selected for the small grant competition. Together with her friends, she successfully implemented this small grant project that made her change her dreams and see her future in a new way. Initially she wanted to become a doctor, but now she has realized that she could succeed if she studied business. So she made her choice



байна. Б.Пүрэвсүрэн “ESEL сургалтад хамрагдаж, бичил төсөл хэрэгжүүлснээр хамгийн чухал нь багаар ажиллаж сурсан. Аливаад эмх цэгцтэй, дараалалтай хандах, манлайлах чадвартай болсон. Манай ангид “Төслийн менежмент” сэдвийн хичээл 3-р курсээс орох төлөвлөгөөтэй юм билээ. Харин би энэ хичээлийг урьдчилаад “судалчихсан” тул илүү боломжтой гэж бодож байгаа. Төсөл хэрхэн бичих талаар сургаж зааварласан, ивээн тэтгэж, биднийг бүх талаар дэмжсэн Хүүхдийг Ивээх Сангийн хамт олонд болон сургуулийн захиргаа, багш нартаа баярлаж, талархдаг” гэж өгүүллээ.

МУИС-ийн оюутан Г.Намуунцэцэг ESEL сургалтаас олж авсан мэдлэг, тэр мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж туршлагажсан “Нэг цэгийн үйлчилгээ” бичил төслийн ачаар өнөөдөр тун амжилттай суралцаж байгаагаа онцлов. Тухайлбал, оюутны суралцах үйл явцын 80 хувь нь бие даалт учир нэгэнт хуримтлуулсан туршлага, мэдлэгтээ тулгуурлан семинарын хичээл, даалгавраа үр дүнтэй хийж гүйцэтгэж байгаа ажээ. Г.Намуунцэцэг их сургуулиа төгсөөд нутагтаа очиж мэргэжлээрээ ажиллах хүсэл эрмэлзлэлтэй гэдгээ хэлсэн. Тэрээр, “Хөдөөгийн хүүхдүүдэд аливаа төсөл хөтөлбөрийн үзүүлж буй үр нөлөө маш их, учир нь, хөдөөгийн сурагчдыг нэмэлтээр хөгжүүлж байж бид хотын болон бусад газрын хүүхдүүдтэй хөл нийлэн алхах боломжтой. Тиймээс аливаа төсөл, хөтөлбөрийг сумын сургуульд хэрэгжүүлэх нь маш их үр дүнтэй” хэмээн ярилаа.

АШУУИС-ийн оюутан Б.Хулан ESEL сургалтад хамрагдаж, “Нэг цэгийн үйлчилгээ” бичил төсөл хэрэгжүүлснээр хувийн санхүүгээ зохицуулж, багаар ажиллаж, аливаад эмх цэгцтэй хандаж

without hesitation. Purevsuren said: “By participating in ESEL training and implementing the subgrant project, I learned how to work in a team. I’ve learned to approach things in an organized and calm manner, and I have developed leadership skills. Our school is planning to teach the subject “Project Management” beginning from the 3rd grade. I think I have a better chance to succeed in this subject because I have already “studied” this subject beforehand. We are very grateful to the Save the Children team, school administration, and the teachers who taught us how to develop a project proposal, sponsored, and supported us in every way possible.”

Namuuntsetseg, a student of the National University of Mongolia, noted that today she is doing well in the University thanks to the knowledge gained in the ESEL course and the micro-project “One-Stop Service Center” where she applied this knowledge. For example, students spend 80% of their school time studying independently, so they use their experience and knowledge to effectively complete seminar assignments and tasks. Namuuntsetseg said that after graduation she aspires to go to her native region and work in her specialty. She said: “The impact of any project on rural children is huge. Rural school children see that only by building their capacity, they can keep up with children from cities and other places. So please believe me, any project or program implemented at soum schools is very important.”

B. Khulan, a student at the Mongolian National University of Medical Sciences, emphasized

сурсан гэдгээ онцлов. “Энэ чадвар бол хэн ч, хэзээ ч булааж чадахгүй миний “өмч” юм” гэж тэрээр бардам хэллээ. Б.Хулан багийнхаа орлого, зарлагыг гардан хөтөлдөг байжээ. “Их, бага нь хамаагүй, байгаа мөнгөө үр дүнтэй зарцуулах л санхүүгийн зөв боловсрол гэж ойлгосон. Би эм зүйч мэргэжлээр төгсөөд томоохон эмийн сантай болно. Хувийн бизнесээ амжилттай цэцэглүүлж чадна” гэж Б.Хулан итгэлтэй хэлэв.

Бидний үүлзсэн нэг багийн андууд бүгд л Хүүхдийг Ивээх Сангийн хамт олонд болон тус сургалтыг чиглүүлсэн багш нартаа талархаж явдгаа уламжлахыг хүссэн. Мөн сургуульдаа төслөө хэрэгжүүлж үлдсэн Б.Мөнхжин сурагч 2023 оны Завхан аймгийн шилдэг Энтрепренер сурагчийн шагнал хүртсэн баярт үйл явдал болсон байна.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ESEL хөтөлбөр энэ мэтээр ахлах ангийн хүүхдүүдийн далдын хүсэл мөрөөдлийг асааж, итгэлээр жигүүрлэн, амжилтын оргил өөд замнах замыг гэрэлтүүлж байна. Хүүхдийг Ивээх Сан өсвөр үеийнхний ухамсарт сэтгэлгээнд “оюуны үр” тарьсан нь төсөөлснөөс ч илүү хурдан урган нахиалж байгааг энэ жишээнээс харж болох билээ. Хүүхдүүд маань гэрэлт ирээдүйгээ эхэллээ. Тэднийг гялалзсан амжилт, нүргэлсэн ажил хөдөлмөр хүлээж байгаа билээ.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Тэтгэлэгт хөтөлбөрийн амжилтын түүхүүдийг монгол хэлээр уншина уу.

Read the success stories of subgrant projects in Mongolian.





## ТЭВЧЭЭР, ТӨВЛӨРӨЛ ОЛГОХ ҮНДЭСНИЙ СПОРТ

“Би их сахилгагүй, хичээлийн цагаар үймүүлчихдэг, хаа нэг болчимгүй үг хэлчихдэг байсан юм. Нуугаад яахав, үнэнээ л хэлье. Харин Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн ачаар өөрчлөгдөж чадсан. Аливаад сэтгэлийн хөдөлгөөнөөр биш, тунгаан бодож хариулт өгдөг, тэсвэр тэвчээртэй болсон” хэмээн ярих энэ хүүг С.Элбэг гэдэг. Тэрээр, Завхан аймгийн Тэлмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангид суралцдаг юм.

С.Элбэг 2022 онд ESEL сургалтад хамрагдсан ч бизнесийн санаагаа хараахан олоогүй тул Тэлмэн сумын сургуульд зохиогдсон анхны пич уралдааныг зүгээр л үзэж сонирхжээ. Найзууд нь, танилууд нь санаачилсан төслөө танилцуулж, шүүгч нарын асуултад түгдрэлгүй хариулж байгааг хараад бахархах сэтгэл төрсөн байна. Энэ үед юу хийж, ямар төсөл санаачилж болох вэ гэсэн асуултад хариу

*These words were said by S. Elbeg, a 9th-grade student at Telmen soum general secondary school in Zavkhan province: “I used to be undisciplined and disruptive during school hours, sometimes even saying inappropriate things. I have no reason to hide it; I’m telling you the truth. But thanks to Save the Children’s ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project, I was able to change. I’ve become more patient, taking time to think before responding, and no longer acting on impulse.”*

Although S. Elbeg attended the ESEL training in 2022, he hadn’t yet found his business idea and participated as a spectator in the first Pitch Competition at Telmen soum school. Watching his friends confidently present their ideas and answer the judges’ questions without hesitation filled him with pride.

It was during this time that the answer to the question of what to do and what projects to pursue came to his mind. One day, he noticed

## A NATIONAL SPORT THAT DEVELOPS ENDURANCE AND CONCENTRATION

орж ирсэн гэдэг. Тэрээр, физикийн багш Д.Мөнхбаярын сурын спортоор хичээллэж буйг биеийн тамирын хичээлийн үеэр сагс тоглож байхдаа харснаа санах. Яагаад ч юм нэг л сонирхол төрөөд болохгүй тул Д.Мөнхбаяр багш дээр очоод нэг удаа харваж үзэх гэсэн юм гэжээ. Багш нь ч зөвшөөрч, зогсолт зааж, нумаа хэрхэн барьж, сумаа хэрхэн онилж тавихыг хэлэв. Хэдийгээр бие нь чилсэн ч нэг л болмоор санагджээ. Түүнийг харвахаар зэхэж байхад зааланд байсан хүүхдүүдийн нүд өөр дээр нь тусаж буйг мэдэрч хэдийнэ сандарсан ч аятайхан санагджээ. С.Элбэг пич уралдааны танхимд энэ явдлаа гэнэт санаад “Ер нь сурын спортоор хичээллэж, бусдадаа зааж өгөхөд болохгүй юу байна. Би энэ санаагаа төсөл болгон бичвэл болох юм биш үү” гэж бодон баясан инээвхийллээ. Түүний эл шийдвэр ч зөв байлаа. Тэрээр ESEL сургалтын зөвлөх Б.Мөнхцэцэгт хандаж, чиглүүлэхийг хүсэв. Ингэснээр С.Элбэгийн хувьд завгүй өдрүүд эхлэх нь тэр. Д.Мөнхбаяр багшаараа хэрхэн харвахыг заалгаж, цэх зогсох, сумгүй нум татах зэрэг хэрэгтэй дасгал бүрийг уйгагүй оролдон шамдах болжээ. Энэ хооронд ижил сонирхолтой хүүхдүүдийг олов.

106 ангийн сурагч Т.Замбалгарвуу, Б.Далантай нартай нэг баг болж, хамтдаа “Цахим орчноос хөндийрч өв уламжлалаа хадгалъя” нэртэй төсөл бичив. Энэ төсөл нь Тэлмэн суманд болсон гурав дахь пич уралдаанд шалгарч, санхүүжилтийн эрх авчээ. Үндэсний телевизийн сурвалжлах баг ирж, төслийн уралдааныг

his physics teacher, D. Munkhbayar, practicing archery while he was playing basketball during physical education class.

Out of curiosity, Elbeg approached teacher Munkhbayar and asked if he could try shooting with a bow. The teacher agreed and showed him how to stand and raise the bow. Though his body was tense, Elbeg felt a sense of determination and believed he could do it.

As he was about to shoot, Elbeg felt the eyes of the children in the gym on him. He was nervous, but somehow he felt good. During the Pitch Competition Elbeg suddenly remembered this incident in the gym, and thought, “Why not practice archery and teach other students? Why not turn this idea into a project proposal?” He smiled at the thought.

His decision turned out to be the right one. Elbeg then approached his ESEL teacher and counselor, B. Munkhtsetseg, for guidance on how to turn his idea into a business. This marked the beginning of Elbeg’s busy days ahead.

He started learning archery from his teacher Munkhbayar, practicing the basic skills of standing still and drawing the bow without arrows. As he practiced, Elbeg also found other children who shared his interest in archery. Elbeg teamed up with 10th-grade students T. Zambalgarvuu and B. Dalantai, and together they wrote a project proposal titled, “Preserving Our Heritage While Staying Away from the Digital Environment.” Their proposal won and was awarded funding at the third Pitch

сурвалжилсан нь хүүхдүүдэд урам зориг өгсөн байна. С.Элбэг, Т.Замбалгарвуу, Б.Далантай нар төслийн санхүүжилтын 2,8 сая төгрөгөөр хоёр ширхэг шинэ нум, 10 сум, эрхийвч, шууны боолт худалдан авав. Төсөл бичих явцын судалгаандаа үндэслэж, сур харваагаар хичээллэх сурагчдыг бүртгэлээ. Хичээлийн завсарлагааны цагаар ахлах, дунд ангиар орж 42 сурагч бүртгэжээ. Үүнээс 10 сурагч дасгалаас шантарч сургалтыг орхив. Үлдсэн 32 сурагч Д.Мөнхбаяр багшийн дасгалжуулалтаар сургалтаа үргэлжлүүлсэн байна.

Пич уралдааны үеэр шүүгчид “Яагаад заавал ийм төсөл бичих болсон бэ” гэж асуухад С.Элбэг “Сурагчид гар утсандаа их цаг зарцуулж байна. Утасны хамаарал нь нүдний хараа муутгах, хоорондын харилцаа хөндийрөх зэрэг олон сөрөг нөлөөтэй” гэж хариулсан нь шүүгчдэд таалагдсан юм. “Сурын спортоор хичээллэснээр тэвчээртэй болно. Аливаад анхаарал сайн төвлөрнө. Сууж сурна, улмаар хичээл сурлагадаа сайжирна. Бие бялдарын хөгжилтэй болно шүү дээ. Нэрийг нь хэлээд яахав. Сургуульдаа нэлээд үймүүлдэг хүүхдүүдийн тоонд ордог нэг найз маань хоёр ч удаа бидний явуулж буй сургалтын үеэр ирсэн юм. Сонирхох биш даажигнах гэж тэр л дээ.

Гэвч гурав дахь удаагаа ирэхдээ би ч бас энэ спортоор хичээллэмээр байна гэсэн юм даа. Тэр найз маань сайн нэртэй, тэвчээртэй, дөлгөөхөн сурагч болсон. Багш нар бүгд магтддаг болсон шүү” гэж С.Элбэг сэтгэл хангалуун ярьж байлаа. Сур харвах нэг удаагийн дасгал 4-5 цаг үргэлжилдэг ажээ. Сургалтад хамрагдсан хүүхдүүд цагт 1000 төгрөгийн төлбөр төлнө. Төсөл үргэлжилсэн зургаан сарын хугацаанд нийт 900,000 төгрөгийн орлого

Competition held in Telmen Soum.

During the Pitch Competition, a National Television news team covered the event, giving the students an added boost of encouragement. With 2.8 million MNT in project funding, Elbeg, Zambalgarvuu, and Dalantai purchased two new bows, ten arrows, thumb rings, and forearm bandages to launch their archery program.

Drawing on the research he had done while preparing the proposal, Elbeg and his team began registering students for archery lessons. They visited high school and middle school classes during breaks and enrolled 42 students, though 10 eventually dropped out. The remaining 32 students continued their training under the guidance of teacher D. Munkhbayar.

When the judges asked during the Pitch Competition why they had chosen to write such a project proposal, Elbeg responded, “Students spend a lot of time on their phones. Phone addiction has many negative effects, from poor eyesight to a growing sense of isolation.” The judges were impressed by his answer.

“Practicing archery will develop patience, improve concentration, and correct posture. School grades will improve. It will enhance physical development. I have a friend who used to misbehave a lot at school. I don’t want to disclose his name, but he came to observe our activities twice. At first, he came just to cause trouble. When he came for the third time, he suddenly said he was very interested and wanted to learn this skill. He really became a patient and gentle student with a good reputation. All of our teachers are praising him.” He said this with a sense of satisfaction.

Each archery training session lasts 4-5 hours,

олж, ашгаасаа нэг шинэ нум 325,000 төгрөгөөр нэмж авчээ. Хүүхдүүд мөнгөө зөв зарцуулах санхүүгийн чадвартай болсноос гадна ашгаасаа хааяа амттан авч идэх дуртай гэнэ. Нэг удаа бүгдээрээ ярилцаж шийдсэний үндсэн дээр гурван өдрийнхөө орлогоор амттан худалдан авч гэрийнхнээ дайлж баярлуулсан ажээ. Бидний ESEL сургалтаас олж авсан хамгийн чухал чадвар бол багаар ажиллах, хүмүүстэй зөв харилцах юм. “Бид сургуулиа төгсөх хүртэл төслийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлж, “Тэлмэн домогт мэргэн” харваачдын клуб болгон өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа. Найзууддаа хандаж хэлэхэд, сонирхлоо олвол мөрөөд, мөрөөдөлдөө үнэнч бай гэж хэлмээр байна. Ингэвэл чи өөрөө, дараа бусад чинь эерэгээр өөрчлөгддөг юм байна шүү” гэж төслийн багийн гишүүн Б.Далантай ярих.

Тэгвэл багийн гишүүн, сурагч Т.Замбалгарвуу “Сур харвааны үеэр удаан зогсдог. Энэ үед бие болон сэтгэлийн тэнцвэрээ эхэлж олдог. Хичээллэдэг хүмүүст бодлоо цэгцлэх дасгал болдог шүү” гэлээ. Харин С.Элбэг “Та төсөөл л дөө. Уухайлаад нумаа татаад дээш харахад цэнхэр тэнгэр, шувуудаас өөр юу ч үгүй уужим орон зай хачин сайхан. Энэ спортоор заавал хичээллэж үзээрэй гэж бүх хүнд уриалж байна” гэсэн юм.

costing 1,000 MNT per hour. Over the six months of the project, they earned a total of 900,000 MNT. From this revenue, they purchased a new bow for 325,000 MNT.

The students not only developed financial skills, learning how to save and spend money wisely, but they also occasionally used their earnings for small pleasures, like buying sweets. On one occasion, they decided to spend their three-day earnings on sweets to treat their families, bringing joy and inspiration to everyone involved. The most important skills they gained through the ESEL training were teamwork and effective communication.

Project team member B. Dalantai shared, “The team plans to continue the project until graduation and expand it into the ‘Legendary Archer Telmen’ archery club. Let me give some advice to my friends: When you find something that interests you, follow it. You and those around you will change for the better.”

Student T. Zambalgarvuu explained, “I pause for a long time during archery practice. It’s in those moments that I first find my physical and mental balance. It’s an exercise that helps organize your thoughts.”

“Imagine this: When you draw your bow and look up, you see a blue sky and nothing but birds. It’s so beautiful. I encourage everyone to try this sport,” said Elbeg.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Тэтгэлэгт хөтөлбөрийн амжилтын түүхүүдийг англи хэлээр уншина уу.

Read the success stories of sub-grant projects in English.



## “СУРАГЧИЙН ШҮҮГЭЭ” ТӨСӨЛ ХҮНД АЧААНААС САЛГАВ

### “STUDENT LOCKER” PROJECT LIGHTENS THE LOAD

“Амжилтын солонго” баг Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж байгаа “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн ололт, амжилтын бодит жишээ юм. Ховд аймгийн Булган сумын ESEL хөтөлбөрийн төгсөгч, 11-12 дугаар ангийн сурагчид нэгэн баг болж, 2021 оны 12 дугаар сард болсон бичил төслийн тэтгэлгийн уралдаанд “Сурагчийн шүүгээ” төсөл бичсэн нь шалгарч, санхүүжилт авчээ.

Бид “Амжилтын солонго” багийн ахлагч, Ховд аймгийн Булган сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 11а ангийн сурагч Э.Анужин, гишүүн Э.Халиун, Б.Уянга, 12а ангийн сурагч У.Болд нарыг онцлон танилцуулъя.

Багийн ахлагч Э.Анужин: Манай суманд нийтийн тээвэр явдаггүй. Сурагчдын 25-30 хувь нь хичээлдээ 2.5-4.5 км алсаас алхаж ирдэг. Тэр холоос хүнд цүнх үүрч алхах нь сурагчийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг бид ажиглаж, судалсан юм. Стандартад зааснаар 14-18 насны хүүхдийн үүрэх ёстой цүнхний жин дөрвөн кг-аас хэтрэхгүй байх ёстой ч манай сургуулийн нэг сурагчийн цүнх ойролцоогоор 5-7 кг жинтэй байсан. Бид төслөө эхлэхээс өмнө хүнд жинтэй цүнх хүүхдийг нурууны суулттай болгох эрсдэлтэйг судалж мэдсэн. Тиймээс “Сурагчийн шүүгээ” төсөл бичсэн. Сурагчдад шүүгээг жилийн

The “Rainbow of Success” team is a prime example of the achievements and success of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented by Save the Children. In Bulgan soum, Khovd province, 11th and 12th grade graduates of the ESEL program formed a team and proposed the “Student Locker” project. Their idea, which involved providing a designated space for students to store their school bags, won the sub-grant competition held in December 2021, earning them funding to bring their project to life.

Let’s introduce the members of the “Rainbow of Success” team: Team leader E. Anujin, along with E. Khaliun and B. Uyanga (all 11th grade students at the general secondary school in Bulgan soum, Khovd province), and U. Bold (a 12th grade student from the same school).

Team leader E. Anujin shared, “There is no public transport in our soum, and 25-30% of the students walk 2.5 to 4.5 kilometers to school. We noticed that carrying heavy school bags over such long distances negatively impacts students’ health. According to standards, the weight of a bag for children aged 14-18 should not exceed four kilograms, but in reality, the average weight of our students’ bags is 5-7 kilograms. Before starting the project, we assessed the risk of back pain caused by carrying these heavy bags. That’s when we decided to propose the ‘Student’s Locker’ project. Through this initiative, we

хугацаатай, бага мөнгөөр түрээсэлж, орлогоороо шүүгээний тоог нэмэн бүх сурагчийг шүүгээтэй болгох зорилготой.

*-Сургалтын тухай анх хаанаас мэдсэн бэ? Сургалтаас өмнө ямар хүлээлттэй байв?*

**Б.Уянга:** Анх ангийнхаа чат дотроос хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтад бүртгэж байгаа тухай мэдээллийг уншсан. Эхлээд учрыг нь сайн ойлгоогүй, цагаан сарын өмнөхөн байсан болохоор зав муутайхан, гэвч ээж, аавтайгаа хамт очиж бүртгүүлсэн. Би бүрэг ичимхий, бусдад санаагаа ойлгуулж чаддаггүй байсан юм. Хувь хүн ур чадвараа хөгжүүлж, өөрийгөө өөрчилж болно бодохоор сайхан санагдаж байлаа. Дараа нь багшаасаа дэлгэрэнгүй мэдээлэл аваад “The Apprentice show”-тай төстэй юм байна даа гэж бодсон. Тэгсэн чинь “Шарк танк” шоу-тай төстэй байсан./инээв/

**Э.Халиун:** Би тэр үед өвдөөд эмнэлэгт байсан тул аав миний өмнөөс очиж анкет бөглөсөн. Дараа нь багш сонгогдсон хүүхдүүдийн нэрсийг зарлахад тэр дунд миний нэр байсанд их баярласан. Хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт надад их боломж гэж бодсон л доо.

*Сургалтад хамрагдах үед цагаа хэрхэн зохицуулдаг байв?*

**Э.Халиун:** Анужин бид хоёр заримдаа ээлжилж суугаад, суугаагүй хичээлээ нэгэндээ хэлж өгдөг, танхимын бус цагаар бие даалтаа хамт хийдэг байлаа.

**Э.Анужин:** Гэрийнхэн эхэндээ яагаад өдөр болгон сургууль руугаа буцаж яваад байдаг юм бэ гэж гайхаж байсан. Учрыг нь тайлбарлаж, төслийнхөө тухай хэлснээр дэмждэг болсон. Хичээлийн дараа гэрийнхээ ажлыг хийчихээд ESEL-ийн сургалтад сууна. Цагаа зохицуулж чадвал ямар ч ажил амждаг юм билээ.

aim to rent lockers to students at an affordable annual rate, and use the rental income to purchase additional lockers so that every student has one.”

*Where did you first hear about the training? What were your expectations before the training?*

**B. Uyanga:** “I first heard about the personal skills development course through my class chat. At first, I didn’t fully understand what it was, and since it was right before the Lunar New Year, I was quite busy. But I decided to register with my parents. I was very shy and had trouble expressing my thoughts clearly to others. It felt encouraging to think that I could develop my personal skills and transform myself. Later, when I got more details from my teacher, I initially thought it was similar to The Apprentice. But as I got more involved, I realized it was more like Shark Tank.” /laughs/

**E. Khaliun:** “At the time, I was in the hospital, so my father went and filled out the application for me. When the teacher announced the selected students, I was so happy to see my name on the list. I saw the personal skills development training as a great opportunity.”

*How did you manage your time during the training?*

**E. Khaliun:** “Sometimes, Anujin and I would attend the sessions in turns, and then explain the lessons we missed to each other and do our homework together.”

**E. Anujin:** “At first, my family was curious as to why I had to go back to school every day. Once I explained the reason and told them about the project, they became supportive. After school, once I finished my homework, I would go to ESEL training. If you manage your time effectively, you can accomplish almost anything.”



**Төслийнхөө санааг хэрхэн олсон бэ. Төслөө хэрхэн бичсэн түүхээсээ хуваалцах уу?**

**Э.Халиун:** Сургалтын үеэр бид өөр багуудад байсан. Тухайн үед сурагчийн шүүгээнээс гадна төслийн олон санаа байлаа. Багш маань “Сурагчийн шүүгээ” төслөө сонго гэж зөвлөсөн юм. Бид сурах бичгээ ашиглан төсөл бичих дарааллын дагуу мэдээллээ долоо хоногийн турш цуглуулж байж бичсэн. Бизнес төлөвлөгөө гаргах гэж шүүгээ борлуулдаг олон компани руу утасдаж, нэгжээ их үрсэн шүү. /инээв/

**Б.Уянга:** Ахлах ангийн хүүхдүүдээс та нарт шүүгээ хэрэгтэй юу, хүнд цүнх үүрэх хэцүү байдаг уу гэсэн асуулгаар судалгаа авахад цаг их зарцуулсан ч зөв алхам байсан. Пич өдөрлөгөөр манай багийнхан тайзан дээр хамтдаа гарч, ахлагч Э.Анужин төслөө танилцуулсан.

**Э.Анужин:** Шүүгчид “Өнөөдөр хичээлдээ үүрч ирсэн цүнхээ үзүүлж болох уу” гэхэд ойр байсан ангийн хүүхдийн цүнхийг өгч үзүүлсэн. Нээрээ л хүнд юм чинь. “Ахлах ангийнхан өдөрт 5-6 цагийн хичээлтэй. Сурах бичиг, дэвтрээ авна. Биеийн тамирын хичээл орвол бэлтгэлийн хувцас, спортын гутал нэмэгдэнэ” гэхэд танхимд байсан хүүхдүүд бүгд алга ташиж дэмжсэн. Тэгээд төсөл маань шалгарч санхүүжилт авсан даа.

**Тулгарсан саад бэрхшээл юу байсан бэ?**

**Э.Анужин:** Сургалтын үеэр хичээлийн таван өдөр сургууль руу буцах ажилтай байсан. Сонгон хичээлүүд, ESEL хичээл гээд өдөр бүр нааш цааш хэдэнтээ явахад жаахан хэцүү. Төсөл сорилт ихтэй байлаа. Эхлээд гэрээгээ бэлдэнэ. Түрээслэх хүүхдүүд ирж уулзмагц гэрээг нь уншуулж, гарын үсэг зуруулж, түлхүүр өгөөд явуулаад байсан чинь сүүлд нь аль анги, ямар дугаарын шүүгээ эзэмших болсон

**How did you come up with the idea for your project? Can you share the story of how you wrote your proposal?**

**E. Khaliun:** “During the training, we were placed in different teams. At that time, there were many project ideas, but we ended up focusing on the ‘Student’s Locker’ project. Our teacher suggested we choose it, and we agreed. We spent a week gathering information and then began drafting our proposal using the proposal writing manual from the textbook. We spent a lot of phone credit calling companies that sold lockers to help us come up with a business plan.” /laughs/

**B. Uyanga:** “It took a lot of time to conduct a survey asking high school students if they needed lockers and whether they found it difficult to carry heavy bags, but it was definitely worth it. On Pitch Day, our team went up together, and Anujin, our team leader, presented our project.”

**E. Anujin:** “The judges asked, ‘Can you show me the bag you brought to school today?’ So, I showed them the bag of a child sitting nearby. It was incredibly heavy. I said, ‘High school students have 5-6 hours of classes a day. They need to carry textbooks and notebooks. If they have a physical education class, they also need to bring training clothes and sports shoes.’ Then, all the students in the hall applauded and supported us. That’s when our project proposal was selected, and we received funding.”

**What obstacles did you encounter?**

**E. Anujin:** “During the training, I had to go back and forth to school for five days a week. It was a bit challenging to balance school lessons and ESEL classes while managing the project. The project itself was tough too. At first, I prepared the rental contracts. When the students came to rent a locker, I had them

гэх мэт мэдээллүүдийг тэмдэглээгүй байсан. Багаараа анги болгоноор хэсэж, тэр овогтой тэр хэний анги вэ, эрэгтэй юу, эмэгтэй юу гэж асууж байгаад арай гэж энэ мэдээллийг тодруулж байлаа. Дараа нь багаараа өдөржин сууж, түрээсэлсэн шүүгээний бүртгэлээ цэгцэлж авсан. Том туршлага болсон доо.

read the contract, sign it, and gave them the keys. But later, I realized I hadn’t recorded important details like which class they were from or which locker number they had. So, our team went around to each class, found the students who had rented lockers, and wrote down all the necessary information, including their class and gender. Then, we spent an en-



**Сургалтад хамрагдаад шинээр юу суралцсан бэ?**

**Э.Анужин:** Үзэл бодол, санаагаа зөв илэрхийлж сурлаа. Шинэ сурах бичиг ашиглаж, шинэ арга зүйгээр сургалт явуулсан нь их таалагдсан. Зураглал хийх, багаар ажиллах, илтгэх гээд бүх хэсэг нь шинэлэг санагдсан. “Цагийн менежмент” хичээл маш их таалагдсан. Зочин багш өөрийнхөө цагийн төлөвлөлт хийдэг тэмдэглэлийн дэвтрээ үзүүлсэн юм. Би

tire day organizing the locker rental records. It was a big lesson for us.”

**What new things did you learn at the training?**

**E. Anujin:** “I learned how to express my opinions and ideas clearly. I really liked that the training used new textbooks and innovative methodologies. The parts on mapping, teamwork, and presentations were all so new and engaging for me. I especially enjoyed the ‘Time Management’ lesson. The guest teacher

одоо багш шигээ дэвтэр хөтөлж цаг төлөвлөдөг болсон.

**Э.Халиун:** Сургуулийн хүүхдүүдийн царайг таньдаг байсан ч нээлттэй харилцаж чаддаггүй байлаа. Одоо бусдын талаар илүү ихийг мэдэн, ярилцаж, суралцахыг хичээдэг болсон. Компьютерын лабораторийг урьд нь хичээлээс бусад үед ашиглаж байгаагүй. Төсөл бичих үедээ зураг татах, мэдээлэл хайх зэргээр илүү үр бүтээлтэй ашиглангаа цахим орчинд ажиллаж сурсан. Мөн багаар ажиллаж сурч байна. Багийн ахлагч Анужин бусдадаа сайнаар нөлөөлж, сайн удирддаг. Бид хувь хүнийхээ хувьд хөгжиж, бие биеэсээ суралцаж байгаа.

**Б.Уянга:** Өмнө нь намайг таньдаг хүүхдүүд цөөн байсан бол одоо “Сайн уу” гэж мэндэлж, хүндэлж, найз болохыг хүсдэг болсон. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлд ордоггүй шинэлэг сургалт байлаа. Хэрэгцээтэй бүх зүйлээр хангасан нь урам өгсөн. Сургалтын зураг зурах хэсэг их таалагдсан.

*Ирээдүйд ямар хүн болохыг хүсэж байна вэ. Зорилгоосоо хуваалцах уу?*

**Б.Уянга:** Санхүү, бизнесийн чиглэлээр суралцана гэж боддог. Төсөл бичих явц их гоё. Шалгарсан нь бүр ч гоё санагдсан. Энэ төсөл миний бизнесийн салбар дахь карьерийн эхний шат боллоо. Амжилт эхэлж байгаа юм шиг санагдсан шүү. Төсөл шалгарахад миний хувь нэмэр бага орсон гэж бодож, өөртөө чамлалттай хандаж байгаа. Гэхдээ хэрэгжүүлэх явцад төслөө танилцуулах, шүүгээний түлхүүр хуваарилан өгөх зэргээр чадлынхаа хэрээр хувь нэмэр оруулж байгаадаа баярладаг. Олон түлхүүр ялгаж, гэрээ хийхэд ажил ихтэй. Төсөл хэрэгжүүлсний дараа энэ салбар надад тохирох эсэхэд жаахан эргэлзэж, бусад салбарыг сонирхмоор санагдсан. Мэргэжлээ сонгохоосоо өмнө

showed his notebook with his time plan, and now I keep my own notebook to plan my time just like he does.”

**E. Khaliun:** “I recognized the faces of other students, but I couldn’t communicate openly with them before. Now, I make an effort to talk to others, get to know them, and learn from them. I had never used the computer lab outside of class before. During the project proposal writing, I learned how to work more productively online, searching for images and gathering information. I’m also learning how to work in a team. Our team leader, Anujin, has a positive influence on us and is a great leader. We are all growing individually and learning from each other.”

**B. Uyanga:** “Before, only a few children knew me, but now they greet me with ‘Hello,’ respect me, and want to become my friend. The course was innovative and not part of the regular school curriculum. It was encouraging to have everything we needed. I especially enjoyed the drawing part of the training.”

*What kind of person do you want to be in the future? Share your goals.*

**B. Uyanga:** “I think I will study finance and business. The process of writing the project proposal was really exciting, and it felt even better when our proposal was selected. This project marked the first step in my career in the business field, and it felt like success was just beginning. While I don’t feel fully satisfied with myself because I think my contribution to the project’s success was small, I’m happy that I was able to assist during the implementation stage. For example, I helped present the project and handed out keys to the new locker renters. Sorting out all those keys and signing contracts was a lot of work. After the project was implemented, I felt a little unsure whether this sector was the right one for me. I wanted to explore other fields as well, but I’m

бизнесийн талаар туршлага, мэдлэгтэй болсондоо баяртай байгаа.

**Э.Анужин:** Ирээдүйд ийм төрлийн төслийн уралдаан, хөтөлбөрт идэвхтэй оролцоно. Яагаад гэвэл, дэвшүүлсэн санаа бүр цаанаа заавал ач холбогдолтой байдаг гэдгийг ойлгосон.

**Э.Халиун:** Анагаахын чиглэлээр суралцах хүсэлтэй. Гадаад руу тэтгэлгээр суралцахаар анкет бөглөхөд сургуулиас гадна өөр ямар нэгэн хөтөлбөрт хамрагдаж байсан гэрчилгээ байгаа юу гэж их асуудаг юм билээ. Энэ төсөлд хамрагдсан гэрчилгээгээ үзүүлээд материалдаа хавсаргасан нь тэтгэлэгт тэнцэхэд маш том давуу тал болж өгсөн. Аль улсад сурахаа сонгоод 12 дугаар ангиа төгсөөд хэлний бэлтгэлд сууна. Миний ирээдүйд том хөрөнгө оруулалт болсон.

**Э.Анужин:** Төсөл бичиж байхад дэмжиж зөвлөгөө өгсөн сургуулийнхаа багш нарт, ойлгож дэмжин гэрийн ажлаас чөлөөлж өгч байсан гэрийнхэндээ, бидэнд боломж олгосон Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн Банк, Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн ах, эгч нартаа баярлаж, талархсанаа илэрхийлье.

2023 онд хэвлэгдсэн

Published in 2023



Ховд аймагт хэрэгжсэн бичил төслүүдийн түүхийг монгол хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented in Khovd province in Mongolian.



Бичил төслүүдийн амжилтын түүхийг англи хэлээр үзнэ үү.

Watch the success stories of subgrant projects in English



## “ТООРХОН” БАГИЙН ТОГООЧ ХҮҮХДҮҮД

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн боловсролын сургуулийн “Тогоочийн анги”-ийн суралцагчид уралдаант пич шалгаруулалтын үеэр “Бид сургуулийн орчиндоо эрүүл, шинэ бүтээгдэхүүнээр сурагчид болон багш нарт үйлчилмээр байна. Сургууль маань одоог хүртэл цайны газаргүй байгаа. Бид энэ хоосон орон зайг нөхөх болно. Та бүхэн бидний бэлтгэсэн бүтээгдэхүүнийг амтлаарай” гэж тайзан дээрээс итгэл төгс танилцуулж, үзэгчдэд амталгаа явуулж байсан хүүхдүүд өнөөдөр санасандаа хүрчээ. Сургуулийн захиргаа тэднийг дэмжин буфет ажиллуулах өрөө гаргаж, тохижуулж өгсөн байна. Сайн дурын багш Стив Миллер америк технологи, жор заасан ажээ.

“Өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренер боловсрол олгох” төсөл Сүхбаатар аймгийн зорилтот Онгон, Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан суманд амжилттай хэрэгжиж, зорилтот бүлгээ тэллээ. Уг төслийг Мэргэжлийн боловсролын сургуульд хэрэгжүүлж туршихын зэрэгцээ хичээлийн албан ёсны хөтөлбөрт орж байгаа юм. Туршилтын хугацаанд хүүхдүүд ESEL хөтөлбөрт хамрагдаж, төсөл бичих чадварт суралцаж, бичил төслийн шалгаруулалтад оролцсон юм. Төлөөлөл болгож “Тоорхон” багийн гишүүн Р.Азжаргал, Б.Хулан, А.Мөнхцэцэг, Б.Сүнжидмаа нарыг танилцуулъя. Тэд мэргэжилдээ дуртай. Үргэлж өсөн дэвшихийг хичээдэг нэг

During the pitch competition, students of the “Cooking Class” at the Vocational Education School of Sukhbaatar province confidently presented their project proposal, and offered samples of their products for customers to taste. “We want to serve our students and teachers with healthy, fresh products within the school environment. Currently, our school lacks a cafeteria, but we intend to fill that gap. Please enjoy our products,” they said. Today, they have delivered on that promise.

Their initiative has received strong support from the school administration, which provided a renovated space for the new cafeteria. Additionally, volunteer teacher Steen Miller shared his expertise, teaching the students American culinary techniques and recipes.

The “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project has been successfully implemented in the targeted soums of Ongon, Munkhkhaan, Bayandelger, and Erdenetsagaan in Sukhbaatar province. The project has since expanded its reach by engaging additional target groups. Piloted at the vocational school, it has now been integrated into the official curriculum.

During the pilot phase, students participated in the ESEL program, developed project proposal writing skills, and participated in a sub-grant competition.

Let’s introduce the members of the “Toorkhon” team: R. Azjargal, B. Khulan, A. Munkhtsetseg,



### YOUNG COOKS OF THE ‘TOORKHON’ TEAM

ангийн найзууд. Мэргэжлийн боловсролын сургуулийн сурагчид ерөнхий эрдмийн болон мэргэжлийн хичээлээр зэрэг суралцдаг тул сургууль дээр олон цагийг өнгөрөөдөг онцлогтой. Хүүхдүүд үдийн цайны цагаар сургуулиас зайтай байрлах дэлгүүрээр үйлчлүүлж, түргэн хоол, бэлэн бүтээгдэхүүн худалдаж авдаг байжээ.

“Тоорхон” багийн гишүүд суралцаж буй мэргэжилдээ тулгуурлан сургуульдаа эрүүл, шинэ хүнс үйлдвэрлэхээр зоригшуулдаг. Энэ нь ч тэдний мөрөөдөл байв. Багийн гишүүд ESEL хөтөлбөрт хамрагдаж, хувь хүний чадварт суралцсан төдийгүй бизнес санаагаа төсөл болгон бичиж, төслийн санхүүжилт авсан юм. Сургуулийн захиргаа тэдний төслийг дэмжин тогоочийн ангийн тоног

and B. Sunjidmaa. Passionate about their profession, they are classmates who are continuously striving to grow and improve.

Vocational school students spend a significant amount of time at school, as they study both general academic subjects and specialized vocational skills. During lunchtime, students would often walk to a store located far from the school to buy fast food and snacks. The members of the “Toorkhon” team envisioned creating healthy, fresh products right at school, using their professional skills.

Through their participation in the ESEL program, they not only developed personal skills, but also transformed their business idea into a formal project proposal, ultimately securing funding. The school administration was highly



төхөөрөмжийг ашиглуулахын зэрэгцээ буфет ажиллуулах талбай гаргаж өгсөн нь том дэмжлэг болжээ.

“Тоорхон” багийн гишүүд ийнхүү үе тэнгийнхнийхээ эрүүл мэндэд санаа тавин сэтгэл гарган хөдөлмөрлөж, цаг хугацааг нь хэмнэж байна. Тэд хичээлээ давтаж, амжилттай суралцахын зэрэгцээ түүхий эдээ татан авч, бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Энэ бол хувийн зохион байгуулалт шаардсан ажил билээ. Багийн гишүүн Р.Азжаргал “Бид ESEL хөтөлбөрөөс цагийн менежмент, хувийн зохион байгуулалтын талаар ихийг суралцсан. Багийн гишүүн бүр үүрэгтэй. Бүгд үүрэгт ажлаа хариуцан биелүүлэхэд хүндрэл гардаггүй.

supportive, granting them access to culinary equipment and providing space to establish their cafeteria—support that proved invaluable.

The “Toorkhon” students are committed to improving their peers’ health and helping them save time. However, they are also students with demanding schedules. Buying ingredients and cooking food—all while managing their academic responsibilities—requires exceptional organizational skills.

R. Azjargal shared, “Through the ESEL program, we’ve learned time management and organizational skills. Each team member has specific responsibilities, and when everyone

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд маань өдөртөө л зарагдаж дуусдаг. Сүүлийн үед харин ч эрэлт ихсэж байна. Тиймээс бид бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмж байгаа. Зөвхөн бизнес хийж, орлого олох нь бидний чин зорилго биш. Ирээдүйд сайн тогооч болохын тулд туршлага хуримтлуулж, танхимд сурснаа амьдрал дээр туршин нутагшуулах нь чухал гэж боддог” хэмээн сэтгэгдлээ хуваалцав.

“Тоорхон” төсөл анх америк жороор таван нэр төрлийн амттан үйлдвэрлэхээр төлөвлөж байжээ. Гэвч үйл ажиллагааны явцад дадлагажиж, үйлчлүүлэгчдийнхээ саналыг харгалзан 10-аад нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болов. Тэд өдөрт 90-110 мянган төгрөгийн орлоготой ажиллаж байна. Багийн гишүүн Б.Хулан “Хэдийгээр эрэлт байгаа ч нэг төрлийн бус шинэ, олон нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх зорилготой. Бид санхүүгийн болон үйлдвэрлэлийн сахилга батыг илүү сахиж, энэ чиглэлээр суралцахыг хичээдэг. Шинэ бүтээгдэхүүнийг стандартын дагуу үйлдвэрлэхээс гадна шинээр жор гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна” гэж ярилаа.

“Өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд ментор, көүчүүд амжилттай ажиллаж байна. Бизнес көүч бичил төслийг зах зээлтэй холбож, бизнесийн зөвлөгөө өгдөг бол менторууд туршлагаа хуваалцаж зөвлөн тусалдаг. “Тоорхон” багийн хамгийн ойрын ментор нь Стин Миллер багш юм. Тэрээр, амттан, хоол хийх америк жорыг “Тоорхон” багийнханд заасан ажээ.

fulfills their tasks, the project runs smoothly. Our products sell out within a day, and with the growing demand, we’re expanding our product range. Our goal isn’t just to run a business and make money; it’s to gain hands-on experience and adapt what we’ve learned to real-life settings in order to become skilled chefs in the future.”

The “Toorkhon” project initially planned to produce five types of desserts based on American recipes. However, through practice and by incorporating feedback from their customers, they have expanded to producing around 10 different products which they sell in their school cafeteria. They report daily earnings ranging from 90,000 to 110,000 MNT.

Team member B. Khulan shared, “Even though demand is growing, we aim to offer a diverse range of new and innovative products. We focus on maintaining financial and production discipline while improving our understanding in these areas. Our goal is to create new products that meet high standards and develop our own unique recipes.”

As part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, both a mentor and a coach support the participants. Business coaches help connect subgrant projects to the market and provide valuable business advice, while mentors share their expertise and offer guidance. The mentor closest to the “Toorkhon” team is trainer Steen Miller, who teaches them American culinary recipes for desserts and other dishes.





Эдүгээ төслийн багийнхан багш, сурагчдадаа танигдсан үйлчилгээтэй, эргэлтийн хөрөнгөтэй, үйлдвэрлэлийн болон бизнесийн туршлагатай, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын тоног төхөөрөмжтэй, холын зорилгоо харж ойлгосон, урам зоригтой энтрепренер хамт олон болж, нийгмийн сүлжээнд бүтээгдэхүүнээ танилцуулж байна.

2024 онд хэвлэгдсэн

Today, the project team has transformed into enthusiastic entrepreneurs with a long-term vision. They now have working capital, manufacturing and business experience, production equipment, and offer a well-established service to their teachers and fellow students. The team is also actively promoting their products on social media.

Published in 2024



Сүхбаатар аймагт хэрэгжсэн бичил төслүүдийн түүхийг монгол хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented in Sukhbaatar province in Mongolian.



Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн хэрэгжүүлсэн бичил төслүүдийн түүхийг монгол, англи хэлээр үзнэ үү.

Watch the stories of subgrant projects implemented by Vocational school and Polytechnic college in English.



## ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ COLLABORATION AND SUPPORT



## ГОВЬСҮМБЭРИЙНХЭН АЙМГААРАА ХАМТАРДАГ

### THE PEOPLE OF GOBISUMBER COLLABORATE TO OVERCOME CHALLENGES

Хүүхдийг Ивээх Сангаас Говьсүмбэр аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл эхлэхэд, бидэнд тулгарсан эхний асуудал бол зөвхөн сургуулийн үйл ажиллагаа байх уу эсвэл тал, талаасаа нэгдэн оролцсон нийтийн хүчин чармайлт байх нь илүү үр дүнтэй юу гэсэн салаа асуулт гарч байсан юм. Мэдээж, шууд хамааралтай, чиг үүргийн, цөөхөн хүмүүстэй хамтран ажиллавал хялбар байна. Гэхдээ төслийнхөө зорилгыг харахад өргөн хүрээний хамтын ажиллагаа чухал байлаа. Ингээд Төслийн аймгийн зөвлөл (ТАЗ), Төслийн сумын зөвлөл (ТСЗ) байгуулж, зөвлөлийн үйл ажиллагаанд баримтлах жишиг журам гарган хэрэгжүүлсэн нь оновчтой шийдэл болсон.

Хүүхдийг Ивээх Сан 2020 оны 2 дугаар сарын 6-нд Аймгийн Засаг даргатай төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь төслийг талархан хүлээн авч, нэг үндсэн үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхээ илэрхийлсэн байна. Удалгүй Засаг даргын захирамж гарч, ТАЗ-ийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содномоор ахлуулан байгуулсан.

Зөвлөлийн гишүүдэд холбогдох газар, хэлтсийн дарга нар, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын аймаг дахь салбарын дарга, Политехник коллежийн захирал, Насан туршийн боловсролын

When Save the Children first began implementing the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, we faced an important question: Would it be more effective to focus on school-based activities, or should we engage the entire community in a collaborative effort? While working with a small group of people who share the same role and structure may seem easier, the goals of the project required broad cooperation with all relevant stakeholders to achieve success.

To ensure this, the establishment of both the Project Aimag Level Counsel (ALC) and Project Soum Level Counsel (SLC), along with standardized procedures for their operations, became the optimal solution.

On February 6, 2020, Save the Children signed a Memorandum of Cooperation with the province Governor to officially launch the project. Governor G. Batsuuri expressed his strong support for the initiative and highlighted the importance of making it a central activity for the province. Following this, the Governor issued a decree to establish the ALC, which consisted of 11 members, chaired by D. Sodnom, the Chief of the province Governor's Office.

The ALC brought together heads of key departments and agencies, the leader of the province's Mongolian Chamber of Commerce and Industry, the director of the Polytechnic College, and teachers from the Lifelong Learning Center. This diverse group ensured

багш нарыг сонгосон нь төслийг тэдгээр байгууллагын үндсэн үйл ажиллагаатай уялдуулах боломж олгосон юм. Тухайлбал, тус аймагт Насан туршийн боловсролын төв байгуулагдаагүй байсныг тус зөвлөлөөр хэлэлцэж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шинээр байгуулж, орон тоо, төсөв хөрөнгө, байрны асуудлыг шийдсэн нь төслийн хэрэгжилтэд төдийгүй орон нутгийн залуучуудад үнэтэй хувь нэмэр болж байна.

ТАЗ-ийн гишүүд төслийн үйл ажиллагааг салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулахын зэрэгцээ, хүүхэд, залуучуудын санаачилсан үйл ажиллагааг тухайлан дэмждэг туршлага бий болж, өргөжин дэлгэрч байна. Зөвхөн ТАЗ-ийн гишүүд гэлтгүй аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга нар хүртэл бичил төсөл хэрэгжүүлж байгаа сургуулийн гаднах залуучуудын нэг, нэг багийг хариуцан, ментороор ажиллаж, дэмжлэг үзүүлсэн юм. Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн энтрепренер клубийн сурагчдын санаачилсан “Гэрэл түгээ” аяны хүрээнд орон нутгийн байгууллагууд, багийн иргэд, айл өрхийн дэмжлэгтэйгээр хөрөнгө босгон, орон сууцнуудын орцыг гэрэлтэй болгосон нь олон нийтийн талархал хүлээсэн аж. Сумын Засаг даргын Тамгын газар сурагчдын энэхүү санаачилгыг талархалтай хүлээн авч, СӨХ-үүдтэй хамтран бүх байр, орон сууцны орцны гэрэлтүүлгийг бүрэн шийдвэрлэхээр төлөвлөжээ. Хүүхдүүдийн аливаа санаачилгыг төр, захиргааны байгууллагаас дэмжвэл орон нутгийн зарим асуудлыг шийдвэрлэх гарц, боломж байгааг уг хамтын ажиллагаа харуулж чадсан юм.

ТАЗ-д холбогдох байгууллагуудын дарга нар гишүүнээр ажилладаг боловч, тухайн байгууллагын ажилтнууд үйл

that the project was well-aligned with the goals of various local organizations.

For example, the ALC identified the lack of a Lifelong Learning Center in the province, presented this issue to the Provincial Citizens' Representative Khural, and successfully advocated for the establishment of a new center. They also addressed key operational aspects, including staffing, budget, and office space. This not only supported the project's implementation, but also contributed to the overall development of local youth.

The ALC members have fostered a practice of aligning project activities with sectoral policies and practices, particularly focusing on supporting initiatives led by children and youth. In addition to the ALC members, the Provincial Governor and the Chairman of the Provincial Citizens' Khural have actively served as mentors, providing guidance and support to each team of out-of-school youth implementing subgrant projects.

As part of the “Let's Illuminate the Light” campaign, initiated by the students of the Entrepreneur Club at the general secondary school No. 5 in Sumber soum, the children raised funds with the support of local organizations, community members, and families to light up the entrances of apartments, which received widespread public appreciation. Furthermore, the soum Governor's Office has expressed its support for this student-led initiative and is planning to address the lighting issues in all household entrances by collaborating with the Home Associations. This collaboration demonstrated that when children's initiatives are supported by state organizations, there are opportunities to address some local challenges and make meaningful improvements.

Although the heads of relevant organizations serve as members of the ALC, the employees of these organizations also play an active role in its activities. If a head is unavailable due to



ажиллагаанд нь идэвхтэй оролцдог. Тухайлбал, дарга нь ирж амжихгүй бол ажилтан нь ТАЗ-ийн хуралд орлож оролцох, үндсэн чиг үүрэгтэйгээ уялдуулан ажиллах соёл нутагшиж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүд бичил төсөл шалгаруулах багт шүүгчээр ажиллахын зэрэгцээ, Политехник коллежийн бичил төсөл хэрэгжүүлж байгаа багийн санаачилсан оюутнуудын цагийн ажлын зуучлалын төвийн үйл ажиллагааг дэмжиж байна. Аймгийн Боловсролын газраас байгууллагуудын удирдлагын шуурхай зөвлөгөөнд Сүмбэр сумын нэгдүгээр сургуулийн туршилтаар хэрэгжүүлж буй “Боржигон хөгжлийн төв” сургуульд

other commitments, another employee steps in to represent the organization at Counsel meetings, ensuring continuity of operations. In addition to serving as judges for the small business-project (Subgrant) selection team, experts from the Department of Labor and Welfare Services have supported the part-time job referral center for students initiated by the subgrant implementation team at the Polytechnic College. They have also begun developing part-time job opportunities within the community.

The Provincial Department of Education presented the School-Based Enterprise initiative, “Borjigon Development Center,” at a meeting

байгуулах боломж бий болгов. Улмаар Орон нутгийн хөгжлийн сангаас 36 сая төгрөгөөр “Боржигон хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаанд хэрэгтэй байсан сургалтын тоног төхөөрөмж, таблет, Боловсролын яамны 79 сая төгрөгийн санхүүжилтийг босгож чадсан нь орон нутгийн хамтын ажиллагааны нэг үр дүн байлаа. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын дарга, ТАЗ-ийн дарга Д.Содном ажлынхаа үр дүнгийн талаар “Ер нь монголчууд бусадтай нээлттэй харилцах чадвар язгуурын сул, бүрэг ичимхий хандлагатай улс. “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл энэхүү зан чанарыг бүрэн засч чадсан гэж би боддог. Тиймээс цаашид уг төслийг төрийн байгууллагууд дэмжиж, төслийн үйл ажиллагаа, арга зүйг орон нутагтаа нутагшуулан авч үлдэх нь чухал байлаа. Төслийн тогтвортой байдлыг хангахад манай зөвлөл анхаарлаа хандуулна. Аймаг, орон нутгаас дэмжин, тодорхой санхүүжилт, нөхцөл бүрдүүлэх боломжтой” хэмээн ярилаа.

Төслийн аймаг, сумын зөвлөл байгуулан, чиг үүргийг нь тодорхойлж, гишүүн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаатай уялдуулан, хамтын ажиллагаа, оролцоо бий болгосон нь боловсрол, хүүхдийн хөгжлийн төлөө орон нутгаараа нэгдэн ажиллах хандлага төлөвшихөд дэмжлэг болж байна.

ises to government organizations for official trainings.

Additionally, the center secured 36 million MNT from the Local Development Fund to purchase essential training equipment and tablets, and 79 million MNT from the Ministry of Education for smart screens and other necessary equipment. These achievements are a direct result of the collaboration between local organizations.

D. Sodnom, Chief of the Governor's Office of Gobisumber province and head of the ALC, summarized the Counsel's work by stating, “Mongolians generally tend to be shy and struggle with open communication. I believe this project has successfully addressed this challenge. Moving forward, our Counsel will focus on securing support from government agencies, integrating the project's activities and methodologies into the local context, and ensuring its long-term sustainability. In this regard, there is potential for the province to endorse this initiative and provide funding to support its implementation.”

The establishment of province and project soum-level counsels, along with the clear definition of their functions and alignment with the core activities of member organizations, is fostering collaboration and participation. This is helping to develop a local approach to working together for education and child development.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



суурилсан энтерпрайз санаачилгыг танилцуулан, тус төвийн зохион байгуулж буй сургалтуудад ажилтнаа оролцуулах, төрийн байгууллагуудын сургалтыг тус төвд түрээсээр зохион

of organizational heads. This initiative, being piloted at school No. 1 in Sumber soum, has created valuable opportunities for local organizations to participate in training sessions hosted by the center and to rent their prem-



“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн талаарх видеог монгол, англи хэлээр үзнэ үү.

Watch the video about the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project in Mongolian and English.





## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЧ

## FINANCIAL EDUCATION GUIDE

“Хүүхэд Монголын ирээдүй. Тэдэнд санхүүгийн боловсрол олгох нь зөвхөн бидний хариуцсан ажил бүс хүн бүрийн үүрэг юм” хэмээн аймаг, сумдын Тамгын газрын болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад зориулсан илтгэлийнхээ төгсгөлд итгэлтэй өгүүлж, бусдыгаа уриалах энэ шинэхэн боловсон хүчин бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Татварын улсын байцаагч Б.Хонгорзул юм. Тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн “Төслийн сумын зөвлөл”(ТСЗ)-ийн санхүү хариуцсан гишүүн билээ.

Бичил төсөл хэрэгжүүлж байгаа хүүхэд залуусын баг бүрэлдэхүүн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайлан гаргаж байна уу, зарцуулалтын баримтыг зөв бүрдүүлж байгаа юу гэх мэтчилэн хяналт тавьж, санхүүжилтийг хуваарийн дагуу, цаг тухайд нь олгоход анхаарч ажилладаг юм. Үүний дотроос Б.Хонгорзулын нэн тэргүүний үүрэг бол “Бичил төсөл хэрэгжүүлэгч багуудад санхүүгийн

“Every child is the future of Mongolia. Providing them with financial education is not just our responsibility – it is everyone’s responsibility,” said B. Khongorzul, the newly appointed State Tax Inspector of Munkhkhaan soum, confidently, at the conclusion of her speech to the leaders of the province and soum governor’s offices, as well as general secondary school officials.

Khongorzul is a member and the financial focal point of the Project Soum Level Counsel (SLC) for Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. Her job is to ensure that the youth teams’ approved budgets for subgrants are used in alignment with project objectives. She also monitors the preparation of financial reports and expenditure documents, making sure that funding is disbursed on time and in accordance with the project’s schedule.

Among her various responsibilities, B. Khongorzul considers her primary role is to be “providing financial advice to subgrant implementation teams.” After graduating from

зөвлөгөө өгөх” гэж тэрээр үздэг. Их сургууль төгсөөд төрсөн нутагтаа ажиллаж, амьдрахаар ирсэн тэрээр төрийн албан хаагч болсноос хоёр сарын дараа ТСЗ-ийн санхүү хариуцсан гишүүн болсон нь энэ. “Анхандаа хүүхэдтэй ажилласан туршлагагүй болохоор энэ ажлыг хийж чадах эсэхдээ эргэлзэж байв. Гэхдээ Хүүхдийг Ивээх Сангаас зохион байгуулсан санхүү хариуцсан гишүүний сургалтад сууснаар эргэлзээ маань арилсан” гэж Б.Хонгорзул ярилаа.

Түүний хувьд үндсэн ажлынхаа зэрэгцээ долоо хоног бүрийн нэгээс хоёр өдрийг орон нутагтаа бичил төсөл хэрэгжүүлж байгаа 16 багийн 69 хүүхэд, залууст зориулдаг байна. Тэдэнд санхүүгийн баримт хэрхэн бүрдүүлэх, худалдан авах ажиллагаанд юу анхаарах талаар зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгдөг. Сар бүр Төслийн сумын зөвлөлийн санхүүгийн зарцуулалтыг тайлагнаж, бичил төсөл хэрэгжүүлэгч багийн төсөл хэрэгжих хугацаанд санхүүгийн явцын болон эцсийн тайланг бие даан гүйцэтгэдэг. Эдгээр 16 төслөөс 14 нь амжилттай хэрэгжиж, Хүүхдийг Ивээх Сангаас батлагдсан төсвийн дагуу санхүүгийн зарцуулалтаа амжилттай хийж дуусгасан байна.

“Санхүүгийн баримтыг хууль, журмын дагуу цуглуулна гэдэг амаргүй. Зарим тохиолдолд худалдан авалт хийсэн байгууллагуудад зөвлөгөө өгч заримаас нь талархал, заримаас нь зэмлэл хүртэх удаатай. Санхүүгийн зарим баримтыг өөрөө холбогдон авч, үгүй бол Улаанбаатар хот орох ажлаа тааруулж байгаад өөрийн биеэр бүрдүүлэх нь ч бий. Хүүхэд, залуусыг бизнесийнхээ төлөө өөрсдийгөө дайчлаасай хэмээн зөвлөгөө өгөхийг эрмэлздэг. Санхүүгээ хугацаанд нь тайлагнаж сурах ёстой гэж хүүхдүүддээ зөвлөдөг” хэмээн Б.Хонгорзул ярилаа.

Бичил төслийн шалгаруулалтад оролцсон баг бүр тэнцэж, санхүүжилт авдаггүй ч Б.Хонгорзул бүх илтгэлийг анхааралтай сонсдог. Тэнцсэн багийн төслийн үндсэн санааг илүү ойлгож, цаашид дэмжлэг үзүүлэх гэж, харин тэнцээгүй багийн гишүүдэд санхүүгийн тооцоолол хэрхэн хийх, дараагийн удаа төслөө улам

university, she returned to her hometown to work. She became a civil servant, and two months later, she joined the Project Soum Level Counsel (SLC) as the financial focal point. Initially, she was unsure if she could handle the role, as she had no prior experience working with children.

However, Khongorzul revealed that her doubts were quickly dispelled after attending a financial management training course for project SLC members, organized by Save the Children. In addition to her primary job, B. Khongorzul dedicates one to two days each week to advising 69 children and youth across 16 subgrant teams on financial documentation and procurement. She also submits monthly reports on the SLC’s financial expenditures and independently provides financial progress and final reports on the subgrants to Save the Children. Of these 16 projects, 14 have been successfully implemented, with expenses fully aligned to the budget approved by Save the Children.

Collecting financial documents in accordance with laws and regulations is not an easy task. While advising organizations that have made purchases, B. Khongorzul sometimes receives gratitude and other times faces reprimands. There are times when she collects the financial documents herself or prepares them during her business trips to Ulaanbaatar.

She encourages children and young people to take ownership of their businesses. Khongorzul said she advises her children to learn to file their financial reports on time.

Not every team that participates in the subgrant competition can win and receive funding, but B. Khongorzul listens attentively to all the presentations. She strives to gain a deeper understanding of the winning teams’ project proposals and provides support to help them succeed. For teams that don’t succeed, she offers guidance on improving their financial calculations and enhancing their project proposals for the next round. Khongorzul encourages these teams to refine their pro-



сайжруулан оролцохын тулд яах ёстойг зөвлөхгэжхичээдэг аж. Тэрээр “Санхүүгийн сахилга баттай, бие даасан үзэл бодолтой, хуримтлуулдаг, баялаг бүтээдэг, хөрөнгө оруулагч сэтгэлгээтэй, шинэ үеийн төлөө зорьж, зүтгэж байна. Хүн бүр мөрөөдөж чадвал бүтээж бас чадна” гэж ярих дуртай.

Залуу хүний хувьд хүүхэд, залуустай хамтарч ажиллахад өөрөө ч бас хөгжиж байгаадаа талархдаг гэсэн. Төрийн алба, магистрын сургалт, ээжийн үүрэг, төслийн зөвлөлийн ажил гээд бүгдийг нь нэг дор хэрхэн амжуулдаг вэ гэж сонирхон асуухад “Хүсэл тэмүүлэл байхад тийм ч хэцүү биш. Би нэг хүүхдэд ч болов тусалж, санхүүгийн мэдлэгтэй болгох юмсан гэж хичээж, сэтгэл хангалуун явдаг. Намайг сурагч байхад ийм төсөл хэрэгжсэн ч болоосой гэж боддог. Гэхдээ энэ төслийн нэг хэсэг болсны хувьд сумын маань хүүхдүүд хувь хүний үр чадвараа сайжруулан, гаргасан төслийн санаагаа хэрэгжүүлэх явцдаа санхүүгийн мэдлэгтэй болсон гэж яриасай гэж хүсэж байна” хэмээн хариулсан юм.

Хүүхдийг Ивээх Сангийн Сүхбаатар аймаг дахь салбарын зохицуулагч Ө.Марал “Б.Хонгорзул өөрийн сайн туршлагаа бусад сумын санхүү хариуцсан гишүүдтэй харамгүй хуваалцдаг. Энэ нь төслийн хэрэгжилтэд маш том дэмжлэг болдог. Үүрэгт ажлаа товлосон хугацаандаа заавал амжуулна гэсэн эрмэлзэл нь бидний болон сумынхаа бичил төсөл хэрэгжүүлж байгаа хүүхэд, залууст маш том дэмжлэг болж байна” гэлээ.

Сүхбаатар аймгийн дөрвөн суманд хэрэгжиж байгаа “Орон нутгийн өсвөр үеийхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд нийт 435 хүүхэд, залуус бичил төслийн уралдаанд оролцсоноос 194 хүүхэд, залуус 44 бичил төслөөр шалгарч, 143,000,400 төгрөгийн санхүүжилт сум орон нутагтаа авч чадсан байна.

2024 онд хэвлэгдсэн

posals and try again. She often says, “My goal is to nurture a new generation of financially disciplined, independent thinkers—individuals who save, build wealth, and adopt an investment mindset. Anyone who can dream can achieve their dream.”

She often expresses gratitude for the personal growth she experiences as a young woman through her work with children and youth. When asked how she manages to balance her government service, masters degree studies, motherhood, and role in the project Counsel, she responded, “It’s not that hard when you have passion. I feel happy to make at least one child financially literate. I wish this project had been available when I was a student. Now that I’m part of it, I want the children in my soum to say that they’ve developed their personal skills and become financially literate through the implementation of their project ideas.”

U. Maral, the coordinator of the Sukhbaatar province branch of Save the Children said, “Khongorzul generously shares her valuable experience with other project SLC members who serve as financial focal points. Her support has been instrumental in the successful implementation of the project. Her commitment to completing tasks on time has been invaluable to us and to the children and youth carrying out subgrants in our soum.”

Within the framework of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented in four soums of Sukhbaatar province, a total of 435 children and youth participated in the subgrant competition. Of these, 194 were selected for their 44 subgrant proposals, resulting in an investment of 143,000,400 MNT in subgrant funding across the soums.

Published in 2024

## ӨГЛӨӨНИЙ ЦАЙНЫ СОЁЛ ТҮГЭЭХ САНААЧИЛГА

### INITIATIVE TO CULTIVATE A BREAKFAST CULTURE

Багш, сурагчид “Өглөөний цайг өөртөө” төсөл хэрэгжүүлж байна

Teachers and students are implementing the “Breakfast for Yourself” project

Хүний эрүүл, зөв хооллолтын үндэс нь өглөөний цай тогтмол уух гэдэг. Ингэснээр бие дэх бодисын солилцоо эрчимжиж, цусан дахь сахарын хэмжээ тогтмолжиж, дархлаа сайжирч, эрч хүчтэй байдгийг эрдэмтэд тогтоожээ. Тэгвэл сумандаа өглөөний цайны соёл түгээж, багш, сурагчид хамтдаа хоол үйлдвэрлэж, сургууль орлого олж байгаа шинэлэг санаачилгын тухай өгүүлье.

...Өвөрхангай аймаг. Богд сум. Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн дотуур байрын цайны газар. Өглөөний цай бэлтгэх охид, хөвгүүд...

A healthy and balanced diet begins with a regular breakfast. Research has shown that eating breakfast boosts metabolism, stabilizes blood sugar levels, strengthens immunity, and increases energy. I'd like to share an innovative initiative that is promoting the breakfast culture in the soum, where teachers and students are collaborating to produce food, and the school is generating income in the process.

...Uvurkhangaï province. Bogd soum. General secondary school No. 1 dormitory cafeteria. Boys and girls preparing breakfast.....





Сурагчид хачиртай талх, ороомог, лууван, бүхэлүрээр баяжуулсан будааны бөмбөлөг, кембаб, ногооны зутан шөл буцалгаж, жимсний салат, шүүс зэрэг өглөөний цайны бүтээгдэхүүнийг мэргэжлийн тогоочдоос дутахгүй амт, чанартайгаар, хурдан шаламгай бэлтгэнэ. Тэдэнд мэргэжлийн хоол зүйч нь зөвлөгөө өгч байгаа харагдана. Энэ бол багш, сурагчдын оролцоонд тулгуурласан “Өглөөний цайг өөртөө” төслийн ажлын нэг хэсэг юм. Үүний дараа сурагчид бэлэн болсон бүтээгдэхүүнийг савлаж, сургуулийн буфет рүү зөөж, тэндээ зарж борлуулна. Мөн сумын бусад байгууллагууд руу захиалгаар хүргэдэг байна. Богд сум 5600 гаруй хүн амтай, төрийн болон үйлчилгээний байгууллагууд, ерөнхий боловсролын хоёр ч сургуультай.

Зах зээлийн багтаамжтай гэсэн үг. Өглөөний цай бэлтгэж байгаа сурагчдын нэг Б.Өсөх-Ирээдүй нэгдүгээр сургуулийн 6б ангийн сурагч юм. Би сайн дураараа ажиллаад сар гаруй болж байна. Өдөр хичээлтэй болохоор 7 хоногт 3-4 удаа, өглөө 9.30 цагаас ирж, 2 цаг орчим ажилладаг. Ээж минь тогооч мэргэжилтэй. Тэгээд ч би хоол хийх дуртай. Энд төрөл бүрийн түргэн хоол бэлтгэж сурсан. Хүүхдүүд надаас “Чи яаж ийм гоё хоолнууд хийж сурсан юм бэ” гэж асуудаг. Тухайн хоолны орцонд багтдаг хүнсний материалуудыг худалдаж аваад гэртээ бэлтгэж, туршиж үздэг. Манай ангийнхан буфетээр байнга үйлчлүүлдэг” хэмээн ярилаа.

*...Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн түргэн хоолны буфет, ширээ сандал. Өглөөний цайгаа уухаар худалдан авч байгаа багш, сурагчид...*

Хичээлийн завсарлагаагаар буфет үйлчлүүлэгч олонтой байлаа. Өдөр бүр ийм байдаг гэнэ. Хүүхдүүд чанасан өндөг, хачиртай талхнаас эхлээд 2500 төгрөгийн үнэтэй кембаб гээд бүхий л төрлийн бүтээгдэхүүнээс худалдан авч байв. Зарим нь ширээнд сууж, зарим нь зогсох зуураа өглөөний цайгаа ууна. Түргэн хоолнууд баталгаатай, эрүүл, хямд үнэтэй, бас шинэхэн. Сургуулийн багш, ажилчид хол

Students are quickly and efficiently preparing breakfast. They make a variety of items such as sandwiches, rolls, carrots, whole-grain rice balls, kimbaap, vegetable soup, fruit salad, and fresh juices—delivering the same taste and quality as professional chefs. Occasionally, a professional dietitian is on hand to offer advice. This is all part of the “Breakfast for Yourself” project, which encourages active participation from both teachers and students.

Afterward, these products are packaged, transported, and sold at the cafeteria set up at the school. They are also delivered to other organizations in the soum upon request. With a population of over 5,600 Bogd soum is home to government and service organizations, as well as two secondary schools, creating a solid local market for these products.

One of the students preparing breakfast, B. Usukh-Ireedui shared, “I am a 6th-grade student in class 6B at school No. 1. I volunteered for this project and have already been working here for over a month. Since I have classes during the day, I come 3-4 times a week at 9:30 a.m. and work for about 2 hours. My mother is a chef, and I love cooking. Here, I’ve learned to prepare all kinds of fast food. The other kids often ask me how I make such delicious food. I buy the ingredients and experiment with recipes at home. My classmates frequently come and buy food from the cafeteria.”

*...The fast food cafeteria, tables and chairs at the school No 1. Teachers and students having breakfast....*

The cafeteria was packed with customers during the school break, and it’s like this every day. Children were buying everything from boiled eggs and sandwiches to kimbaap, which cost 2,500 MNT. Some sat at tables, while others ate their breakfast while standing. Fast food has many advantages, such as being safe, healthy, affordable, and fresh, and it allows students and school staff to save time.

явахгүй цагаа хэмнэх боломжтой гээд давуу тал олон. “Өглөөний цайг өөртөө” төслийг Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн сургуульд суурилсан энтерпрайз санаачилгын хүрээнд 122 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, хэрэгслээр хангаж, аргагүйн дэмжлэг үзүүлжээ.

Уг төслийг нээх үеэр ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн дэргэдэх “Шим тэжээл” судлалын төвөөс сумын иргэд болон сурагчдад зохистой хооллолт, эрүүл мэнд, өглөөний цайны ач холбогдлын талаар танилцуулж, бүтээгдэхүүний дээжийн үзэсгэлэн, амталгаа зохион байгуулсан нь хүмүүст эергээр нөлөөлжээ. Нэгдүгээр сургуулийн төслийн энэхүү шинэлэг бөгөөд сонирхолтой санаачилгад сэтгэл ханамжтай байж, дэмжих итгэл үнэмшил төрүүлжээ. Богд сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн захирал Л.Гантулга “Өглөөний цайгаа сургууль дээр буфетээр борлуулдаг. Мөн

The “Breakfast for Yourself” project is supported by Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, which provided equipment and tools worth 122 million MNT, and shared their methodology as part of the School-Based Enterprise initiative. During the launch of the project, the Nutrition Research Center at the Industrial Technology School of the Mongolian University of Science and Technology delivered a presentation to the residents and students of the soum on proper nutrition, health, and the importance of breakfast. They also organized an exhibition and tasting of product samples. This event had a positive impact on the community, leaving people satisfied and confident in supporting this innovative initiative at the school.

L. Gantulga, the director of Bogd soum general secondary school No. 1 explained, “Breakfast is sold at the school cafeteria and also delivered to official organizations, and to school







сумын албан байгууллагууд болон 2 дугаар сургуульд хүргэж, үйлчилнэ.

Өглөөний цайгаа сургуулийн сурагчдын дотуур байрын гал тогоонд бэлтгэх учраас тэнд хүмүүс ирж үйлчлүүлэх боломжгүй. Тиймээс захиалга авдаг сошиал групп үүсгэсэн. Сурагчид бэлтгэж, зарсан бүтээгдэхүүний үнээс тодорхой хэмжээний урамшуулал авдаг болохоор илүү урамтай ажиллаж байгаа” гэлээ. Өглөөний цайны буфетээр үйлчлүүлж байгаа хоёр хүүтэй ярилцлаа. О.Дагвадорж, Б.Хос-Эрдэнэ нар 4а ангийн сурагчид. Тэдний хичээл өглөө 8.00 цагаас ордог тул заримдаа цайгаа ууж амждаггүй. Гэвч завсарлагааны цагаар эндээс хачиртай талх, ороомог авч идэх дуртай аж. Мөнгөгүй үедээ зээлээр авчихдаг, дараа нь аав, ээж төлчихдөг гэлээ. Бас сургуулийн ойролцоох дэлгүүрт аваад идчих зүйл байхгүй, чихэрлэг бүтээгдэхүүн эрүүл мэндэд муу хэмээн хэвлүүхэн тайлбарлаж байх юм.

No. 2. Since the breakfast is prepared in the dormitory kitchen, it's not possible for people to come and eat there. To manage this, we created a social chat group for taking orders. The students are more motivated to work because they receive a certain share of the sales revenue from the products they prepare and sell.

We spoke with two boys enjoying their breakfast in the cafeteria. O. Dagvadorj and B. Khos-Erdene are 4th-grade students in class 4A. Their classes start at 8:00 a.m., so sometimes they don't have enough time to have breakfast. They enjoy buying sandwiches and rolls here during recess. When they don't have money, they buy food on credit and their parents pay for it later. They also mentioned that there's nothing to eat at the store next to the school, and that sweets aren't healthy. Since the launch of the “Breakfast for Your-

“Өглөөний цайг өөртөө” төслийнхөн үйл ажиллагаагаа эхэлснээс хойш нийт 23 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна. ...Өглөөний цайны соёл түгээх төслийн багийнхан. Танхимаар эзэмшсэн мэдлэгээ бодит амьдралд ашиглаж, үр чадвараа хөгжүүлэх сурагчид...

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн чухал зорилтуудын нэг нь өсвөр үеийн хүүхэд, залуусыг ирээдүйн хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх юм. Тэгвэл “Өглөөний цайг өөртөө” сургуульд суурилсан энтерпрайз төслийн багийнхан энэ зорилгыг биелүүлэхэд бодит хувь нэмэр оруулж, сумандаа өглөөний цайны соёл түгээж, зохистой хооллолтын дадал хэвшүүлэхэд чухал үүрэгтэй оролцож байна. Хүүхэд, багш нарын оролцоонд тулгуурлан бизнесийн тодорхой үйл ажиллагаа эрхэлж, олсон орлогоо сургуулийнхаа үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд зориулж байна. Энэ үйл ажиллагаа нь суралцагчид танхимаар эзэмшсэн мэдлэгээ бодит амьдралд ашиглаж, үр чадвараа хөгжүүлэх боломж олгодог. Тэдний цаашдын зорилго бол төслөө сум, орон нутгийн оролцоонд тулгуурлан амжилттай хэрэгжүүлж, зөвхөн сургууль, хүүхэд, багш нар төдийгүй сумаараа зохистой хооллолтын соёлд суралцах юм. Сургуульд суурилсан энтерпрайз хэрэгжүүлэгч ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл Улаанбаатар хотод ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалжээ. Энэ үеэр “Өглөөний цайг өөртөө” төслийнхөн үндэсний үйлдвэрлэгч “Батбайгаль бэйкери” компанид зочилж, эрүүл, ашигтай хүнсний бүтээгдэхүүний жагсаалт, үйлдвэрлэх жор, хүний нөөц, санхүү, ариун цэвэр, ариутгал зэрэг төрөл бүрийн сэдвээр мэргэжлийн болон практик зөвлөгөө авсан байна.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд гарсан

self” project, it has generated sales totaling over 23 million MNT.

...Members of the breakfast culture project team. Students applying the knowledge they've gained in class to real-life situations and developing their skills....

One of the goals of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented by Save the Children, is to prepare adolescents and young people for the future labor market. To turn this goal into reality, and promote a culture of breakfast and healthy eating habits throughout the soum, the team behind the “Breakfast for Yourself” School-Based Enterprise project is engaging in specific business activities that involve both students and teachers. The proceeds are being reinvested to support the school's main objectives.

This activity enables students to apply the knowledge they have gained in the classroom to real-life situations, while developing practical skills. Their ultimate goal is to successfully implement the project through the participation of the soum and local community, so that not only schools, children, and teachers, but the entire soum, can learn about proper nutrition. Throughout the project, representatives from general secondary schools participating in the School-Based Enterprise initiative have visited businesses in Ulaanbaatar engaged in similar operations to learn from their experiences.

During this time, the “Breakfast for Yourself” project team visited the national manufacturer “Batbaigal Bakery,” where they received professional and practical advice on a range of topics, including healthy and nutritious food products, recipes, human resources, finance, hygiene, and sanitation.

One innovative initiative within the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project is the concept of school-based

нэг шинэлэг санаачилга бол сургуульд суурилсан энтерпрайз гэсэн ойлголт юм. Энэ нь сургуулийн багш нар, сурагчид хамтдаа боломжоо ашиглаж, тодорхой үйлдвэрлэл явуулж, борлуулалт хийн, олсон орлогоо хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах, сургуульд сурсан зүйлээ бодит амьдралд хэрэгжүүлэх явдал юм. Сургуульд суурилсан энтерпрайз санаачилгын хүрээнд Өвөрхангай аймгийн Богд сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль “Өглөөний цайг өөртөө” төсөл хэрэгжүүлж байгаа. Үүнтэй ижил төстэй төслүүд Ховд аймгийн Зэрэг, Завхан аймгийн Тэлмэн, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль, Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд тус тус хэрэгжиж байна.

2024 онд хэвлэгдсэн

enterprises. This involves teachers and students working together to conduct production and sales activities, with the proceeds being used for child development programs. It also provides an opportunity to apply what students learn in school to real-life situations.

As part of the School-Based Enterprise initiative, school No. 1 in Bogd soum, Uvurkhangaï province, is implementing the “Breakfast for Yourself” project. Similar projects are also underway at schools No. 1 in each of the following soums: Zereg soum of Khovd province, Telmen soum of Zavkhan province, Erdenetsagaan soum of Sukhbaatar province, Sumber soum of Gobisumber province, and others. The project is also being implemented at school No. 2 in Kharkhorin soum, Uvurkhangaï province.

Published in 2024



Сургуульд суурилсан энтерпрайзын түүхүүдийг монгол хэлээр уншиж, танилцуулга видеоог үзнэ үү.

Read the success story of the School-Based Enterprise and watch the videos in Mongolian

## BUSINESS COACH: STEERING TOWARDS GOALS, OPTIMIZING ACHIEVEMENTS

### ЗОРИЛГОД ЧИГЛҮҮЛЭГЧ, АМЖИЛТЫН ХӨШҮҮРЭГ БУЮУ БИЗНЕС КӨҮЧ

“Көүч” гэж хэнийг хэлэх вэ? Ойлгомжтой, энгийнээр хариулъя. Тухайн хүний зорилгыг тодорхойлоход туслах, эсвэл өмнөө тавьсан зорилго, зорилтыг илүү тодорхой төлөвлөхөд чиглүүлэх, тэрхүү зорилгодоо хүрэх замд учрах аливаа саад бэрхшээлийг илрүүлэн, тэр бүхэнд тохирсон гаргалгааг хамтдаа ярилцаж, шийдэл хайж, амжилтад хүргэх чиглүүлэгч хүнийг көүч хэмээн тайлбарлаж болно. Ингэхдээ тухайн көүч амьдралын туршлага, сургамж, мэдлэгтээ суурилж, тухайн хүнд байгаа боломж, авьяас, мэдлэг чадварт тулгуурлаж ажилладаг.

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд зорилтот таван аймаг тус бүрд бизнес көүчүүд ажиллаж байна. Тэдний нэг нь Өвөрхангай аймгийн бизнес көүч Б.Сүрэн юм. Тэрээр, зорилтот сум болох Уянга, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Гучин-Ус, Богд, Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Арвайхээр сумын Политехник коллежийн оюутнууд, мөн эдгээр сумын Насан туршийн суралцахуйн суралцагчид болон энтрепренер клубийн хүүхэд, залуустай хамтран ажиллаж байна. Төслийн аймаг, сумын зөвлөл, ESEL хөтөлбөрийн багш нар болон сургуульд суурилсан энтерпрайз төслийн багийнхантай ч гар нийлэн, үр дүнтэй хамтарч байна.

*What defines a coach? Let me simply explain. A coach is someone who helps individuals in identifying their goals or developing actionable plans to achieve them, determining and overcoming obstacles, collaboratively finding solutions, and ultimately guiding them towards success. They provide guidance based on their experience, lessons learned, knowledge, and skills.*

Under the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project implemented by Save the Children, business coaches are working in five target aimags. Among these coaches is B. Suren, a business coach from Uvurkhangaï aimag.

He collaborates with students from secondary schools in the target soums of Uvurkhangaï aimag, including Uyanga, Kharkhorin, Bat-Ulzii, Khujirt, Guchin-Uus, Bogd, and Sant. Additionally, he engages with students from the Polytechnic College of Arvaikher soum, as well as children and youth affiliated with the Lifelong Learning and Entrepreneur Clubs in these soums. Furthermore, he interacts with the aimag and soum councils, ESEL teachers, and the School-based Enterprise project team as well.

Suren started his career with the Hospitality Services and Tourism Program at the University of Finance and Economics. Subsequently, he served as the general manager of UFE GLOBAL LLC, a food production company, and as the coordinator of the Collaboration



Түүний хувьд СЭЗИС-ийн “Зочлохуйн үйлчилгээ, аялал жуулчлалын хөтөлбөр”-өөс ажлын гараагаа эхэлжээ. Дараа нь “UFE GLOBAL” LLC хоол үйлдвэрлэлийн компанийн ерөнхий менежерээр ажиллаж байв. Сургуулийнхаа “Хамтын ажиллагаа бизнес хөгжлийн хүрээлэн”-гийн зохицуулагч болж, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байсан туршлагатай нэгэн. Тиймээс энэ туршлагадаа үндэслэн бичил төслүүдийн үйл ажиллагаанд болон санаачлагчдад төсөл боловсруулахад нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байгаа юм.

Тэрээр, “21-р зуунд дэлхий нийтээрээ онцлонхаржбайгааэнтрепренерсэтгэлгээг орон нутгийн өсвөр үеийнхэн, залуучуудад түгээж, хувь хүний үр чадварыг хөгжүүлж байгаа төслийн зөв зорилгын нэг хэсэг болж байгаадаа талархаж байдаг” хэмээн ярьж байна. Бизнес көүч Б.Сүрэн өөрийн санаачилгаар анхаарах чиглэлүүдийг тодорхойлох, оновчтой үйл ажиллагаа явуулах зорилгоор төслийн оролцогч талууд болон төслийн сумын зөвлөл, менторууд, ESEL хөтөлбөрийн багш нар, энтрепренер клубийн сурагчдаас “Бизнес көүчтэй хамтран ажиллах хэрэгцээг тодорхойлох судалгаа” авч үр дүнг нь нэгтгэн үйл ажиллагаандаа тусгаснаар цаашид төслийн үйл ажиллагааг орон нутагт амжилттай хэрэгжихэд нөлөөлнө хэмээн үзэж байгаа аж.

Бизнес көүчийн үндсэн үүргүүдийн нэг нь төслийн хүрээнд ESEL сургалтад хамрагдан бичил төслийн уралдаанд орж, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар зорьж буй болон хамрагдсан хүүхэд, залуучуудын баг, багш/зөвлөхөд дэмжлэг үзүүлэх юм. Мөн бичил төслүүдийг зах зээлтэй холбох, боломжит хөрөнгө оруулагч, хувиараа бизнес эрхлэгч, бусад санхүүгийн эх үүсвэртэй танилцуулж зуучлах, орон нутгийн холбогдох арга хэмжээ, үзэсгэлэнд оролцуулах явдал юм.

and Business Development Institute at that University. Through these roles, he gained extensive experience in both international and domestic projects. Now, drawing upon this expertise, he offers advice and support for subgrant team’s operations and the development of project proposals.

He says, “I am grateful to be involved in this project, which aims to nurture individual skills and instill the ‘Entrepreneurial mindset’ emphasized globally in the 21st century, particularly among local youth and young adults.”

Business coach B. Suren took the initiative to conduct research aimed at identifying high-priority areas and carrying out optimal activities. This research focused on determining the necessity for collaboration with a business coach among various project stakeholders, including the project board, mentors, teachers of the ESEL program, and students of the “Entrepreneur Club” in the target soums. He believes that by consolidating the research findings and integrating them into the project’s activities, it will greatly contribute to the successful implementation of the project in the future.

One of the primary duties of the business coach is to help the team of children and youth who engage in the subgrant project proposal writing competition subsequent to their completion of the ESEL training, with the objective of qualifying for the small grant program. This support extends to ESEL teachers and counselors as well. Additionally, the business coach is responsible for connecting subgrant projects to markets, connecting them to the potential investors, local businessmen and other financial resources, and facilitating their involvement in pertinent local events and exhibitions.

Consequently, he assisted children and young individuals engaged in subgrant projects to

Тиймээс бизнес көүч Б.Сүрэн Хүүхдийг Ивээх Сангийн Өвөрхангай аймаг дахь салбартай хамтран “Өвөрхангай түншлэл-Намрын баяр 2023” үзэсгэлэн худалдаанд бичил төсөл хэрэгжүүлж байгаа хүүхэд, залуусыг оролцуулсан нь тэдний борлуулалтын орлого нэмэгдэж, шинэ хэрэглэгч, захиалагчидтай болж, зах зээлээ тэлэхэд түлхэц өгсөн юм.

Мөн тэрээр, СЭЗИС-ийн “Хөтөлбөр инновацын төв”-ийн багш нартай хамтран төслийн оролцогч талууд, ESEL хөтөлбөрийн сурагчид, бичил

participate in the “Uvurkhangai Partnership – Autumn Festival 2023” trade fair in collaboration with the Uvurkhangai branch of Save the Children. As a result, these young entrepreneurs experienced an increase in sales income, acquired new customers, and successfully expanded their market reach.

Additionally, in collaboration with the teachers from the Program Innovation Center at the University of Finance and Economics, on-line training sessions on “Modeling Mindset” and “Entrepreneurial Thinking” were organized for project stakeholders, students of the



төсөл хэрэгжүүлж байгаа хүүхэд, залууст зориулан “Загварчлах сэтгэлгээ”, “Энтрепренер сэтгэлгээ” цахим сургалт зохион байгуулсан нь мэдлэг болоод сэтгэлгээний цар хүрээг тэлсэн үйл ажиллагаа болжээ.

Бизнес көүчийн дараагийн нэг үндсэн үүрэг бол “Орон нутгийн өсвөр үеийнхэнд

ESEL program, as well as children and young individuals involved in subgrant projects. The project team has observed that as a direct outcome of this training, participants have acquired valuable knowledge and expanded the scope of thinking.

The next primary responsibility of the business coach is to facilitate the successful ex-

хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн шинэлэг санаачилга болох орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж буй “Сургуульд суурилсан энтрепрайз” төсөлтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх юм. Б.Сүрэнгийн хувьд “UFE GLOBAL” хоол үйлдвэрлэлийн компанид ажилласан туршлагадаа тулгуурлан Богд сумын “Өглөөний цайг өөртөө” төсөл амжилттай хэрэгжихэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна. Хоол, хүнсний үйлдвэрлэл хүний эрүүл мэндтэй холбоотой байдаг учир маш хариуцлагатай бизнес. Иймд бизнес көүч мэдлэг туршлагадаа үндэслэн хоол үйлдвэрлэлийг бизнес талаас нь хөгжүүлэхийн зэрэгцээ санхүүгийн болон зөвлөх үйл ажиллагаа явуулж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлээ тэлэх боломж эрэлхийлж байгаа юм. Түүнчлэн сургуульд суурилсан энтрепрайзийн нэмэлт төслийн уралдаанд Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн “Үйлдвэрлэгч хүүхдүүд” төслийн багтай хамтран ажиллаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн нь өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлуудаас нэгэн онцлох үр дүн байлаа. Цаашид төслийн үйл ажиллагааг дэмжих, үнэлгээ хийх баг бүрдүүлж, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөжээ.

**Бизнескөүч Б.Сүрэн:** *Надад мэдлэг туршлага дутагдах явдал гардаг ч аль болох шинээр дахин судалж, хэрэгцээ шаардлагатай байгаа мэдээлэл, зөвлөмжүүдийг өгч ажиллаж байна. Ингэснээр хувь хүнийхээ хувьд олон талаар сурч хөгжиж, чадавхиж байгаагаа мэдэрдэг. Хувийн хичээл зүтгэл, хүчин чармайлтад нөлөөлж байгаа нэг зүйл нь Хүүхдийг Ивээх Сангийн зорилго, бусдын хөгжил, өөрчлөлтийн төлөө хариу нэхэлгүй, цаг наргүй хичээж байгаа хамт олных нь зүтгэл идэвх юм. Көүчийн үйл*

ecution of the School-based Enterprise project, which is a pioneering initiative within the framework of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented in local secondary schools. Suren’s previous experience at the food production company UFE GLOBAL has proven advantageous, enabling him to effectively collaborate and provide consultancy and support for the successful implementation of projects like the “Breakfast for Yourself” initiative in Bogd soum. The food production business itself carries great responsibility because food is directly linked to human health.

Hence, leveraging his expertise and background, the business coach is actively seeking opportunities to develop new products and expand the market, while offering financial and food technology consulting services. Furthermore, he collaborated with the team from the Producer Children project at the 2nd secondary school of Kharkhorin soum, helping them in designing and submitting a project proposal for an additional grant competition organized under the School-based Enterprise project, which ultimately resulted in their proposal securing the grant.

Looking ahead, he intends to assemble a dedicated team to oversee and assess project endeavors, offering ongoing mentorship and support.

**Business coach B. Suren:** *As a business coach, I often encounter gaps in my knowledge and experience. However, I actively seek out new knowledge and continuously strive to learn, sharing any insights and recommendations I acquire along the way. The relentless pursuit of learning not only enhances my capacity, but also fuels personal growth. Observing the dedication of the team, who selflessly work towards*

*ажиллагаагаа илүү үр дүнтэй болгохын тулд Хүүхдийг Ивээх Сангийн Өвөрхангай аймаг дахь салбараас дэмжлэг туслалцаа, чиглүүлэг авч хамтран ажилладаг. Өнгөрсөн хугацаанд хийсэн олон үйл ажиллагааны амжилт, үр дүн салбарын хамт олонтой салшгүй холбоотой.*

Түүний хувьд цаашид төслийн тогтвортой байдлыг хангаж ажиллах чиглэлээр Насан туршийн нэгжид суурилсан энпрепренер клубүүд байгуулж, Сумын залуучуудын хөгжлийн салбар зөвлөл болон залуучуудын хөгжлийн зөвлөлүүдтэй холбож, залуучуудыг нийгмийн асуудлуудаа хамтдаа шийдвэрлэх, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж бүрдүүлэхийг зорьж байна.

Бизнес көүч Б.Сүрэн: Загас барьж өгөх бус загас барих аргыг нь зааж өг” гэсэн Лао Цугийн хэлсэн үг бий. Миний бодлоор, боловсролд оруулсан хөрөнгө оруулалт үргэлж ухаалаг байдаг. Нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл болох хувь хүний хөгжлийг чухалчлан үзэж, орон нутгийн залуучуудын боловсролд хөрөнгө оруулж байгаа Хүүхдийг Ивээх Сангийн энэ төсөл миний харж, ойлгож байгаагаар маш үнэ цэнтэй, чухал ач холбогдолтой юм. Тиймээс бусдын боловсролд тус нэмэр болохыг хичээдэг хувь хүний үнэ цэн, итгэл үнэмшилтэй маань нийцдэг болохоор урамтай ажиллаж байна гэлээ.

*Көүч амжилтаа хэрхэн дүгнэх вэ? Хэн нэгний өмнөө тавьсан зорилго, зорилтыг биелүүлэхэд хөшүүрэг болж, чиглүүлэх, явах замыг нь тодорхойлж, амжилтад хүргэснээр көүчийн зорилго биелдэг.*

*the objectives of Save the Children and the welfare of others without expecting anything in return, further strengthens my commitment. To foster more effective collaboration, I rely on the support and guidance provided by the branch of Save the Children in Uvurkhangai aimag. The success of past initiatives owes much to the collaborative efforts of industry colleagues, highlighting the importance of teamwork and cooperation.*

To ensure the sustainability of the project, Suren established a lifelong unit-based Entrepreneur club, fostering connections between the club and the youth development councils at the soum branches. His goal is to provide opportunities for young people to collaboratively address social issues and expand their business activities.

Business coach B. Suren: Lao Tzu once said, “Instead of just giving fish, teach them to fish.” I believe investing in education is always a smart choice. This Save the Children’s project prioritizes individual growth as crucial for societal progress. By investing in the education of local youth, it provides valuable knowledge and opportunities for children and young people. Hence, I approach my work with enthusiasm as it aligns with my personal values and beliefs of striving to contribute to the education of others

*How does the coach evaluate success? Let me try to answer clearly and simply. A coach achieves their objective by helping individuals in reaching their goals and objectives, and by determining the best path to guide them towards success.*

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



## АМЖИЛТАД ХӨТӨЛСӨН ХАМТЫН АЖИЛЛАГАА

### COLLABORATION FOR SUCCESS

Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийг Өвөрхангай аймагт хэрэгжүүлэхэд Худалдаа аж үйлдвэрийн салбар танхим үр дүнтэй хамтран ажилласан юм.

МҮХАҮТ-ын Өвөрхангай аймаг дахь салбар танхим сүүлийн 24 жил орон нутагтаа үйл ажиллагаа тасралтгүй явуулж байна. Бизнесийн салбар, тэр дундаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоод, аж ахуйн нэгжүүдтэй нягт холбоотой ажиллаж иржээ. Тус байгууллага нь бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байх зорилготой юм.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн Аймгийн зөвлөл (ТАЗ) 2020 онд байгуулагджээ. Төслийн үйл ажиллагааг аймаг, орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхэд аргазүйн дэмжлэг үзүүлэх зорилготой энэ зөвлөлд Худалдаа, аж, үйлдвэрийн танхим (ХАҮТ)-ын дарга Б.Ууганбаяр гишүүнээр орж ажилласан нь хамтын ажиллагаа бэхжих, хөгжих үндэс болжээ. Зорилтот сумдад төслийн үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэх Төслийн сумын зөвлөл (ТСЗ) байгуулагдахад ХАҮТ-ын дарга Хүүхдийг Ивээх Сангийн салбартай хамтран зорилтот сумдаар хамтдаа очиж ажиллахдаа ТСЗ-ийн гишүүнээр сум, орон нутагтаа бизнес эрхэлдэг ХАҮТ-ын гишүүдийн төлөөллүүдийг бүрэлдэхүүндээ багтаасан байна. Үүний үр дүнд зорилтот сумдад тогтмол бизнес эрхэлж байгаа, олон

The Uvurkhangai branch of the Mongolian National Chamber of Commerce and Industry (MNCCI) effectively collaborated with Save the Children to implement the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project in Uvurkhangai province.

For the past 24 years, the Uvurkhangai branch of MNCCI has been active in the region, working closely with the business sector, particularly small and medium-sized enterprises, cooperatives, and other business entities. The goal of MNCCI is to influence, advocate for, facilitate, connect, and support business development in the region.

As part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, the Aimag Level Counsel (ALC) was established in 2020 to provide methodological support for the effective implementation of project activities within the province. The inclusion of B. Uuganbayar, Chairman of the MNCCI, as a member of the Counsel has been instrumental in strengthening collaboration with the MNCCI.

Additionally, when the Project Soum Level Counsel (SLC) was being established to implement project activities in the target soums, the Chairman of MNCCI, in collaboration with the Save the Children branch, visited these soums. During these visits, members of MNCCI who were operating businesses locally were invited to join the SLC. As a result, experienced entrepreneurs who had been run-

ning businesses in the targeted soums now have the opportunity to provide mentoring support to children and youth in those areas. This initiative yielded excellent results, as mentors with extensive business experience shared their knowledge and made a significant intellectual investment in the children and youth of their soum. During the subgrant competition held in February 2024, Save the Children launched the “Searching for Sharks” campaign with the aim of encouraging local businesses to support and invest in project proposals developed by the children and youth.

The collaboration with MNCCI within the framework of the “Searching for Sharks” campaign had a significant impact, encouraging large numbers of province and soum business owners, as well as Chamber leaders, to actively participate in the Pitch competition and provide financial support to project proposals. As a result, 8 business owners from Bat-Ulzii, Guchin-Uus, Sant, and Khujirt soums, along with representatives from the target soums’ authorities, took the initiative and personally participated in the Pitch event. Through this collaboration, a total of 3.8 million MNT in financial support was provided to 5 teams, and a business owner from Bat-Ulzii soum agreed to support the Lifelong Learning Unit’s youth project by offering a workspace.

Увурхангай аймаг дахь ХАҮТ нь аймгийн брэнд бүтээгдэхүүнүүдийг нэг дор төвлөрүүлэн сурталчлах, жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, чанарын шаардлагад нийцсэн, шинэ бүтээгдэхүүнээр хангах, улмаар орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилготой байгуулагдсан “Өвөрхангайд үйлдвэрлэв” төвийг хариуцан ажилладаг. Тус төвөөр дамжуулан бичил төсөл хэрэгжүүлж байгаа сурагчид, сумын залуусыг дэмждэг юм. Тодруулбал, төслийн хүрээнд бичил санхүүжилт авч төслөө хэрэгжүүлж байгаа багуудын сурагчид, сумын

ning businesses in the targeted soums now have the opportunity to provide mentoring support to children and youth in those areas. This initiative yielded excellent results, as mentors with extensive business experience shared their knowledge and made a significant intellectual investment in the children and youth of their soum. During the subgrant competition held in February 2024, Save the Children launched the “Searching for Sharks” campaign with the aim of encouraging local businesses to support and invest in project proposals developed by the children and youth.

The collaboration with MNCCI within the framework of the “Searching for Sharks” campaign had a significant impact, encouraging large numbers of province and soum business owners, as well as Chamber leaders, to actively participate in the Pitch competition and provide financial support to project proposals. As a result, 8 business owners from Bat-Ulzii, Guchin-Uus, Sant, and Khujirt soums, along with representatives from the target soums’ authorities, took the initiative and personally participated in the Pitch event. Through this collaboration, a total of 3.8 million MNT in financial support was provided to 5 teams, and a business owner from Bat-Ulzii soum agreed to support the Lifelong Learning Unit’s youth project by offering a workspace.

Uvurkhangai province’s MNCCI operates the “Made in Uvurkhangai” center, which was established to promote the province’s local brands, support small and medium-sized businesses (SMEs), sell local goods, supply new, high-quality products and ultimately, foster the development of SMEs in the province.

The center supports local students and youth. For example, the teams that received subgrants and are actively implementing their projects have been selling their goods through the “Made in Uvurkhangai” center

залуусын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг “Өвөрхангайд үйлдвэрлэв” төвөөр дамжуулан 2022 оноос хойш борлуулж байна. ESEL хөтөлбөрийг амжилттай төгссөн, төсөл нь дэмжигдэж санхүүжилт авч үйлдвэрлэлээ эхлүүлсэн багуудын бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан, борлуулахад үнэтэй хувь нэмэр оруулж байна.

2024 оны 6 дугаар сарын байдлаар



“Өвөрхангайд үйлдвэрлэв” төвөөр таван сумын 10 төслийн багийн 15 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг тогтмол борлуулж байгаа юм. Тухайлбал, Хархорин сумын Гүнзгий сургуулийн “Doctor colors” төслийн багийн аяга, бэлэг дурсгалын зүйлс, Хархорин сумын 2 дугаар сургуулийн “Төгс зохиол” төслийн олон төрлийн лаа, давсан урлалууд, “Цүнхний шинэ эрин үе” төслийн даавуун цүнхнүүд, Орхон сургуулийн “Хорум урлан” төслийн модон бэлэг дурсгалууд, Богд сумын 2 дугаар сургуулийн “Nature craft” төслийн давсан урлалын бэлэг дурсгал, Богд сумын нэгдүгээр сургуулийн “Шагайн наадгай” төслийн шагайн наадгай олбог, 2 дугаар сургуулийн “Ухаан заяа” төслийн уран зургууд, Насан туршийн суралцахуйн нэгжийн “Уран гоцгоо” төслийн нэхмэл гутлууд, Сант

since 2022. The center plays a crucial role in promoting and selling the products of teams that have successfully completed the ESEL program, received funding for their projects, and started production. As of June 2024, more than 15 types of products from 10 project teams across 5 soums are regularly sold through the center.

These products include cups and souvenirs from the “Doctor Colors” project of Gunzgii School in Kharkhorin soum, various candles and handmade salt dough crafts from the “Perfect Harmony” project of Kharkhorin soum school No. 2, cloth bags from the “New Era of Bags” project, wooden souvenirs from the “Khorum Uurlan” project of Orkhon school, handmade salt souvenirs from the “Nature Craft” project of Bogd soum school No. 2, felt mat for playing ankle bones game from the “Shagain Naadgai” project of Bogd soum school No. 1, paintings from the “Ukhaan Zaya” project of school No. 2, woven shoes from the “Uran Gogtsoo” project of the Lifelong Learning Unit, ornaments from the “Mongol Jewelry” project by Sant soum general secondary school students, and incense from the “Mongol Incense” project by the

сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Монгол гоёл” төслийн гоёл чимэглэлүүд, Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн “Монгол хүж” төслийн хүж зэрэг олон бүтээгдэхүүнийг дурдаж болно. Эдгээр бүтээгдэхүүний нийт борлуулалт 2,5 сая төгрөг болжээ. ХАҮТ үүнээс гадна зорилтот сумдын Насан туршийн суралцахуйн нэгжийн ESEL хөтөлбөр төгсөж, санхүүжилт авч төслөө хэрэгжүүлж байгаа сумын залуусыг “Өвөрхангай намрын баяр-2023” түншлэл, үзэсгэлэн худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан юм. Энэ нь гарааны бизнесээ эхлүүлж байгаа сумын залууст бүтээгдэхүүнээ сурталчилах таатай боломж болжээ.

ХАҮТ-ын дарга Б.Ууганбаяр “Энэ төсөл цаг үеэ олсон, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг багаас нь бизнесийн болон амьдрах ухаанд сургахад томоохон хувь нэмэр оруулж байгаа их онцлогтой. Зорилтот сумдын 14-25 хүртэлх насны залуус уг төсөлд хамрагдсанаар олон талаар хөгжөөд зогсохгүй гарааны бизнесээ эхлүүлж байна. Товчхондоо энэ төслийн хүрэх үр дүн нь ХАҮТ-ын зорилготой явцав нийцэж байгаа учир цаашид төслийн арга зүйг нутагшуулан авч үлдэх, төслийн тогтвортой байдлыг хангахад ХАҮТ-ын хамтын ажиллагаа чухал шаардлагатай гэж үзэж байна. Төсөлд хамрагдаж бизнесээ өргөжүүлж байгаа сумын залуус ирээдүйд ХАҮТ-ын тэргүүлэгч, албан ёсны гишүүн болж Монголын төдийгүй олон улсын туршлагаас судалж, бизнесээ улам хөгжүүлэх боломжтой” хэмээн ярилаа.

Аливаа төсөл орон нутагт үр өгөөжтэй хэрэгжих үндэс суурь нь урт хугацааны, тууштай түншлэл байдаг гэдгийг Өвөрхангай аймаг дахь ХАҮТ болон төслийн салбар хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа харуулж байна.

Polytechnic College in Uvurkhangai province. The total sales of these products amounted to 2.5 million MNT.

MNCCI helped to support the youth from the target soums who completed the ESEL program through the Lifelong Learning Unit, received funding and implemented their projects. These young people received assistance to participate in the “Uvurkhangai Autumn Festival-2023” trade fair. Taking part in the provincial trade fair proved to be a significant boost for these aspiring entrepreneurs, helping them promote their products to the public and attract more customers.

MNCCI Chairman B. Uuganbayar stated, “This project was both timely and impactful. It made a significant contribution by equipping secondary school students with essential business and life skills from an early age. Through this project, young people aged 14-25 in the target soums not only experience personal growth, but also gain the opportunity to start their own businesses. The project’s outcomes align closely with the objectives of MNCCI. It is evident that MNCCI’s collaboration will play a crucial role in further adapting the project’s methodology to local needs, and ensuring its long-term sustainability. Moreover, the young entrepreneurs participating in this project will have the potential to become leaders and official members of MNCCI in the future, learning from both national and international experiences as they grow and expand their businesses.”

The effective cooperation between the MNCCI in Uvurkhangai Aimag and the project branch office demonstrates that the foundation for successfully implementing any project in the local community lies in long-term, consistent partnerships.

Published in 2024

2024 онд хэвлэгдсэн





## ЭРҮҮЛ ХҮНС ТАРИАЛДАГ ЭКО СУРГУУЛИЙНХАН

## ECO SCHOOL STUDENTS GROW HEALTHY FOOD

### Экологи болон амьдрах ухааны ур чадвар олгодог төрөлжсөн сургууль болох зорилготой

Ховд аймгийн Зэрэг сум нь эрс тэс уур амьсгалтай, газар тариалан эрхлэхэд бэрх, гөлтгөнөтэй, давсархаг хөрс бүхий газар нутагтай. Гэвч бэрхшээлийг даван туулж, эрүүл, чанартай хүнсний ногоо тариалж ургуулан, сургуулийн сурагчид болон сумын иргэддээ үйлчилж буй хамт олны амжилтын түүхийг хуваалцъя.

Ховд аймгийн Зэрэг сум аймгийн төвөөсөө 160, нийслэлээс 1284 км алслагдсан, эрс тэс уур амьсгалтай, салхины хурд 14-55 м/сек хүрч шуурдаг, хөрс нь гөлтгөнөтэй, давсархаг учраас газар тариалан эрхлэхэд зохимжтой биш хэмээн судлагдсан байдаг. (Сургуульд суурилсан энтерпрайзийг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох судалгааны тайлан О.Бүрэнжаргал 2021 он)

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургууль нь Хүүхдийг Ивээх Сангийн “Орон

### The goal is to transform into a specialized school that imparts ecological knowledge and strengthens life skills

Zereg soum in Khovd province faces harsh climate conditions and soil challenges, with gypsum and saline land that makes farming difficult. We want to proudly share the success story of a community that has overcome these challenges, grown healthy vegetables, and provided fresh produce for both the schoolchildren and the people of the soum.

Zereg soum in Khovd province is located 160 km from the provincial center and 1,284 km from the capital city. The soum experiences a harsh climate, with wind speeds ranging from 14 to 55 m/sec, and its gypsum-rich, saline soil makes it unsuitable for farming. (Research Report on the Feasibility of Implementing a School-Based Enterprise, O. Burenjargal, 2021)

Zereg soum School participated in the

нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд төсөл хэрэгжүүлж буй таван аймгийн зорилтот сумдын сургуулиудын дунд зохион байгуулсан “Сургуульд суурилсан энтерпрайз” (ССЭ) хэрэгжүүлэх төслийн уралдаанд “Эко хүнс” төслөөр оролцон шалгарч

107.5 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Энэ мөнгөөр хүлэмжийн болон гадна талбайн тариалалтад шаардлагатай багаж төхөөрөмж, үр, үрсэлгээ худалдан авч, хоёр ч хүлэмж, хашаа хамгаалалт барьсан байна. Орон нутгаас гадна талбайн тариалалт эрхлэх дөрвөн га газар олгожээ.

“Эко хүнс” ССЭ нь удирдлагын, сургалт судлагдахууны, маркетинг борлуулалтын, тариалалтын, гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын баг, сурагчдын клуб гэсэн бүтэцтэй. Үйлэжиллагаанд нь энтрепренер клуб, эко клубийн сурагчид бусдыгаа манлайлан оролцохоос гадна сургуулийн нийт багш, ажилчид гар бие оролцон тариалалт, арчилгаа, хураалтыг хамтдаа хийж, бодит үр дүнд хүрч байна. Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 8а ангийн сурагч Б.Анар “Манай сургууль хүлэмж, ногооны талбайтай. Бид ангиараа очиж ажилладаг. Ногооны талбайн чулуу түүж, хүлэмжинд үрсэлгээ бэлдэж ургуулдаг. Харин ээлжээр усалдаг юм.

Цэг шиг жижигхэн байсан үр яаж ургаж, хичнээн өндөр болж, үр жимсээ өгч байгааг ажиглах үнэхээр гоё. Дотуур байрандаа тарьж ургуулсан ногоотой хоол идэх бүр ч сайхан. Би ногоо тарьж ургуулах мэдлэгтэй болсондоо баяртай байна” хэмээн ярилаа.

Багш бүр “Эко хүнс” ССЭ-ийн үйл ажиллагааг судлагдахуунтай уялдуулах боломжийг эрэлхийлж, хичээл төлөвлөлтөө хийж, сурагчид сургуульд суурилсан энтерпрайзийг олон нийтэд таниулах, нөлөөлөх ажлуудыг санаачлан гүйцэтгэдэг юм. Зуны амралтаар нярав, сантехникч нар талбай, хүлэмжийн усалгаа, арчилгааг голлон хариуцдаг байна.

Сургуулийн хамт олонд анх туршлага

“School-Based Enterprise” project competition, which was organized among schools in the target soums of five aimags implementing Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project. The school received 107.5 million MNT in funding for their “Eco Food” project proposal. With this funding, they purchased the necessary equipment and seeds for growing vegetables both in greenhouses and outdoors, and constructed two greenhouses and fences. The local government also provided 4 hectares of land for vegetable cultivation.

The “Eco Food” school-based enterprise is made up of several teams: management, training, marketing and sales, cultivation, external relations, investment, and the student club. Students from the Entrepreneur Club and Eco Club lead these activities, while all teachers and staff at the school actively participate in planting, tending, and harvesting together, while contributing to the project’s tangible results.

B. Anar, an 8th-grade student at Zereg soum General secondary school shared, “Our school has a greenhouse and a vegetable plot where our class works. We clean the vegetable plot by removing the stones, and prepare and plant seedlings in the greenhouse. We take turns watering the plants. It’s amazing to watch a tiny seed, like a dot, grow taller and eventually bear fruit. It’s even better to eat the vegetables we’ve grown right in our dormitory. I’m glad to have learned how to grow vegetables.”

Each teacher looks for opportunities to integrate the activities of the “Eco Food” school-based enterprise into their lesson topics and develops their lesson plans accordingly. Students take the lead in initiating and carrying out activities to promote the enterprise to the public and conduct advocacy efforts. During the summer holidays, the stockkeeper and plumber are primarily responsible for watering and maintaining the fields and greenhouses.



дутмаг байв. “Эко хүнс” ССЭ-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Ховд аймгийн “Хөгжил” политехник коллежийн газар тариалангийн зөвлөх багш нараас Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгээр гурван удаа сургалт авсан юм. Ингэж тэд тариалалт эрхлэх мэдлэг, арга зүй, ур чадвараа нэмэгдүүлсэн байна. Дээр дурдсанчлан, Зэрэг сумын сургуулийнхан ССЭ-аа хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байсны нэг нь эрс тэс цаг агаар байлаа. 2023 оны хаврын 28 м/с хурдтай шуурганд нэг хүлэмж нь хийссэн ч, үлдсэн нэг хүлэмж болон нэг га гадна талбайн тариалалтаас 3,1 тонн хүнсний ногоо хурааж, сургуулийнхаа үдийн цай,

The school initially lacked experience in running such an enterprise. To successfully implement the “Eco Food” school-based enterprise, they received three training sessions from agricultural experts at the “Khugjil” Polytechnic College in Khovd province, with support from Save the Children. These sessions helped enhance their knowledge, methods, and skills in farming. As mentioned earlier, the students at Zereg soum School faced several obstacles in implementing their school-based enterprise, one of which was the extreme weather.

Although one greenhouse was destroyed in a 28 m/s storm in the spring of 2023, 3.1 tons of vegetables were harvested from the remaining greenhouse and 1 hectare of vege-



дотуур байрын хүнсэнд нийлүүлснээс гадна сумын иргэдэд борлуулж 5,7 сая төгрөгийн орлого олжээ.

Тэд хавар бүр сурагчдынхаа тусламжтайгаар үр, үрсэлгээ бэлтгэж, хүлэмжиндээ чинжүү, улаан лооль, хоёр төрлийн өргөст хэмх, юуцай зэрэг нарийн ногоо, гадна талбайдаа тарвас, төмс,

table plot. The harvested produce was used in school lunches and dormitory meals, and was also sold to the people of the soum, generating 5.7 million MNT in revenue.

Every spring, they prepare seeds and seedlings with the help of their students, growing vegetables like peppers, tomatoes, two types of cucumbers, and bok choy in the greenhouse,

байцаа, чацаргана тариалдаг. Намар 9-10 дугаар сард ургацаа хурааж, сургуулийнхаа гаднах борлуулалтын цэгт болон захиалга авч, хүргэлтээр зардаг аж. Жил бүрийн намар зохион байгуулдаг “Манай сургууль-Малчны хотонд” аяны хүрээнд ургацын дээжээ багуудын төвд хүргэж, малчдад үйл ажиллагаагаа танилцуулж, ногоогоо борлуулдаг. Эцэг эхчүүд хүүхдүүдийнх нь гар бие оролцож, тарьж ургуулсан эрүүл хүнсний ногоог худалдан авахдаа баяртай байдаг байна. Цаашид тарих ногооны төрлөө нэмэгдүүлж, багц бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж, “Eco food” гэсэн логотой болжээ.

Сургуулийн захирал Ч.Төмөрмөнх “Монгол Улсын хэмжээнд сургуульд суурилсан энтерпрайз хэрэгжүүлж буй анхдагч зургаан сургуулийн нэг болж, шинэ туршлага бий болгон, боловсролын салбараа түүчээлж байгаадаа баяртай байна. Энэ бол өндөр үүрэг хариуцлага юм. Цаашдаа баруун бүсийн жишиг сургуульд суурилсан энтерпрайз болж, үйл ажиллагаагаа өргөжүүлнэ гэдэгтэй итгэлтэй байна” гэлээ.

“Эко хүнс” ССЭ нь эрүүл хүнс тариалахаас гадна Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эрүүл хооллолт болон хүнсний ногооны ашиг шимийн талаар мэдлэгтэй, байгалийн ухааны туршилт, судалгаанууд хийх чадамжтай, экологийн хийгээд амьдрах ухааны ур чадвартай болгох зорилгоор хүлэмж, гадна талбайг дадлага туршилтын бааз болгон ашиглаж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн сургууль болохоор зорьж байгаа юм.

while cultivating watermelons, potatoes, cabbage, and sea buckthorn in the planting fields. They harvest the crops in September and October, selling them through the school’s sales outlet or via delivery.

As part of the annual “Our School - Herders’ Camp” campaign, held every fall, samples of the harvest are delivered to the bagh center, where herders are introduced to the school’s activities and the vegetables are sold. Parents are happy to purchase healthy vegetables grown with the help of their children. Looking ahead, they plan to expand the variety of vegetables they grow, produce packaged products, and they have even created their own logo, “Eco Food.”

The school’s director, Ch. Tumurmunkh, shared, “I am proud to be part of one of the first six schools in Mongolia to implement a school-based enterprise, introduce new practices, and take a leadership role in the education sector. I also view this as a great responsibility. I am confident that, in the future, we will expand our efforts and become a model school-based enterprise in the western region.”

In addition to growing healthy food, the “Eco Food” school-based enterprise aims to equip students at Zereg soum’s general secondary school with knowledge about healthy eating and the benefits of vegetables, provide them with the ability to conduct natural science experiments and research, develop ecological and life skills, and serve as a specialized school offering job and professional orientation, with greenhouses and outdoor areas used as practical training and testing grounds.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Сургуульд суурилсан энтерпрайзын түүхүүдийг англи хэлээр уншиж, танилцуулга видеог үзнэ үү.

Read the success story of the School-Based Enterprise and watch the videos in English



## ДЭЛХИЙД ГАРГАХ ЗАМЫН “ИНЖЕНЕР”

### LOCAL “ENGINEERS” PAVING THE ROAD TO THE WORLD

Бичил төсөл амжилттай хэрэгжих нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Орон нутгийнхаа онцлогийг мэддэг, чадавхтай хүмүүсийн зөвлөгөө, дэмжлэг хамгийн чухал. Тэдгээр хүмүүсийн төлөөлөл болох “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн сум дахь Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан гишүүнийг онцолъё. Зорилтот сумдын сурагчид “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” ESEL сургалт төгсөж, баг болон нэгдэж, төсөл бичин, пич уралдаанд оролцдог. Шалгарсан багууд төсөлдөө санхүүжилт авч, бизнес санаагаа хэрэгжүүлдэг. Тэгвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан гишүүд төслийн эхэн, дунд, төгсгөл гэсэн гурван үе шатанд хэрэгжилтийн явцыг бүхэлд нь хянаж байдаг. Тэд мөн төслийн багуудад үр дүнгээ яаж тайлагнах вэ, зорилгодоо хүрэхэд цаашид юуг анхаарах вэ гэхчлэн зөвлөгөө байнга өгдөг.

П.Ганчимэг их эмчийн мэргэжилтэй, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн даргаар ажилладаг. Анх төслийн Сумын зөвлөл байгуулагдахад Шивээговь сумын Засаг даргаар ажиллаж байсан бөгөөд төслийн Сумын зөвлөлийн даргаар томилогдож байв.

Тэрээр, “Энэ хариуцлагатай албанд зүтгэж эхэлсний анхны бөгөөд чухал санал бол төсөлтэй хамтран ажиллах байлаа. Төслийн Сумын зөвлөлийн даргаар томилогдож, сумын ИТХ-д танилцуулахдаа энэ төслийг сайн хэрэгжүүлэх ёстой. Хүүхдүүдийн ирээдүйд хэрэг болох ёстой. Шивээговийн

The success of a subgrant project depends on many factors, but the advice and support of individuals who understand the specific needs of the locality are crucial. The local team members of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, responsible for monitoring, and evaluation, are precisely those individuals.

Students from the target soums complete the “Entrepreneurship-Based Personal Skills Development” (ESEL) training, form teams, develop project proposals, and participate in pitch competitions. The selected teams receive funding to implement their business ideas. Monitoring, and evaluation focal points oversee the entire implementation process at three key stages: the beginning, middle, and end of the project.

They also regularly provide guidance to project teams on how to report their results and what areas to focus on moving forward to achieve their goals.

P. Ganchimeg is a medical doctor and the head of the Shiveegobi soum Health Center in Gobisumber province.

When the project Soum Level Counsel (SLC) was first established, she was serving as the governor of Shiveegobi soum. Later, she was appointed as the head of the project SLC.

She said, “When I took on this responsible position, the first and most important proposal I made was to collaborate on the project. After being appointed head of the project’s SLC, I presented the idea to the Soum Khural. I believed that this project must be implemented effectively, as it would significantly benefit the future of our children. I saw it as a pathway for the children of Shiveegobi Soum to connect with the world.” P. Ganchimeg stepped down

хүүхдүүдийн дэлхийд гарах зам байж мэднэ хэмээн бодож байсан” гэлээ.

П.Ганчимэг сумын Засаг даргын үүрэгт ажлаа 2023 онд хүлээлгэж өгчээ. Төслийн Сумын зөвлөлийн даргаар шинэ Засаг дарга ажиллах болсон тул төслийн хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтнаар үргэлжлүүлэн ажиллах болов. Эхлүүлсэн ажлынхаа үр шимийг үзэх боломж олгосон саналыг баяртайгаар хүлээн авчээ.

П.Ганчимэг сургалтаар олж авсан мэдлэг, чадвар болон Сумын зөвлөлийн даргаар ажиллаж байсан туршлагадаа үндэслэн амжилттай ажиллаж байна. Тэрээр, санхүүжилт

авч шалгарсан багийн багш, сурагчдад төслөө хэрэгжүүлж эхлэхээс өмнө мэдээлэл зөвлөгөө өгч чадавхжуулах, төслийн явц болон эцсийн тайлан мэдээг үнэн зөв гаргах, төслийн үндсэн чиг үүргээс хазайхгүй, тогтвортой ажиллахад нь дэмжлэг үзүүлдэг юм. “Wifi zone” төслийн багийн үйл ажиллагааны менежер Э.Баясгалан “Бид санхүүжилт авч, үйл ажиллагаагаа эхлээд бодит бэрхшээлтэй тулгарсан. Байгаа төсөвтөө тохируулан сургуулийн коридорын хэсгийг Wifi zone орчин болгосон. Гэвч хүүхдүүд сургуулийн орчинд хичээлээс гадуур сууж ажиллах хугацаа дунджаар 1-2 цаг байлаа. Нэг сарын үйлчилгээний төлбөрөө 5000 төгрөгөөр тогтоосон нь хүүхдүүдийн интернэт ашиглах хугацаатай харьцуулахад өндөр байв. Үнэ буулгах боломжгүй байсан тул сумын хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан П.Ганчимэгт хандсан юм. Тэрээр бидэнд энэ асуудлыг шийдвэрлэх зохистой арга зам зөвлөсөн. Нэг анги дунджаар 25 сурагчтай, бүгд хямд үнээр интернэт хэрэглэх сонирхолтой. Иймээс анги удирдсан багш нартай уулзаж, сарын турш ангиараа 20000 төгрөгөөр



as the governor of Shiveegobi soum in 2023. With the new Governor taking on the role of head of the project SLC, she gladly accepted the position of monitoring, and the evaluation focal point, as it allowed her to witness the results of her efforts. P. Ganchimeg is now applying her knowledge and skills—gained through training and her experience as head of the project SLC—to work successfully within the project. She provides valuable information and advice to the teachers and students of subgrant-selected project teams before they begin implementing their projects. She also assists in developing accurate progress and final reports, ensuring the teams stay on track and work sustainably while remaining aligned with the project’s main objectives. “We received funding and faced real challenges when we started our activities,” said E. Bayasgalan, the operations manager of the “Wifi Zone” project team. “We converted a school corridor into a Wi-Fi zone within our existing budget. However, the average time children spent in the school environment and outside of school hours was only 1-2 hours. The monthly service fee was set at 5,000 MNT, which seemed high given the limited time children used the internet. Since lower-

интернэт хязгааргүй ашиглах санал тавихад дэмжсэн. Ингээд төслөө саадгүй хэрэгжүүлэх боломжтой болсондоо талархаж явдаг” гэж ярилаа.

Өнөөдрийн байдлаар Шивээговь суманд нийт 16 бичил төсөл амжилттай хэрэгжээд байна. П.Ганчимэг “Би сумынхаа айл өрх бүрд хүрч, хүн бүрд туслах эмчийн үүрэгтэй. Үүний зэрэгцээ орон нутгийн хүүхэд бүрийн хүслийг сонсож, тэднийг чадавхжуулж, зорилгынхоо төлөө хүсэл тэмүүлэлтэй байж, хамтран ажиллах, бусдыг сонсож, бусдаас суралцах, хамгийн гол нь өөрт тулгарсан аливаа асуудлаа харж, дангаар болон багаараа шийдвэрлэх тэр боломжийг олгосон төсөлтэй хамтран ажиллаж байгаадаа талархдаг.

Манай сумаас шалгарсан бичил төслүүд амжилттай хэрэгжихэд төслийн сумын зөвлөлийн гишүүдийн хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, сургуулийн удирдлага, чиглүүлэгч багш нар, бизнес көүч, төслийн орон нутгийн зохицуулагч, маш олон хүний хичээл зүтгэл оролцсон, төсөл хэрэгжүүлэгч хүүхэд, залуусын хүсэл тэмүүлэл, урам зориг ч байсан. Энэ бүхэн нэгдэж үр дүнд хүрсэн” хэмээн онцлон өгүүлэв.

Бидний яриа түүний “Хүүхэд бүрийн нандин хүсэл мөнхөд үргэлжлэх болтугай” хэмээсэн ерөөлөөр өндөрлөв.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



Төслийн оролцоо, дэмжлэгийн амжилтын түүхийг англи хэлээр уншина уу.

Read the success story of the project cooperation and support in English.

ing the price wasn't an option, we approached the soum's monitoring and evaluation focal point, P. Ganchimeg, for advice. She helped us find a reasonable solution to the problem. With an average of 25 students per class, all of whom were interested in accessing the internet at an affordable price, we met with the teachers and proposed unlimited internet access for the entire class for 20,000 MNT per month. They supported the idea, and we are grateful that we were able to implement our project smoothly.” To date, a total of 16 subgrant projects have been successfully implemented in Shiveegobi soum. P. Ganchimeg emphasized, “I am a doctor with a duty to reach every household in my soum and help everyone. At the same time, I am grateful for the opportunity to work with this project, which has allowed me to listen to the wishes of every local child, build their capacity, and pursue my goals with passion. It has also taught me the value of collaboration—working together, listening to others, learning from them, and most importantly, identifying and solving problems, either individually or as a team. The success of the subgrant projects selected from our soum can be attributed to the cooperation and dedication of the project's SLC members, the efforts of many individuals, including school administration, trainer facilitators, business coaches, local project coordinators, and the passion and enthusiasm of the children and youth implementing the projects. All of these efforts came together to achieve great results.”

Our conversation ended with her heartfelt blessing: “May the dreams and hopes of every child endure for a lifetime.”



## ЭНТЕРПРАЙЗАА СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБОСОН “ҮЙЛДВЭРЛЭГЧ ХҮҮХДҮҮД”

### “CHILD PRODUCERS”: INTEGRATING THE ENTERPRISE INTO THE SCHOOL CURRICULUM

Зураг дээрх хүүхдүүд бол Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 5 дугаар ангийн сурагчид юм. Тэд хичээлийн бус цагаар үйлдвэрлэл явуулж, жимстэй тараг савлаж байгаа нь энэ. Тус сургууль “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд “Үйлдвэрлэгч хүүхдүүд” сургуульд суурилсан энтерпрайз хэрэгжүүлж байна. Сургуулийн 4, 5 дугаар ангийн сурагчид жимстэй тараг бэлтгэх, савлах, борлуулах ажлыг хариуцдаг байна. Савлагч машины хажууд аюулгүй ажиллагааны дүрмийг томоор хэвлэн наажээ. Зааварчилгааг уншвал “Хүүхдүүд чиглүүлэгч багшийн зааврын дагуу ажиллана, савлагч машин

The children in the photo are 5th-grade students at Kharkhorin soum secondary school No. 2 in Uvurkhangai province. Outside of school hours, they are involved in producing and packaging fruit yogurt. This initiative is part of the school's “Child Producers” program, which is being implemented as a component of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for Vulnerable Youth in Rural Mongolia” project.

Students in grades 4 and 5 are responsible for preparing, packaging, and selling fruit yogurt. A large safety manual is displayed next to the packaging machine.

The instructions read: “Children must follow the facilitator's guidance at all times. They are not allowed to touch the buttons on the



ажиллаж, савлалт явагдаж байх үед товчлуурт хүрч болохгүй, хүүхдүүд зөвхөн уутыг савлагч хошуунд хийх, бэлэн болсон жүүсийг багцалж уутлах ажлыг хийнэ, савлах команд болон бусад тохиргоо хийх товчлуурт зөвхөн багш хүрч ажиллуулна, эрүүл ахуй, ариун цэврийг ханган малгай, бээлий, хормогчийг заавал өмсөнө” гэсэн байв. Малгай, хормогч, бээлийгээр ижилссэн хүүхдүүд үйлдвэрлэлээ явуулж, борлуулалтаа ч хийж байгаа нь харагдана. Хүүхдүүд багаасаа ажил хөдөлмөрт дуртай болж, хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгохоос гадна өөр нэг бодит дэвшил гарсан нь хүүхдүүд бүгдээрээ хичээлдээ сонирхолтой болж байна.

### Хичээлдээ ч, үйлдвэрлэлдээ ч сонирхолтой болсоор...

байгааньиймучиртай. 56 анги 28 сурагчтай. Тэд гурван багт хуваагдаж, чацаргана, нэрс, хад, аньс жимсний найрлагатай дөрвөн төрлийн тараг савлаж, борлуулна. Ингэхдээ зохион байгуулалтын оновчтой бүтэц бий болгож чаджээ. Тухайлбал, даваа гаригт эхний багийн 10 хүүхэд, тараг савлаж бэлэн болгоод, мягмар гаригт түүнийгээ худалдаж борлуулна. Харин хоёр дахь багийнхан мягмар гаригт үйлдвэрлэл явуулж, лхагва гаригт худалдана. Лхагва гаригт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн хүүхдүүд пүрэв гаригт борлуулах хуваарьтай. Хүүхдүүд үйлдвэрлэлийн дадлагаа ангидаа ч үргэлжлүүлнэ. Тухайлбал, монгол хэлний хичээлээр бүтээгдэхүүнийхээ ач холбогдлыг өгүүлсэн мэдээ бэлтгэж, зар сурталчилгааны эх зохионо. Харин математикийн хичээлээр тооцоолол хийнэ. Эхний багийнхан өдрийн орлого, зарлага, цэвэр ашгаа олж, долоо хоногийн дундаж орлогоо бодож байхад, дараагийн баг сарын нийт орлогыг

packaging machine while it is in operation. Children should only place the bags into the packaging nozzle and pack the finished product. Only the teacher is authorized to operate the machine's buttons and settings. To maintain hygiene and cleanliness, students must wear a hat, gloves, and apron.” These safety rules are printed in large, clear text.

Children, dressed in hats, aprons, and gloves, are seen producing and selling the yogurt. This hands-on experience helps them develop a fondness for work from an early age and understand the value of labor. Another positive outcome is that the children are becoming more interested in their schoolwork.

### This is why the students are so engaged in both their studies and the production process.

There are 28 students in class 5B, who are divided into three teams. Each team is responsible for packaging and selling four types of yogurt made with sea buckthorn, blueberries, rockrose, and cranberries. Through this experience, they've established an efficient organizational structure. For example, on Mondays, 10 children from the first team package the yogurt, and on Tuesdays, they sell it.

The second team handles production on Tuesdays and sells the yogurt on Wednesdays. The children who produce the yogurt on Wednesdays are scheduled to sell it on Thursdays. At school, they continue the work they did in the production workshop, applying it in the classroom. For example, during their Mongolian language lessons, they prepare news reports highlighting the importance of their product, and design ads.

In math class, the children work on financial calculations for their business. The first team

тооцно. Гурав дахь баг жилийн орлогоо сар, сараар гаргажээ. Нэг хүүхэд өдөрт нэг уут тараг уудаг. Бүтээгдэхүүнийхээ амтлагаа хийнгээ амин дэмээ нөхөж, ажлын хөлсөө авч байгаа хэрэг. Уусан тарагнахаа мөнгийг орлогоосоо хасаж бодно. Хүүхдүүдийн тооцоо маш нарийн. Сарын нийт өдрөө ажлын 22 хоногоор тооцсон байх жишээтэй. Цахилгаан, байрны зардлыг сургууль хариуцдаг тул зардлаасаа хасаж тооцсон байв. Ангиараа нэгж бүтээгдэхүүний зардлыг гаргажээ.

Сонирхуулбал, “Нэг уут 200 төгрөг, 200 ширхэг уут 40000 (Уутаа багцаар нь авдаг бөгөөд нэг багцад 200 ширхэг байдаг), 1 кг жимс 15000, 1 кг тараг 3000, 1 кг элсэн чихэр 5500, 20 литр тараг 60,000 төгрөг

tracks their daily income, expenses, net profit, and average weekly income, while the next team determines their total monthly income.

The third team calculates their annual income by month. Each child drinks one bag of yogurt a day, replenishing their nutrients while earning their wages. The cost of the yogurt they drink is deducted from their income. The children's calculations are very precise. For example, they determined that there are 22 working days in a month. Since the school covers electricity and housing costs, these expenses were deducted from their calculations.

The class calculated the unit cost of the product. For example, “One bag costs 200 MNT, and 200 bags cost 40,000 MNT (since bags are purchased in packs of 200). The cost of





болно. 20 литр тарганд 1 кг жимс, 0,5 кг элсэн чихэр хольж, 200 мл хэмжээгээр савлаж, нэг бүрийг нь 1500 төгрөгөөр зарна” гэхчлэн нарийн тооцоо, задаргаа үргэлжилнэ. Тэгвэл эрүүл мэндийн хичээлээр жимстэй тараг хүний биед ямар ач холбогдолтой талаар ярилцаж, зохион бичлэг хийсэн байна. Зураг, технологийн хичээлээр жимстэй таргийг хэрхэн хадгалдаг вэ сэдвээр зурж, хадгалах хэмийг хэмжиж үзнэ.

“Үйлдвэрлэлийг сургалтын хөтөлбөртэй уялдуулснаар гарч байгаа үр дүн олон” хэмээн Өвөрхангай аймгийн Хархорин сумын 2 дугаар сургуулийн 5б ангийн багш М.Гантуяа танилцуулав. Тэрээр, “Хүүхдүүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ маш сайн тооцоолж чаддаг. Үйлдвэрлэлийн дадлагыг хүүхдүүд хичээлтэй холбосноор сонирхолтой болсон. Багаасаа санхүүгийн боловсролд суралцаж, багаар ажиллах

ingredients is as follows: 1 kg of fruit costs 15,000 MNT, 1 kg of yogurt costs 3,000 MNT, 1 kg of sugar costs 5,500 MNT, and 20 liters of yogurt costs 60,000 MNT. In the production process, 1 kg of fruit and 0.5 kg of sugar are mixed with 20 liters of yogurt, which is then packaged into 200 ml bags. Each bag is sold for 1,500 MNT.” This is how the detailed calculation and cost breakdown is made.

In the health lesson, the students discussed the benefits of fruit yogurt for the body and wrote an essay on the topic. In the drawing and technology lesson, they drew pictures of stored fruit yogurt and calculated measurements. M. Gantuya, a 5B grade teacher at School No. 2 in Kharkhorin soum, Uvurkhangai province, presented the results of integrating production into the curriculum.

She said, “The children are able to make financial calculations for the products they produce with great accuracy. Engaging in production

чадвартай болж байна. Үйлдвэрлэлийн бодит жишээг хичээлдээ ашигласнаар хүүхдүүдийн идэвх оролцоо эрс нэмэгдсэн. Тэд ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэдий хэмжээгээр савлаж, өдөрт хичнээн бүтээгдэхүүн борлуулдаг вэ гэдгээ хамгийн сайн мэднэ. Сайн мэддэг жишээг хичээлдээ ашиглах нь илүү сонирхолтой, үр дүнтэй байсан” гэж ярилаа.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн “Үйлдвэрлэгч хүүхдүүд” сургуульд суурилсан энтерпрайз нь ахлах ангийнхны радио электроник, ухаалаг хогийн сав, давсан урлал, дунд ангийнхны цүнхний багц, хуруу хүүхэлдэй, бага ангийнхны шидэт ундаа төсөлд тулгуурладаг. Төслийн энтпренершипийн зөвлөх Э.Бат-Орших “Багш, ажилтнууд энэхүү төслийг богино хугацааны түр ажил гэж харахаас илүү, суралцагчдын суралцах, багш нарын ажиллах орчинг сайжруулах боломж хэмээн хичээж, хичээлийн хөтөлбөртэй уялдуулан илүү сонирхолтой болгох талд анхаарч байгаа нь маш чухал” гэж яриу.

Энэхүү амжилтын түүхэнд сурагчдын багийн ажиллагаа, идэвх оролцоо, сургууль дээрх үйлдвэрлэлээ сургалтын хөтөлбөртэйгээ уялдуулсан сонирхолтой хийгээд бүтээлч шийдлийн талаар жишээ татан өгүүлээ. Сонирхолтой, туршлага болохуйц, санаа авахуйц байсан биз ээ.

has enhanced their interest in their studies. They are gaining a financial education at an early age and developing strong teamwork skills. By incorporating real-life examples from production into their lessons, students’ active learning participation has increased significantly. They have a clear understanding of the products they produce, how much they pack, and how many they sell each day. Using familiar examples in lessons has proven to be both more interesting and effective.

The school-based enterprise, “Child Producers”, at Kharkhorin soum secondary school No. 2, in Uvurkhangai province, is built on subgrant projects such as: radio electronics by high school students, smart trash cans, salt dough crafts, tote bags made by middle school students, finger toys, and a magic drink project by younger students.

“It is crucial that teachers and staff, instead of viewing this project as a short-term initiative, focus on enhancing the learning environment for students and the working environment for teachers. They should align it with the curriculum and make it more engaging,” said E. Bat-Orshikh, the project’s entrepreneurship consultant. This success story is a testament to the teamwork, active participation, and innovative solutions that integrated production with the school curriculum. It was engaging, educational, and truly inspiring.

Published in 2024

2024 онд хэвлэгдсэн





## ЭРГЭХ ХОЛБООГ БЭХЖҮҮЛЭГЧ

### REBUILDING CONNECTIONS: PATHWAYS FOR GROWTH AND EMPOWERMENT

Орон нутагт хэрэгжиж буй төсөл бүр өөр зорилготой, өөрийн үнэт зүйлстэй бөгөөд түүнийгээ дагаж нийгмийн сэтгэл зүй, иргэдийн оролцоо дэмжлэг ч өөр байдаг. Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал М.Энэбиш Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн аймгийн зөвлөлийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан гишүүн юм.

Тэрээр, төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулж, үр дүнтэй, зорилгодоо нийцэж, цаг хугацаандаа үргэлжилж байгаа эсэх болон санхүүжилт авсан багуудын худалдан авалтад хяналт тавьж, нийгэм, хувь хүний хөгжилд хувь нэмэр оруулахыг хичээн ажилладаг. Мөн хүүхэд, залуусыг төсөл хэрэгжүүлэх зургаан сарын хугацаанд багуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, төслийн хэрэгжилтийн явцад юу анхаарах талаар санал бодлоо солилцдог аж. М.Энэбиш хариуцсан долоон бичил төслийнхөө 28 хүүхэд, залууст байнга зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна.

“Төслийн Аймгийн зөвлөлийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн гэхээр хүүхдүүд сүрдэж, чөлөөтэй ярьж чадахгүй, асуултад үнэн зөвөөр хариулахгүй байх нь бий. Тиймээс аль болох илэн далангүй байж, хүүхдүүдийн сонирхдог сэдвээр нөхөрсөгөөр ярилцахыг хичээдэг. Ингэснээр хүүхдүүд илүү нээлттэй байж чаддаг. Хүүхдүүдэд зааж зааварчлахаас илүү, тэднийг сонсох чухал гэж боддог. Үйл ажиллагаандаа анхаарах, ямар

Each project implemented in a local area has its own unique goals and values, which in turn, influence social psychology, citizen participation, and support. M. Enebish, Director of the Lifelong Learning Center in Sukhbaatar province, serves as the Monitoring and Evaluation focal point for the Project Aimag Level Counsel (ALC) of Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project.

She monitors the implementation of project activities, ensuring they are effective, on target, and completed on time. She also oversees the procurement process for teams that have received funding and works to contribute to both social and personal development. Throughout the six months of project implementation, M. Enebish organized meetings and interviews with the teams to exchange ideas and insights on key considerations for successful project execution. Additionally, she regularly provides advice and support to the 28 children and youth involved in the seven subgrant projects she oversees.

It is common for children to feel intimidated, reluctant to speak freely, or hesitant to answer truthfully when they learn that she is the Monitoring and Evaluation focal point. To address this, she makes an effort to be as open as possible, engaging in friendly conversations about topics that interest the children. This approach creates an environment where the children feel more comfortable and open.

“I believe it’s more important to listen to chil-



дутагдал байна вэ, түүнийг хэрхэн засаж, цаашид амжилттай ажиллах вэ гэхчлэн хэлэлцүүлэг өрнүүлж, шийдлийг өөрсдөөр нь гаргуулахыг хичээдэг. Энэ бол ирээдүйд ажлаа төлөвлөдөг, асуудлаа тодорхойлдог, шийдэл олдог, хариуцлага хүлээж чаддаг жинхэнэ энтрепренер хүн болох чухал алхам” хэмээн М.Энэбиш өгүүлж байна. Тэрээр, хүүхдүүдтэйгээ багш шавь, найз нөхрийн хэмжээнд дотно танилцаж, төслийнх нь тухай байнга ярилцан, бусдад сурталчилж, байгууллага, хүмүүстэй холбох зэргээр байнгын эргэх холбоотой ажилладаг.

Бичил төсөл хэрэгжүүлж байгаа хүүхэд, залуусын бүтээгдэхүүн, үйл ажиллагааг үе тэнгийнхэнд нь түгээн дэлгэрүүлж, бусад хүүхдийг ч мөн мөрөөдлөө зорилго болгоход уриалдаг юм. Түүний өөр нэг үүрэг бол “Бичил төслийн шалгаруулалт”-ын комиссын гишүүнээр ажиллах. Бичил төслийн шалгаруулах шатнаас эхлэн, төслөө хэрэгжүүлж дуусах хүртэл нь хүүхэд, залуустай хамтардаг гэсэн үг. Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт зургаан удаагийн бичил төслийн шалгаруулалт

dren than to simply give instructions. We encourage them to reflect on their actions, discuss any mistakes, explore ways to correct them, and think about how to work more effectively in the future. By doing this, we empower them to find their own solutions. This is a crucial step toward becoming a true entrepreneur—someone who can plan their future, identify challenges, find solutions, and take responsibility,” says M. Enebish.

She works closely with her children, building connections as both a teacher and a friend. She actively engages in discussions about their projects, champions their work, and connects them with relevant organizations and individuals. By promoting the products and initiatives of children and youth involved in subgrant projects to their peers, she inspires others to pursue their dreams and turn them into achievable goals.

Another of her responsibilities is serving as a member of the Subgrant Project Selection Commission, where she supports children and youth from the project selection stage

зохион байгуулж, 435 хүүхэд, залуус 98 бичил төсөл бичиж оролцсоноос М.Энэбиш таван удаагийн шалгаруулалтад 382 хүүхэд, залуусын 84 бичил төсөлд шүүгчээр ажилласан байна.

Бичил төслийн шалгаруулалтын зорилго нь хүүхэд, залууст сургалтаас олж авсан хувь хүний үр чадвар, энтрепренершипийн мэдлэгээ практикт туршиж хэрэгжүүлэх (багаар ажиллах, багийн гишүүд болон санхүүжүүлэгч байгууллагын өмнө үүрэг хариуцлага хүлээж сурах, эрсдэл тооцоолох, төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, шинийг санаачилж бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлэх г.м) тэр дундаа нөөц бололцоог танин нээж, орон нутагтаа болон сургуульдаа хэрэгцээ шаардлагатай, хэрэгжүүлж болохуйц шинэлэг бизнесийн санаа хөгжүүлэхэд оршдог.

М.Энэбиш “Орон нутагт хэрэгжиж буй ийм сайхан төслийн нэг хэсэг болж, хүүхэд, залуусынхаа хөгжилд дэм тус болж, нутаг орныхоо ирээдүйд хувь нэмэр оруулж байгаадаа их баяртай байна. Зөвхөн хүүхэд, залуусын хөгжил, төлөвшилд хувь нэмрээ оруулаад зогсохгүй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хэрэгжилтийн явцад маш их зүйлийг шинээр сурч хөгжиж, туршлага хуримтлуулж, урам зоригтой ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг. Төсөл хэрэгжүүлэгч Хүүхдийг Ивээх Сан болон төслийн багийн хамт олонд гүн талархал илэрхийлье” гэсэн юм.

through to completion. In Sukhbaatar province, six subgrant project competitions were held, with 435 children and youth submitting 98 project proposals. Enebish participated as a judge in five of these competitions, reviewing 84 proposals submitted by 382 children and youth.

The goal of the project proposal selection is to help young people apply the personal skills and entrepreneurial knowledge they've gained from training, while identifying potential resources and developing innovative business ideas that can be implemented in their communities and schools. This includes teamwork, taking responsibility toward team members and funding organizations, assessing risks, managing projects within budgets and plans, and fostering creative and innovative thinking.

Enebish stated, “I am truly happy to be part of such a wonderful project being implemented in the region. It's an honor to support the development of our children and youth and contribute to the future of our country. Through my involvement, I am not only contributing to their development and growth but also learning new things, gaining valuable experience, and working with dedication on the ‘Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia’ project. I would like to express my heartfelt gratitude to Save the Children and the project team.”

Published in 2024



Төслийн оролцоо, дэмжлэгийн амжилтын түүхийг монгол хэлээр уншина уу.

Read the success story of the project cooperation and support in Mongolian.

## ШИНИЙГ ЭРЭЛХИЙЛЖ, ЗОРИЛГОДОО ТЭМҮҮЛЭГЧ

### SEEKING NEW OPPORTUNITIES AND ACHIEVING GOALS

“Ер нь залуу хүн оролдож үзэх зоригтой л байвал хийх зүйл олон бий. Би ямагт шинийг эрэлхийлж, тэмцэж, ялах хүсэл тэмүүлэлтэй болсон” гэж ярих энэ бүсгүйг

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Насан туршийн боловсролын төв (НТБТ)-ийн багш, “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн үр шимийг хүртэгч, “Sumber golden beetle” төслийн багийн гишүүн Г.Энхжин гэдэг.

Тэрээр, нөхөр С.Анххүслэнгийн хамт ESEL сургалтад хамрагдаж, хувь хүн болон амьдралд нь ямар эерэг өөрчлөлт гарсан тухайгаа ярьсан юм. “Сүмбэр сумын НТБТ-ийн сургалтын менежер Х.Амаржаргал бидэнд сургалтын талаар анх хэлсэн юм. Нөхөр бид хоёр 2021 оны хаврын элсэлтээр суралцаж төгссөн. Сургалт сонирхолтой, мэддэг юм шиг хэрнээ мэддэггүй олон зүйлсийг амьдралд ойрхон жишээгээр баяжуулан зааж байлаа.



“There are many things a young person can do if they have the courage to try. I have developed a passion for exploring new opportunities, for fighting, and for succeeding.” The woman who said this is G. Enkhjin, a teacher at the Lifelong Learning Center (LLC) in Sumber soum, Gobisumber province, a beneficiary of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, and a member of the “Sumber Golden Beetle” project team. Enkhjin, alongside her husband S. Ankhhuslen, participated in the ESEL training and shared how it positively impacted her personal development and life. “The training manager at the Lifelong Learning Center in Sumber soum, Kh. Amarjargal, introduced us to the program. My husband and I enrolled in the spring of 2021 and successfully completed the course. It was



Бид хоёр сургалтаа таслалгүй, идэвхтэй суралцаж, ингэснээр бидний амьдралын эерэг өөрчлөлтүүд эхэлсэн” хэмээн гэр бүлийн хоёр ярилаа.

Г.Энхжин ESEL сургалтад хамрагдахаас өмнө Говьсүмбэр аймагт шилжин ирээд удаагүй байв. Анхны хүүхдээ төрүүлж, сургуулиасаа чөлөө авч, гэртээ сууж байсан цаг тул найз нөхдийн хүрээлэл бага, өөртөө итгэх итгэл сул, бүсдад өөрийгөө илэрхийлэх, тэр дундаа шинийг эрэлхийлж, оролдож үзэх оролдлого нь буурсан байв. Харин ESEL сургалтын үеэр шинэ хүмүүстэй танилцаж, найз нөхөдтэй болсон байна. Үе тэнгийн олон залуусаас суралцаж, өөрийгөө олж таних, илэрхийлэх, багаар ажиллах зэрэг маш олон чадварт суралцжээ. Түүний хувьд сургалтаа төгсөх үед нялх хүүхэдтэй байсан тул төсөл бичих, судалгаа хийхэд цаг гарсангүй. Харин ESEL анги төгсөн “Sumber Golden beetle” төслийн багийн охидоос ажиллах хүч дутагдаж байгаа тул хамтран ажиллах санал тавьснаар энэ багт нэгдэж, мэдлэг, ур чадвараа зориулах болжээ. Дараагийн боломж түүнд 2023 оны өвөл ирэв. НТБТ-ийн захирал Г.Баасансүрэн Г.Энхжинг аймгийн НТБТ-д амьдрах ухааны багшаар ажиллах санал тавьсныг хүлээн авчээ. Энэ нь түүнд болон төслийн багийн гишүүдэд томоохон дэмжлэг болсон байна.

Төсөл нь амжилттай хэрэгжих тусам багийн гишүүд илүү урамшин, гэр бүлийн гишүүдээ үйл ажиллагаандаа татан оролцуулж, төрөл бүрийн самбар, тоглоом, эсгий урлал хийж, захиалгаа хугацаанд нь

a truly engaging experience, based on real-life examples, teaching us valuable lessons that we thought we already knew. We both actively participated without interruption, and the training led to noticeable, positive changes in our lives”, the couple shared.

Before attending the ESEL training, Enkhjin had recently moved to Gobisumber province. After giving birth to her first child, she took a leave of absence from her teaching job and stayed at home. During this time, her social circle shrank, she faced a decline in self-confidence and struggled to express herself. Her once strong desire to explore and try new things had also diminished.

Through the ESEL program, she met new people, made lasting friendships, and acquired valuable skills. She learned from her peers, rediscovered her inner strength, gained confidence in self-expression, and developed the ability to work effectively in a team.

At the time of her graduation, Enkhjin had just had a baby, so she didn't have the time to write a project proposal or conduct research. However, the girls from the “Sumber Golden Beetle” project team, who had also graduated from the ESEL program, reached out with a proposal to collaborate. Their team was short-staffed, and they invited Enkhjin to join them. Embracing the opportunity, Enkhjin became a part of the project team, dedicating her knowledge and skills fully to the work.

Her next opportunity came in the winter of 2023 when G. Baasansuren, the director of the Lifelong Learning Center, offered Enkhjin a position as a life skills teacher at the provincial Lifelong Learning Center. This new role provided significant support for her personal development while also offering valuable assistance to the project team members.

As the project gained success, the enthusiasm of the team members grew. They became more engaged and started involving

амжуулахын тулд гэрээрээ хүртэл ажиллах болжээ. Ингэснээр “Sumber Golden beetle” багийн төсөл орон нутагтаа танигдаж, олон ч захиалагчтай болсон байна.

Г.Энхжин “Энэ төсөл бидний ажил амьдралд ихээхэн тус болсон. Бид цагаа төлөвлөж, ажлаа зохион байгуулж сурсан. Гүйцэтгэлийнхээ чанарт анхаарч, захиалагч нартай хамтран ажиллаж байна” хэмээн ярилаа.

Тэрээр, ESEL сургалтад сууж, багаараа төсөл хэрэгжүүлж, өөрийгөө таньж мэдсэнээр амьдралд нь олон боломж нээгджээ. Үүний нэг баталгаа нь тэрээр аймгийнхаа НТБТ-ийн багш болсон явдал юм.

2024 онд хэвлэгдсэн

their family members in the work. Together, they created various boards, toys, and felt products, even working from home to ensure timely delivery of orders. Thanks to their collective efforts, the “Sumber Golden Beetle” project not only gained local recognition, but also attracted a growing customer base.

G. Enkhjin reflects, “This project has been incredibly beneficial, both in our work and personal lives. We've learned how to manage our time better and organize our tasks more efficiently. We are now collaborating with our clients to further improve the quality of our products.”

Attending the ESEL training, working on projects with the team, and gaining a deeper understanding of herself opened up numerous opportunities in Enkhjin's life. Becoming a teacher at the Lifelong Learning Center is a testament to this growth.

Published in 2024

## ЗӨВЛӨН ЧИГЛҮҮЛЭГЧ, СЭТГЭЛ ЗҮЙН “ДАСГАЛЖУУЛАГЧ”

### COUNSELOR AND PSYCHOLOGICAL “COACH”

#### Бусдын амжилтын чиглүүлэгч байх түүний хүсэл мөрөөдөл бага наснаас нь эхэлжээ

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд таван аймагт бизнес көүч ажиллаж байна. Тэдний нэг нь Ч.Нарантуяа юм. Тэрээр, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Насан туршийн суралцахуйн төвийн суралцагчид, аймгийн Политехник коллежийн оюутнууд, энтрепренер клубийн хүүхэд, залуустай хамтран ажиллаж байна. Мөн төслийн аймаг, сумын зөвлөл, ESEL хөтөлбөрийн багш нар болон “Сургуульд суурилсан энтрепрайз” төслийн багийнхантай ч сэтгэл нийлэн ажилладаг.

Амжилтын чиглүүлэгч байх зан төлөв түүнд багаас нь төлөвшжээ. Зах зээлийн хүнд үед төрж, өссөн тэрээр Сүмбэр өртөөний галт тэрэг дамжин бохь ширхэглэн зарж, ажил хөдөлмөрийн амтыг эрт мэдэрч, хүүхэд бүр мөрөөдлөөр дүүрэн байж, мөрөөдөлдөө хүрэхийн тулд хичээж, тэмүүлэх ёстой гэж ухаарсан аж. Тийм ч учир хүүхдүүдийн амжилтыг чиглүүлэх көүчээр ажиллах боломжийг алдсангүй. Ч.Нарантуяа гурван ч дээд сургууль төгсөж, бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалжээ. Ажлын гараагаа Монголд хэрэгжиж

#### Her Dream of Guiding Others to Success Began at an Early Age

As part of the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented by Save the Children, business coaches are working across five provinces. One of these coaches is Ch. Narantuya, who works with secondary school students in the Sumber and Shiveegobi soums of Gobisumber province. She also works with students from the Lifelong Learning Center, the provincial Polytechnic College, and the Entrepreneur Club's youth members. Additionally, Ch. Narantuya collaborates closely with the project's



байсан олон улсын анхны томоохон төслүүдийн нэг “Тогтвортой амьжиргаа-II” төслөөс эхэлжээ. “Мерси кор Монгол” ОУБ-ын орон нутгийн төлөөлөгчөөр ч ажиллаж байв. Эдгээр төслөөс маш ихийг сурч, туршлага хуримтлуулжээ. “Бага байхад хүүхдүүд суудлын галт тэрэгнээс зүүгдэн суугаад хоол зарж, олсон мөнгөө амьдралдаа нэмэрлэдэг байсан. Эрсдэлд орж, хөл гаргүй болох, цаашлаад амь насаа алдах нь ч байлаа. Хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүд хулгай, дээрэм хийж, гэмт хэрэгт уруу татагдаж, буруу замаар орж байлаа. Ийм хүүхдүүдийн эрхийг хамгаалдаг газар, дэмждэг хүн ч байсангүй. Ийм хүнд үеийг бид ардаа орхиж чадсан. Одоо Монголд хүүхдийн эрхийг хамгаалдаг тогтолцоо бүрдэн бэхжиж, хууль эрх зүйн актуудаар баталгаажжээ. Өнөөдөр хүүхдүүд сурч хөгжих бүх нөхцөлөөр хангагдсан байна. Бид харин өсвөр үе, хүүхэд, залуусыг бэлэнчлэх сэтгэлгээнээс холдуулж, бие даах чадамжийг нь нэмэгдүүлэх, практик ур чадварыг олгоход түлхүү анхаарах хэрэгтэй” гэж көүч Ч.Нарантуяа ярилаа

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл” эхнээсээ таалагдсан тул тэрээр бизнес көүч болохоор шийджээ. Энэ төсөл хэдийгээр өсвөр үеийн хүүхэд, залуусын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн боловч, оролцогч талууд зэрэг хөгжиж, харилцан суралцаж, хөгжих боломжтой юм. Бие биеэ хүндэтгэн, бусдыг ойлгож, сонсох, ажлын ачааллаа зөв хуваарилан, багаар ажиллах ур чадвартай болдог онцлогтой.

Төсөл анх бизнес көүчгүй хэрэгжиж эхлэхэд хөдөөгийн алслагдсан сумдад төсөл бичих хандлага бага, аймгийн хэмжээнд ердөө 1-2 төсөл дэмжигдэж байлаа. Харин 2022 оноос зорилтот таван аймагт бизнес көүч ажиллаж эхэлснээс

Aimag and Soum Level Counsels, ESEL program teachers, and the “School-Based Enterprise” project team.

She developed her passion for guiding others to success at an early age. Born and raised during the challenging times of the transition to market economy, she began working at an early age, selling chewing gum at the Sumber train station. This experience instilled in her the value of hard work and the belief that every child should dream big and work tirelessly to achieve those dreams. This is why she seized the opportunity to become a coach, helping guide children toward success.

Ch. Narantuya graduated from three universities and earned a Master's Degree in Business Administration. She began her career with the “Sustainable Livelihoods-II” project, one of the first large international projects implemented in Mongolia. She also served as the local representative of Mercy Corps Mongolia, an international NGO. Through these roles, she gained valuable knowledge and experience. “When I was young, children would cling to the steps of passenger trains to board, selling food to passengers to earn money for their livelihood. It was a dangerous and risky practice, with many children suffering injuries, losing limbs, or even losing their lives. Children from impoverished neighborhoods were often drawn into crimes like theft and robbery, with some even taking a wrong path. There was no organization or individual to protect the rights of these children. Thankfully, we have moved past those difficult times. Today, a system to protect children's rights has been established and strengthened in Mongolia, and is now guaranteed by law. Today, children are provided with all the necessary conditions for learning and development. However, we need to help adolescents, children, and young people reject the “entitlement mentality”, encouraging them to become more independent and equipping them with practical skills,” said coach Narantuya. She decided to become a business coach because she was drawn to the “Entrepreneurship-Focused Socio-Emotional



хойш энэ тоо эрс нэмэгдсэн нь бизнес көүчийн оролцоо чухал гэдгийг харуулсан билээ. Ч.Нарантуяа “Говьсүмбэр аймгийн зорилтот сумдын ерөнхий боловсролын сургуулиудын 8-12 дугаар ангийн бүх сурагчид, Политехник коллежийн оюутнууд, Насан туршийн суралцахуйн төвийн залуусыг хөгжих, бизнес санаа гаргах, санхүүгээ төлөвлөх, багаар хамтран төсөл бичих, хэрэгжүүлэхэд чиглүүлэн, төсөлд оролцох боломж бүрдүүлж, зөвлөж байгаа маань хариуцлагатай ажил шүү” гэж бахархалтай өгүүлэв. Тэрээр, төслийн оролцогч талууд, зөвлөх багш нартай илүү уялдаатай байж, ESEL хөтөлбөрт хамрагдаж буй хүүхэд залууст өөрийгөө таньж мэдэх, цагаа зөв зохистой хуваарилахад тусалж байна. Түүгээр ч зогсохгүй хүүхэд, залуусыг бизнес сэтгэлгээтэй болгох, төсөв санхүүгээ тооцоолж, багаар хамтран ажилладаг, төсөл бичиж, түүнийгээ хамгаалж чаддаг, үр дүнг нь үзэх хүртэл тууштай байх зан чанарт чиглүүлж ажилладаг. 2022 онд Говьсүмбэр аймгийн бизнес көүчээр ажиллаж эхлэхэд анхны төслийн уралдаанд аймгийн хэмжээнд дөрвөн төсөл оролцсоноос нэг нь л тэтгэлэг авч байлаа. Тэгвэл өнөөдөр нийт долоон удаагийн тэтгэлэгт хөтөлбөрөөр 58 төсөл дэмжигдэн санхүүжилт авч, амжилттай хэрэгжиж байна.

Энэ амжилтад бизнес көүч Ч.Нарантуяагийн үүрэг, оролцоо их байсан нь дамжиггүй. Хүүхдүүд ч урам авч, дараа дараагийн төслийн уралдаанд олон баг оролцох болжээ. Баг бүрийн бизнес санааг шууд хэрэгжүүлэх боломжгүй ч Ч.Нарантуяа оролцогчдынхоо хүсэл тэмүүллийг унтраалгүй, тэдэнд тохирсон, хэрэгжүүлэх боломжтой арга барилаар төслөө өөрчлөх замаар

Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project from the start. While the project focuses on enhancing the capacity of adolescents and young people, it also allows stakeholders to develop, learn, and grow together. What makes this project unique is that it teaches children and young people to respect one another, listen and understand others, organize the work process effectively, and collaborate as a team.

When the project first began, without a business coach, there was little interest in writing projects in remote rural soums, with only 1-2 projects being supported at the provincial level. However, since the business coach started working in the five target provinces in 2022, the number of supported projects has increased dramatically, demonstrating the significance of the business coach's involvement. Narantuya proudly said, “It is a big responsibility to provide guidance to all students in grades 8-12 at general secondary schools in the target soums of Gobisumber province, students at the Polytechnic College, and youth from the Lifelong Learning Center to grow, develop business ideas, plan their finances, implement projects in teams, and participate in project activities.” She works closely with project stakeholders and teachers/counselors to help young people participating in the ESEL program explore their potential and manage their time more effectively. Additionally, she focuses on instilling a business mindset in children and young people, building their skills in budgeting, teamwork, writing and presenting project proposals, and fostering persistence until they see the results of their efforts. When Narantuya began working as a business coach for Gobisumber province in 2022, only four project proposals were submitted for the first subgrant competition, and just one was selected and received a subgrant. Today, 58 projects have been selected, received funding through seven subgrant programs, and are being successfully implemented. There is no doubt that business coach Narantuya played a significant role in this success. The children were also inspired

санхүүжилт авах арга замд чиглүүлж, дасгалжуулж ажилласан байна. Төслийн шалгаруулалтад оролцоход ямар сорилт давж, юу сурах ёстойг ойлгуулж, дэмжлэг аваагүй ч урам хугарахгүй байхаар сэтгэл зүйг нь бэлтгэж байсан аж. Ингэснээр хүүхдүүд уралдаандаа өрсөлдөөнтэй оролцож, санал шүүмжийг оновчтой хүлээн авч, ухарч шантралгүй, төслөө дахин сайжруулахаар тэмүүлдэг болсон юм. Бизнес көүч Ч.Нарантуяа өнөөдрийн байдлаар ESEL сургалтын 1000 гаруй хүүхдэд мэдээлэл, сургалт хийж, төслийн шинэ санаа гаргасан хүүхэд, залуучуудын 115 багтай ажилласнаас 58 баг нь тэтгэлэгт хамрагдсан байна.


Эдгээр 58 төсөл орон нутагтаа 170 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт татаж, амжилттай хэрэгжиж байгаа юм. Мөн “Сургуульд суурилсан энтерпрайз” хэрэгжүүлж буй Сүмбэр сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн бизнес төлөвлөгөө боловсруулах, улирал, жилийн төлөвлөгөө, тайлан гаргахад нь дэмжлэг үзүүлж байна. Хүүхэд насандаа туулсан амьдралын бартаа нь өсвөр үеийнхнийг амжилтад чиглүүлэх көүч болгосон гэж хэлмээр санагдана. Түүний хувьд орон нутагт энтрепренершип, бизнес көүч, менторийн сэтгэлгээг түгээж, ач холбогдлыг нь ойлгуулж чадсан томоохон төслүүдийн анхдагч гэж хамт олон нь үнэлж байдаг юм билээ. Бизнес көүч Ч.Нарантуяа цаашид орон нутагтаа төдийгүй улсын хэмжээнд чадваржсан бизнес зөвлөх, көүчээр ажиллах зорилго тавьжээ.

and are now preparing to participate in the next subgrant competitions by forming many new teams. While not all of the teams' business ideas were implemented, Narantuya did not discourage their enthusiasm. Instead, she coached them on how to modify their project proposals, making them suitable and feasible for securing funding. She helped them understand the challenges they would face, outlined what they needed to learn before participating in the subgrant competition, and prepared their mindset to handle the possibility of not receiving funding without losing motivation. As a result, the children learned to participate competitively, accept feedback effectively, and strive to improve their project proposals without fear of failure. To date, business coach Narantuya has provided information and training to over 1,000 children through the ESEL program and has worked with 115 teams of children and youth who developed new project ideas, 58 of which have received subgrants.

These 58 projects have attracted over 170 million MNT in investment for the local province and are being successfully implemented. She is also supporting the development of business plans, as well as quarterly and annual plans and reports, for the general secondary school in Sumber soum, which is running a “School-Based Enterprise.” The challenges she faced growing up motivated her to become a coach who guides young people toward success. Her colleagues recognize her as a pioneer of major projects that have instilled the spirit of entrepreneurship, business coaching, and mentorship in the community, while also emphasizing their importance. Business coach Narantuya has set a goal to work as a qualified business consultant and coach, not just locally, but on a national scale.

2024 онд хэвлэгдсэн

Published in 2024



## ХӨГЖИЛД ТЭМҮҮЛЭХ УРАМ ЗОРИГ ӨГСӨН “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” ТӨВ

### “DEVELOPMENT GUIDE” CENTER: INSPIRING GROWTH

Завхан аймгийн Тэлмэн сум аймгийн төвөөсөө 120, Улаанбаатар хотоос 880 гаруй км алслагдсан, нийт 2879 хүн амтай, 859 өрхтэй, аймагтаа томоохонд тооцогдоно. Тэлмэн суманд ерөнхий боловсролын нэг сургууль 529 суралцагч, 59 багш, ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл хэрэгжүүлж буй таван аймгийн зорилтот сумдын сургуулиудын дунд “Сургуульд суурилсан энтерпрайз” хэрэгжүүлэх төслийн уралдаан зарлахад Завхан аймгийн зургаан сумын сургууль төслөө ирүүлжээ. Эдгээрээс Тэлмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн “Хөгжлийн хөтөч” хүүхэд залуучуудын цахим сургалтын төв байгуулах төсөл шалгарч 103.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Telmen is a remote soum located in Zavkhan province, 120 kilometers from the provincial capital and over 880 kilometers from Ulaanbaatar. With a population of 2,879 and 859 households, it is the largest soum in the province. Telmen is home to one general secondary school, which serves 529 students and employs 59 teachers and staff.

As part of Save the Children’s “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, a competition was launched for schools in targeted soums across five provinces to implement a “School-Based Enterprise” initiative. Schools from six soums in Zavkhan province submitted project proposals, and among them, the proposal from Telmen soum secondary school to establish the “Development Guide” Center a dedicated e-learning hub for children and youth was selected. This project received a funding award of 103.9

Энэхүү цахим төв нь 2022 оны 11 дүгээр сарын дундуур тоног төхөөрөмжөө хүлээн авч, суурилуулсан, 2023 оны 3 дугаар сард нээлтээ хийн, үйл ажиллагаагаа эхэлжээ. Дунд, ахлах ангийн сурагчид, багш, ажилтнууд энэ төвөөр дамжуулан компьютерийн мэдлэгээ сайжруулж, шинэ тутам программууд дээр ажиллаж сурах, сургалтын үйл ажиллагаандаа цахим технологи ашиглах бүрэн боломжтой болжээ.

“Сургуульд суурилсан энтерпрайз”-ийн энхүү үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөртэй болон гадаад хэл, мэдээллийн технологи, монгол хэл, бичиг зэрэг судлагдахуун бүрийн хичээлтэй холбогдох ажээ. Багш, сурагчид интернэт орчинд компьютер ашиглан бие даалт, дасгал даалгавраа хийх болсон нь алслагдсан сумын сургуульд давуу тал болсон юм. Сургуулиас Б корпусын нэг ангийг уг төсөлд зориулж иж бүрэн тохижуулсан байна. Энэ онд шинэ сургууль ашиглалтад орсон тул тус корпуст зөвхөн “Хөгжлийн хөтөч” төв үргэжлүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа юм. Эдүгээ тус корпусыг “Сургуульд суурилсан энтерпрайз” буюу “ССЭ корпус” гэж товчлон нэрлэж хэвшжээ.

“Хөгжлийн хөтөч” төв өнгөрсөн хугацаанд цээж зураг авах, угаах, өргөмжлөл хийх, компьютерийн анхан шатны сургалт явуулах, бичлэг шторк хийх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2.5 сая гаруй төгрөгийн ашиг олж, давхардсан тоогоор 375 сурагч, 56 багшийг хамруулж, сумын 250 гаруй иргэнд үйлчилсэн байна. “Өсвөрийн сурвалжлагч”, “Чөлөөт индэр” мэтгэлцээний клуб, “Art Studio” гэрэл зургийн клубт суралцагчид өөрсдийн хүсэл сонирхлоороо нэгдэж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээ бэлтгэх, видео шторк хийх, постер зөвлөмжүүд бэлтгэх зэрэг олон төрлийн чадварт суралцаж байна. Ганц ашгийн төлөө бус, төслийн үндсэн зорилтуудын нэг болох суралцагч

million MNT.

The e-center received and installed its equipment in mid-November 2022, officially launching its operations in March 2023. Since then, the center has provided students, teachers, and school staff with the opportunity to enhance their computer skills, explore new software programs, and integrate digital technology into their teaching and learning activities.

The activities of the School-Based Enterprise are closely integrated with the general secondary school curriculum, covering subjects such as foreign languages, information technology, and Mongolian language. Students have access to computers with internet connectivity, enabling them to complete homework and assignments. This provides a significant advantage, particularly for those in remote soums.

The school has fully equipped a classroom in Building B for this project. Since the new school opened this year, the “Development Guide” Center is the only initiative currently operating in the building, which has since been designated as the School-Based Enterprise (SBE) building.

Since the launch of the project, the “Development Guide” Center has generated over 2.5 million MNT in revenue by offering key services such as photo services, certificate layout and design, basic computer skills training, video recording, and the production of video ads. More than 250 residents of the soum comprising 375 students and 56 teachers have benefited from these services.

Students engage in various clubs based on their interests, including the Youth Reporter, Free Platform Debate Club, and Art Studio Photography Club. Through these activities, they gain a wide range of skills, such as managing their free time more effectively, news writing, video ad production, and poster de-



болон багш нарын технологийн мэдлэгийг сайжруулах зорилгоор 6-12 дугаар ангийн 13 бүлгийн 259 суралцагчид мэдээллийн технологийн албан ёсны хичээлийг хуваарийн дагуу энэ төвд явуулж байна. Хурд сайтай сүүлийн үеийн компьютер, ухаалаг дэлгэц ашиглаж хичээллэх нь сурагчдад урам зоригтой, амжилттай суралцах, багш нарт мэргэжлээрээ хөгжих боломж олгожээ.

Боловсролын салбарт хэрэгжүүлж буй “Eduten” математикийн хөтөлбөрт 3-4 дүгээр ангийн 98 сурагч болон “Pearson” англи хэлний хөтөлбөрөөр 147 суралцагч “Хөгжлийн хөтөч” төвд суралцаж байна. ССЭ танхимд жил гаруйн хугацаанд нийт 120 хүүхэд, залуус амжилттай суралцаж, 175 цагийн үндсэн сургалт хичээллэж, орон нутгийн хүүхэд залуусын сурч

sign.

Making a profit is not the only goal of this center. Formal IT lessons are organized according to schedules for 13 groups of 259 students, ranging from grades 6 to 12, with the aim of enhancing the technological skills of both students and teachers—one of the core objectives of the project. Learning in a classroom equipped with fast, modern computers and smart screens motivates both students and teachers to expand their knowledge and skills.

The “Development Guide” Center hosts the Eduten mathematics program for 98 students in grades 3 and 4, as well as the PEARSON English language program for 147 students.

Over the past year, 120 children and youth have successfully participated in the training offered in the SBE classroom. A total of 175

боловсрох, хөгжихөд тус нэмэр болсон ажээ.

“Бидэнд хамгийн сүүлийн үеийн дрон, ухаалаг самбар гэх мэт орчин үеийн техник хэрэгсэл өгсөн Хүүхдийг Ивээх Санд маш их баярладаг. Тэрхүү тоног төхөөрөмжүүдийг ашигтай, бүтээмжтэй ашиглахыг хичээдэг. Мэдээж гамтай хэрэглэвэл, олон жил, олон сурагч, багш нар үр шимийг нь хүртэж, хөгжих болно” гэж эндхийн сурагч, багш нар нэгэн дуугаар хэлж байлаа. Ухаалаг дэлгэц болон өндөр хурдны интернэт, компьютер ашиглан физик, хими, газарзүйн хичээлийн зарим агуулгыг тус танхимд үздэг байхаар төлөвлөж, багш нар ээлжит хичээлийн агуулгаа боловсруулж туршсан байна. 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн тухайлсан сэдвүүдийг тус ангид зааж сургахаар бэлтгэж байна. Бүх анги ийм ухаалаг самбартай болж, ашиглаж чадвал ямар ч хичээлийн агуулгыг хөгжүүлж, суралцагчдад сонирхолтой, бүтээлч байдлаар хичээллэх бүрэн боломжтой гэдгийг багш нар хэлж байлаа.

Хөгжлийн суурь бол системтэй мэдлэг. Системтэй мэдлэгийг ашиглан үр дүнд хүрэх гүүр нь хувь хүний үр чадвар хийгээд хандлага юм. “Хөдөө суманд боловсрол эзэмшсэн ч дэлхийн томоохон их, дээд сургуульд тэнцэж суралцахад “Энтерпренершипд суурилсан хувь хүний үр чадвар хөгжүүлэх” ESEL сургалтад сурсан, бичил төслийн санхүүжилт авч, бизнесээ туршиж хэрэгжүүлэх явцад сурч мэдсэн бүхэн маань надад үнэхээр их хэрэг болсон” гэж Хүүхдийг Ивээх Санд талархлаа дамжуулахыг хүссэн Унгар улсын Будапешт хотын Технологи, эдийн засгийн их сургуулийн оюутан Г.Энххүслэн ч бас Тэлмэн сумын сургуулийн төгсөгч юм. Боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж их бөгөөд үр дүнд нь эх орон маань цэцэглэн хөгжих нь лавтай билээ.

hours of basic training have been organized, making a significant contribution to the education and development of local children and youth.

“We are deeply grateful to Save the Children for providing us with the latest drones and smart boards. We are committed to using these tools in the most effective and productive ways possible. Of course, we will handle these devices with care, and many students and teachers will benefit from this equipment for years to come,” said both students and teachers.

Some physics, chemistry, and geography classes are planned to be held in this classroom, utilizing smart screens, high-speed internet, and computers. Teachers have already developed and tested the content for upcoming sessions and are preparing to teach specific topics in this classroom for the 2024-2025 fall semester. They have noted that if all classrooms were equipped with smart boards like these, they would be able to create lesson content and lead training sessions in a more engaging and creative way.

The foundation of development lies in systematic knowledge, while the bridge to applying that knowledge and achieving tangible results is an individual's soft skills and attitude.

G. Enkhkhuslen, a student at the Budapest University of Technology and Economics in Hungary and a graduate of Telmen School shared, “Although I was educated in a rural soum, everything I learned from attending the ‘Entrepreneurship-Based Personal Skills Development’ ESEL course, receiving a subgrant, testing and implementing my business ideas helped me get accepted into one of the world's top universities. Investment in education is, without a doubt, the cornerstone of our country's development.”



2024 онд хэвлэгдсэн

Published in 2024

## ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛСОН МЕНТОР

### A MENTOR WITH CLEAR GOALS

Г.Энхцоож “Менторын ажил зөв гаргалгааг олоход тусалж, дэмжих, ойлголцох юм. Тиймээс би хүүхэд бүртэй биечлэн уулзаж, шинэ санааг нь анхааралтай сонсож, санаагаа төсөл болгон хөгжүүлэхэд туслаж, урам өгч, итгэл төрүүлэхийг зорилго болгодог” хэмээн ярьж байна.

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн хүрээнд орон нутагт менторын соёлыг түгээж, зорилтот таван аймагт сайн дурын үндсэн дээр менторуудыг бэлтгэсний нэг нь Г.Энхцоож юм. Тэрээр, Ховд аймгийн Зэрэг, Манхан, Мөст, Үенч, Алтай, Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Насан туршийн боловсролын нэгжийн залуус болон Жаргалант сумын Политехник коллежийн оюутнуудад зөвлөн тусалж, хамтран ажиллаж байна. Мөн “Энтрепренер Лийдс” манлайлын хөтөлбөрт “Манлайлал ба илтгэх ур чадварын өртөө”-г хариуцсан сургагч багшаар ажиллаж, пич арга хэмжээнд шүүгчээр оролцон төслийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулдаг юм.

Г.Энхцоож ESEL хөтөлбөрт хамрагдсан сурагчид, бичил төслийн уралдаанд



G. Enkhtsooj says, “The role of a mentor is to help find the right solutions, provide support, and offer understanding. That’s why I make it my goal to meet with each child personally, listen closely to their new ideas, help them turn those ideas into projects, and inspire confidence in them.”

The “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, implemented by Save the Children, has fostered a culture of mentoring within local communities and trained mentors across five target provinces. One such mentor is G. Enkhtsooj.

He mentors students from secondary schools in Zereg, Mankhan, Must, Uyench, Altai, and Bulgan soums in Khovd province, as well as

оролцогч багууд болон санхүүжилт авч төслөө хэрэгжүүлж буй багийн хүүхэд, залуус, багш, эцэг эхчүүд гээд өнгөрсөн гурван жилийн хугацаанд 1800 гаруй хүнд зөвлөн тусалжээ. Бизнес санаагаа хөгжүүлж төсөл бичсэн багуудад пич уралдаанд орохдоо төсөл хэрэгжүүлэх аргаа оновчтой тодорхойлж, багийн гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, ашиг орлогын тооцоолол зэрэг гол мэдээллээ товч бөгөөд бүрэн дүүрэн өгөөрэй гэж зөвлөдөг. “Пич уралдаанд тэнцээгүй хүүхдүүд шантрахгүй, дараагийн удаа яавал тэнцэх бол, юун дээр анхаарах вэ гэж асуудаг. Хүүхдүүд бэрхшээлийг даван туулахыг хичээж байгааг харах сайхан байдаг. Хүүхдүүд ярилцаж өөрсдөө шийдлээ гаргаж ирж байхдаа нүдэнд нь гэрэл асаад урам ороод л ирдэг” гэж Г.Энхцоож ярьж байна. Түүний өгүүлснээр ментор хүн хүүхдийн дээрээс биш дэргэдээс нь харилцаж, нээлттэй харилцаа, итгэлцлийг бий болгох хэрэгтэй аж. Хүүхдүүд түүнийг ах эсвэл багш гэж харахгүйгээр үе тэнгийн юм шиг нээлттэй байж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, бэрхшээл, боломжоо хамтран ярилцаж чадаж байгаа нь түүнд урам өгдөг байна.

Г.Энхцоож “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн талаар “Хүүхдүүд насанд хүрэхэд бүх зүйлс сайхан байснаа гэнэт тооцоолоогүй жижигхэн бэрхшээл тулгарахад өөрийгөө чадваргүй гэж бэрхшээлд бууж өгдөг. Харин энэ төсөлтэй холбогдсон хүүхдүүд их сургууль эсвэл ажлын байранд гарахад, магадгүй бизнес хийхэд гарч

youth from the Lifelong Learning Unit and students from the Polytechnic College in Jargalant soum. Additionally, he serves as a trainer for the “Leadership and Public Speaking Skills Station” under the “Entrepreneur Leads” leadership program and actively supports the project by serving as a judge at the Pitch event.

Over the past three years, he has assisted more than 1,800 individuals, including students participating in the ESEL training program, teams involved in the subgrant competition, as well as children, youth, teachers, and parents of team members who received subgrants to implement their projects.

He advises teams that have developed their business ideas into project proposals to present key information, such as the project implementation methodology, team members’ responsibilities, and income estimates, clearly and concisely during their presentation at the Pitch Competition.

“The children who don’t pass the Pitch Competition don’t get discouraged. Instead, they ask how they can improve for next time and what they should focus on. It shows their determination to overcome challenges, and that’s motivating to see. When the children speak and come up with their own solutions, it lights up their eyes and inspires them even more,” says G. Enkhtsooj.

Enkhtsooj believes that a mentor should engage with children on equal terms, fostering open relationships built on trust. He is encouraged by the fact that the children, seeing him not as an older brother or teacher but as a peer, feel comfortable sharing their opinions and discussing their challenges and opportunities freely.



ирдэг боломжууд, бэрхшээлүүдийг ESEL сургалтад хамрагдаж, сургуульд суралцаж байхдаа мэдэж, бэрхшээлээ даван туулах, боломжуудыг өөртөө ашиглах чадварууд бий болгож байна. Энэ мэдлэг, ур чадварыг энэ төсөл хүүхдийн сурлагын түвшин, хөгжлийн онцлогийг үл харгалзан хүртээмжтэй олгож байгаа нь миний ментороор ажиллах гол шалтгаан байсан” гэлээ.

Хүүхэд, залуус “Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх” ESEL сургалтад сууж эхэлмэгц хамтдаа ярилцдаг, санаагаа хөгжүүлдэг, хэрэгжүүлдэг, хамтдаа боломжуудаа атгаж бэрхшээлээ давдаг болдог. Энэ нь багаар ажиллах чадвар, үнэнч нөхөрлөлийг бий болгож, хүүхэд насны гэгээн, жаргалтай дурсамжуудынх нь нэгийг бүтээж байгаа юм.

“Би ментор болсноор өсвөр үеийнхэн, хүүхэд залуучуудтай ажиллах ур чадвартай болсон. ESEL сургалтын төгсөгч хүүхэд, залуучуудад ментор гэж дуудуулж байгаагийн хувьд би зөв хүн байх ёстой, хүүхдэд үлгэрлэх ёстой гэж боддог. Тэгэж ч хичээдэг юм. Энэ ажил маань намайг хувь хүний болон мэдлэг, мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжүүлж, тэмүүлэх хүсэл зорилготой болгосон” гэж нэмж хэлсэн.

Г.Энхцоож “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн ерөнхий зохицуулагч бөгөөд Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, хөгжлийн газраас Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран явуулсан “Хувь хүний хөгжлийн цогц сургалт”-ын сургагч багш юм.

Enkhtsooj spoke about the “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project, saying, “When children reach adulthood, they may feel like everything is going well, but when they face unexpected small challenges, they suddenly feel incompetent and give up. However, children involved in this project are learning, through ESEL training, about the opportunities and challenges they will encounter in university, employment, or starting a business. They are also developing the skills to overcome these challenges and seize new opportunities. The main reason I chose to work as a mentor is that this project makes these vital skills and knowledge accessible to children, regardless of their academic background or developmental characteristics.”

Since the children and youth began attending ESEL training, they started talking to each other, developing ideas together, grasping new opportunities, and overcoming challenges. This fosters teamwork, builds strong friendships, and creates some of the brightest and happiest memories of their childhood.

G. Enkhtsooj added, “Becoming a mentor has equipped me with the skills to work with teenagers and young people. As an ESEL mentor, I must be a positive role model for the children, and I work hard to achieve that. This role has given me the desire and motivation to continuously develop myself personally, professionally, and academically.”

G. Enkhtsooj is the general coordinator of the “Let’s Live Happily in Our Khashaa” project and a trainer for the “Comprehensive Personal Development Training” program, conducted by the Khovd Province Department of Family, Child and Youth Development in

Тэрээр, өмнө нь хүүхэд, залуустай ажиллаж байсан туршлагагүй байсан бол төслийн ментор болсноор өсвөр үеийн сурагчид, залуустай хамтран ажиллаж арвин туршлага хуримтлуулжээ.

2024 оны 8 дугаар сарын байдлаар Ховд аймгийн зорилтот сумдад 1912 хүүхэд, залуус ESEL сургалтад хамрагдаж, тэднээс 343 хүүхэд, залуус 229.5 сая төгрөгийн санхүүжилт бүхий 86 бичил төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

2024 онд хэвлэгдсэн

collaboration with the Youth Development Center. Although he had no prior experience working with children and youth, becoming a mentor for the project allowed him to gain extensive knowledge and experience working with teenage students and young adults.

As of August 2024, 1,912 children and youth in targeted soums of Khovd province have participated in ESEL training. Of these, 343 children and youth are successfully implementing 86 subgrant projects with a total funding of 229.5 million MNT.

Published in 2024

## ТАЛАРХАЛ

Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламжаар “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл 2019-2025 онд амжилттай хэрэгжиж дууслаа. Энэхүү төслийн амжилт, ололт, туршлагыг өгүүлсэн олон түүх хэвлэгдэж, санхүүжүүлэгчид, зорилтот бүлэг, хамтрагчид болон нийтэд хүрсэн юм. Эдгээр амжилтын түүхийг хамтдаа бичилцэж, хувь нэмэр оруулан, төслөө амжилттай хэрэгжүүлсэн багийн үе үеийн гишүүдэд гүн талархал илэрхийлье.

### **Төслийн менежер:**

Ё.Нямдаваа

### **Улаанбаатар хот дахь төслийн баг:**

Т.Гантуяа

Э.Уянга

Н.Үүрийнцолмон

С.Загдрагчаа

Т.Гантунгалаг

Л.Лхагвасүрэн

М.Баянзүл

В.Гэрэлмаа

### **Орон нутаг дахь төслийн баг:**

Г.Батцэцэг

П.Дөлгөөн

П.Бямбазаяа

Ө.Марал

Б.Шүрэнчимэг

Б.Мягмарсүрэн

М.Хулан

Н.Баасанжав

Н.Бадамцэцэг

Б.Ууганбаяр

С.Хишигтогтох

Д. Дариймаа

А.Энхтуул

## ACKNOWLEDGEMENT

The “Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills for the Most Vulnerable Youth in Rural Mongolia” project has been successfully implemented with a grant by Japanese Social Development Fund, World Bank Trust Fund from 2019 to 2025. Throughout its duration, numerous success stories, achievements, and impactful experiences have been shared and disseminated to donors, target groups, partners, and the public. We would like to extend our heartfelt gratitude to all team members, past and present, whose dedication and efforts have made these accomplishments possible and ensured the project's success.

### **Project Manager:**

Yo. Nyamdavaa

### **Project Team in Ulaanbaatar:**

T. Gantuya

E. Uyanga

N. Uuriintsolmon

S. Zagdragchaa

T. Gantungalag

L. Lkhagvasuren

M. Bayanzul

V. Gerelmaa

### **Project Team in the Local Areas:**

G. Battsetseg

P. Dulguun

P. Byambazaya

U. Maral

B. Shurenchimeg

B. Myagmarsuren

M. Khulan

N. Baasanjav

N. Badamtsetseg

B. Uuganbayar

S. Khishigtogtokh

D. Dariimaa

A. Enkhtuul





Save the Children

МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

SAVE THE CHILDREN IN MONGOLIA

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона  
төвийн 4-р давхар

☎ +976+11-329365, 11329371  
ISBN дугаар: 978-9919-9209-5-1

🏠 Ulaanbaatar city, Chingeltei district, 1st khoroo, 4th floor of  
Arizona Center

☎ +976-11-329365, 11329371  
ISBN: 978-9919-9209-5-1



🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

📷 HairaarUlgerley